



ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ



ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ

УЛААНБААТАР ХОТ
2023 он

Захиалагч	Гүйцэтгэгч
<p>Монгол Улсын Засгийн газар</p> <p>Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба</p> <p>Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллага</p> <p>Азийн сан</p> <p>“Хүйсийн тэгш эрх төв” ТББ</p>	<p>“Хөгжлийн эрх зүйн төв” ТББ</p>

Энэхүү судалгааны тайланг Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн болно. Энд дурдагдсан үзэл бодол, үр дүн, мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын болон Азийн сангийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

Хэрэв та бүхэн судалгааны тайланд санал хүсэлт илгээх бол доорх хаягаар бидэнтэй холбогдоорой.

Монгол Улс, Улаанбаатар хот 211238
 Шуудангийн хайрцаг-321, Утас/факс: 976-11-311512
 Итгэлийн утас: 1800-1903
 Нүүр хуудас: Mongolia Gender Equality Center
 И-мэйл: gendereqcen@gmail.com
info@stoptrafficking.mn
 Вэб хуудас: www.stoptrafficking.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	6
ӨМНӨХ ҮГ	7
УДИРТГАЛ	8
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	9
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	9
1.2. Үнэлгээ хийх хүрээ	10
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	12
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	13
1.5. Мэдээлэл цуглуулах арга	15
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	15
2.1. Статистик, тоон мэдээ цуглуулах	15
2.2. Чанарын судалгаа хийх	16
2.3. Баримт бичгийн дүн шинжилгээ хийх	17
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	21
3.1. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хууль тогтоомж ба олон улсын эрх зүйн эх сурвалж	21
3.2. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт	34
3.3. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны арга хэлбэр, түүний хэрэгжилт	61
3.4. Хүн худалдаалах гэмт хэргийн статистик тоон мэдээлэл	66
ДҮГНЭЛТ	79
ЗӨВЛӨМЖ	84
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	89

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ГХЯ	Гадаад харилцааны яам
ГХХтХ	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль
ГХУСАЗЗАА	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба
ДЗМОУБ	Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллага
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИТС	Иргэдэд туслах сан
КОНВЕНЦ	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц
МУ	Монгол Улс
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ЛГБТ	Лесби, гомо, бисексуал, трансжэндэр
ОУБ	Олон улсын байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
ПРОТОКОЛ	Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай нэмэлт протокол
ТББ	Төрийн бус байгууллага
УЕП	Улсын ерөнхий прокурор
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ҮДЗБГХ	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв ТББ
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХХТтХ	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭСЯ	Элчин сайдын яам

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Үнэлгээ хийх хүрээ	11
Хүснэгт 2.	Үнэлгээний шалгуур үзүүлэлт	12
Хүснэгт 3.	Үнэлгээний харьцуулах хэлбэр	13
Хүснэгт 4.	Судалгаанд оролцогчид (хүйсээр)	16
Хүснэгт 5.	ХХТтХ-ийн Төрийн захиргааны төв байгууллагуудын хуулиар хүлээсэн бүрэн эрхийн хэрэгжилт	34
Хүснэгт 6.	Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх 2017-2021 оны үйл ажиллагааны тайлангийн биелэлт	60
Хүснэгт 7.	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хэрэг, шүүхээр шийдвэрлэгдсэн байдал	66
Хүснэгт 8.	Хүн худалдаалах гэмт хэрэг, шүүхээр шийдвэрлэгдсэн байдал /2013-2022 он/	68
Хүснэгт 9.	Биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн байдал /2013-2017 он/	72
Хүснэгт 10.	Бэлгийн мөлжлөгийн хэрэг, шүүхээр шийдвэрлэгдсэн байдал /2017-2022 он/	74
Хүснэгт 11.	Биеэ үнэлэхийг зохион байгуулах хэрэг, шүүхээр шийдвэрлэгдсэн байдал /2020-2022 он/	76
Хүснэгт 12.	Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн мэдээлэл /2018-2022 он/	78
Хүснэгт 13.	Үнэлгээний хураангуй	79

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.	Бүртгэгдсэн болон хянан шийдвэрлэсэн хэрэг	15
График 2.	Хүн худалдаалах гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын хугацаа /2013-2016 он/	71
График 3.	Хүн худалдаалах гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын хугацаа /2017-2022 он/	71

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс 2008 онд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний нэмэлт болох Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд нэгдэн орсон. Конвенцын хэрэгжилтийг хангах, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хүчин чармайлт гаргаж, 2012 онд Улсын Их Хурлаас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг баталж, өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийхээр зохицуулсан. Ийнхүү хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийхдээ тухайн хуулийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хуульд бүхэлд нь эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно гэж заасан.

2020 онд Монгол Улсын Засгийн газар нь Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаменттай хамтран “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ”-г байгуулсан. Энэ хүрээнд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээ хийх, улмаар хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй ололтыг бататгах, хийдэл, давхардлыг арилгах, мөн хуулийг даган гарсан журам, стандартын хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, түүнд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг илрүүлэх, цаашид анхаарах асуудлыг тодорхойлох, улмаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр бодлогын дүгнэлт, санал, зөвлөмжийг гарган оролцогч талуудад хүргүүлэх зорилгоор энэхүү үнэлгээг хийж гүйцэтгүүллээ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг бүхэлд нь үнэлэхэд, зорилгод хүрсэн байдал 93.8 хувь, практикт нийцэж байгаа байдал нь 31.3 хувь, хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь 6.3 хувийн хэрэгжилттэй байгаа үр дүн гарсан. Иймд цаашид хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчинг сайжруулах, боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх, батлагдах шаардлагатай журмуудын төслийг боловсруулах, дахин шинэчлэх, батлуулах ажлыг төлөвлөн ажиллаж байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээ хийсэн Зөвлөх баг буюу Хөгжлийн эрх зүйн төвийн хамт олонд баярлалаа.

Мөн үнэлгээний тайлантай холбоотой бүхий л зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн Хүйсийн тэгш эрх төвийн баг, хамт олонд талархал илэрхийлье.

Л.НЯМГЭРЭЛ

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

УДИРТГАЛ

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт 2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр “Аргачлал батлах тухай” тогтоолын 6 дугаар хавсралтад заасан **“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”**¹ /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

Хууль тогтоомжийн тухай хуулиар Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийдэг бөгөөд шаардлагатай тохиолдолд үүнээс өмнө ч хийнэ. Харин үнэлгээг хийхдээ тухайн хуулийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хуульд бүхэлд нь эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно² гэж заасан.

“Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль”-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгаа нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой бөгөөд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн болно.

¹ Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Аргачлал батлах тухай (2019)

² Хууль тогтоомжийн тухай хууль (2015), 51 дүгээр зүйлийн 51.3 дахь заалт.

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц” /цаашид “Конвенц” гэх/ нь Бүгд Найрамдах Итали Улсын Палермо хотноо 2000 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдаж, уг Конвенц болон түүний нэмэлт “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол” /цаашид “Протокол” гэх/-д Монгол Улс 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсон³ байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль /цаашид “ХХТХ” гэх/ нь 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр батлагдаж, 2012, 2013, 2015, 2016, 2017, 2018, 2019, 2020, 2021, 2022 болон 2023 онд тус бүр нэмэлт өөрчлөлт орж байсан боловч өнөөдрийг хүртэл нэг ч удаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан байдаг.

Монгол Улсад 2013-2023 онд бүртгэгдсэн хүн худалдаалах гэмт хэрэг /цаашид “ХХГХ” гэх/ болон шүүхээр шийдэгдсэн хэргийн харьцаа хэт ялгаатай /бүртгэгдсэн 91, шүүхээр шийдсэн 30/ байгаа нь судлаач, мэргэжилтнүүд болон энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд оролцогч талуудын анхаарлыг ихээхэн татаж байгаа юм. Мөн АНУ-ын Төрийн Департаментаас жил болгон гаргадаг “Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай” 2022 оны тайланд “Монгол Улсын Засгийн газар хүн худалдаалах гэмт хэргийг таслан зогсооход тавигдах суурь шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байгаа хэдий ч энэ чиглэлээр ихээхэн хүчин чармайлт гаргаж өөрөөс гаргах ерөнхий

³ Монгол Улсын хууль, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд нэгдэн орсныг соёрхон батлах тухай (2008).

хүчин чармайлалтаа нэмэгдүүлсэн учраас Монгол Улс II шатлалд⁴ хэвээр үлдсэн”⁵ талаар илтгэсэн.

Хурдтай хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн өнөөгийн байдал, ХХГХ-тэй тэмцэх ажиллагаанд оролцогч талуудын илэрхийлж буй байр суурь зэргийг үндэслэн энэхүү ХХТХ-ийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх цаг болсон байна. ХХТХ-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийгдсэнээр энэ хууль бодитой хэрэгжиж, зорилтоо хангаж байгаа эсэх, нийгэмд гарч байгаа хүн худалдаалахтай холбоотой асуудал, бэрхшээлийг шийдвэрлэж чадаж байгаа эсэх, цаашид хуулийн үр нөлөөг сайжруулахын тулд хэрхэн боловсронгуй болгох шаардлагатайг тодорхойлох юм.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “Үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасныг удирдлага болгов. Улмаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх хүрээг дараах байдлаар тогтоолоо.

⁴ Хүн худалдаалахтай тэмцэх ажлыг хэрэгжүүлдэг улс орнуудыг 4 зэрэглэл буюу шатлалд ангилдаг. I шатлал: Хүний наймааны тухай хуулийн хамгийн доод стандартыг бүрэн дагаж мөрддөг улс орнууд.

II шатлал: Хамгийн суурь стандартыг бүрэн дагаж мөрддөггүй боловч дагаж мөрдөхийн тулд ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа улс орнууд. /Монгол Улс энэ ангилалд 2019 оноос одоог хүртэл хамаарч байна/.

III шатлал (Анхаарал татаж буй орон): Хохирогчдын тоо их буюу мэдэгдэхүйц нэмэгдэж байгаа тул II түвшний орнууд тусгай хяналт шаарддаг, хүн худалдаалахтай тэмцэх хүчин чармайлт нэмэгдэж байгааг нотлох баримтыг гаргаж өгөхгүй байх, эсвэл дараагийн жилийн хугацаанд авах үүрэг амлалтад үндэслэх. /Монгол Улс 2018 онд энэ шатлалд хамаарч байв. 2019 онд өмнөх жилтэй харьцуулахад хүний наймааг таслан зогсоох төрийн хүчин чармайлт нэмэгдсэн тул зэрэглэл ахиулж дээрх 2-р шатлалд оруулсан/.

IV шатлал: Хамгийн бага стандартыг хангадаггүй, дагаж мөрдөхийн тулд дорвитой хүчин чармайлт гаргадаггүй улс орнууд. Энэ түвшний улс орнууд хүмүүнлэгийн болон худалдааны бус хориг арга хэмжээнд өртөж болзошгүй. [What Do the Tiers of the Trafficking in Persons Report Mean? \(state.gov\)](https://www.dhs.gov/what-do-the-tiers-of-the-trafficking-in-persons-report-mean?state.gov)

⁵ Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, *Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан* (2022) <https://mn.usembassy.gov/mn/2022-trafficking-in-persons-report-mn/> сүүлд хандсан: 2023-07-08.

Хүснэгт 1. Үнэлгээ хийх хүрээ

№	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, заалт
1	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт
		2 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомж
		3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
		4 дүгээр зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зарчим
2	Хоёрдугаар бүлэг. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зохион байгуулалт	5 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх
		6 дугаар зүйл. Дэд зөвлөл, түүний бүрэн эрх
		7 дугаар зүйл. Хуулийн этгээдийн үүрэг
		8 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг
3	Гуравдугаар бүлэг. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны арга хэлбэр	9 дүгээр зүйл. Хамгаалах байр
		10 дугаар зүйл. Хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах
		11 дүгээр зүйл. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамгаалах
		12 дугаар зүйл. Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ
		13 дугаар зүйл. Хохирогч хүүхдийг хамгаалах
		14 дүгээр зүйл. Хүн худалдаалах талаар мэдээлэл өгсөн иргэнийг хамгаалах, урамшуулах
		15 дугаар зүйл. Хохирол нөхөн төлүүлэх
		16 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны санхүүжилт

Үүнээс гадна дараах хүрээг нэмж тогтоосон. Үүнд:

- **Олон Улсын гэрээ конвенцтой үндэсний хууль тогтоомж нийцэж буй байдлыг үнэлэх зорилгоор:**
- - Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол;
- **Үндэсний хууль тогтоомжийн хоорондын нийцэл, уялдаа хангагдаж буй эсэхийг үнэлэх зорилгоор:**
 - Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль;
 - Эрүүгийн хууль;
 - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль;
 - Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль;
 - Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр /2017-2021 онд хэрэгжүүлсэн/;

• **ХХТХ-ийг хэрэгжүүлэх дэд бүтцэд үнэлгээ хийх зорилгоор:**

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээ үзүүлэх журам (ЭМЯ)
- Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам (ХНХЯ)
- Хилийн чанадад хүн худалдаалах болон хүнд, онц хүнд гэмт хэргийн хохирогч болсон иргэнийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах, үйлчилгээ үзүүлэх тухай журам (ГХЯ)⁶

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт:

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхдээ аргачлалын 3.4-д заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг харгалзан сонгов.

Шалгуур үзүүлэлтүүдээс:

- **Зорилгод хүрсэн түвшин**
- **Практикт нийцэж байгаа байдал**
- **Хүлээн зөвшөөрөгдсөн байдал** гэсэн 3 шалгуур үзүүлэлтийг сонгож,

хуулийн үнэлэх зүйл, заалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой гэдэг байдлаар тохируулж сонгов.

Хүснэгт 2. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг	Шалгуур үзүүлэлт
1	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл /Конвенц ба үндэсний хууль тогтоомжийн нийцэл/	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	Зорилгод хүрсэн түвшин
		2 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомж	
		3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	
		4 дүгээр зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зарчим	
2	Хоёрдугаар бүлэг. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зохион байгуулалт	5 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх	Зорилгод хүрсэн түвшин
		6 дугаар зүйл. Дэд зөвлөл, түүний бүрэн эрх	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
		7 дугаар зүйл. Хуулийн этгээдийн үүрэг	Практикт нийцэж байгаа байдал
		8 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг	

⁶ Эдгээр ОУ-ын гэрээ, хууль, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг үнэлэхдээ зөвхөн хүн худалдаалахтай холбоотой буюу ХХТХ-ийн хэрэгжилтийг хангахад холбогдох зүйл, хэсэг, заалтыг хамруулсан.

3	Гуравдугаар бүлэг. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны арга хэлбэр	9 дүгээр зүйл. Хамгаалах байр	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал
		10 дугаар зүйл. Хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах	
		11 дүгээр зүйл. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамгаалах	
		12 дугаар зүйл. Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ	
		13 дугаар зүйл. Хохирогч хүүхдийг хамгаалах	Практикт нийцэж байгаа байдал
		14 дүгээр зүйл. Хүн худалдаалах талаар мэдээлэл өгсөн иргэнийг хамгаалах, урамшуулах	
		15 дугаар зүйл. Хохирол нөхөн төлүүлэх	
		16 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны санхүүжилт	

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр:

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зорилт, зарчим, хэм хэмжээ НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенц, түүний нэмэлт протоколтой нийцэж буй эсэх, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомж хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах нөхцөл байдал, хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийнэ.

Аргачлалын харьцуулах хэлбэрүүдээс «байх ёстой болон одоо байгаа», «хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших», «тохиолдол судлал» гэсэн 3 хэлбэрийг сонгов.

Хүснэгт 3. Үнэлгээний харьцуулах хэлбэр

	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, заалт	Харьцуулах хэлбэр
1	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	Байх ёстой болон одоо байгаа
		2 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомж	
		3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	
		4 дүгээр зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зарчим	

2	Хоёрдугаар бүлэг. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зохион байгуулалт	5 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх	Байх ёстой болон одоо байгаа
		6 дугаар зүйл. Дэд зөвлөл, түүний бүрэн эрх	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших
		7 дугаар зүйл. Хуулийн этгээдийн үүрэг	
		8 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг	Тохиолдол судлал
3	Гуравдугаар бүлэг. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны арга хэлбэр	9 дүгээр зүйл. Хамгаалах байр	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших
		10 дугаар зүйл. Хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах	
		11 дүгээр зүйл. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамгаалах	
		12 дугаар зүйл. Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ	
		13 дугаар зүйл. Хохирогч хүүхдийг хамгаалах	Тохиолдол судлал
		14 дүгээр зүйл. Хүн худалдаалах талаар мэдээлэл өгсөн иргэнийг хамгаалах, урамшуулах	
		15 дугаар зүйл. Хохирол нөхөн төлүүлэх	
		16 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны санхүүжилт	

Дээрх харьцуулалтын хэлбэрийн хүрээнд тус хуулийн хэрэгжилт одоогийн нөхцөл байдалд нийцэж буй эсэх, төрийн байгууллага, иргэн, төрийн бус байгууллага, бусад этгээдийн эрх, үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хэрхэн зохицуулж байгаа болон уг хуулийн нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг судалж тогтоосон.

1.5. Мэдээлэл цуглуулах арга:

Үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр зэргээс хамаарч тоон болон чанарын мэдээллийг ашиглаж дараах мэдээлэл цуглуулах аргыг ашигласан болно. Үүнд:

- **Баримт бичгийн судалгаа:** ХХГХ-ийн талаар хийгдсэн болон бусад судалгааны тайлан, холбогдох статистик, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн.
- **Ганцаарчилсан ярилцлага:** ХХТХ-ийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага, төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа мэргэжлийн байгууллага зэргийн ажилтан, албан хаагчид мөн хүн худалдаалах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчид болон гэмт хэргийн хохирогчдоос ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан.

2


ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргын дагуу хэрэгжилтийн үе шатыг хийж гүйцэтгэв. Ингэхдээ холбогдох байгууллагуудаас статистик, тоон мэдээг авч, ярилцлагын удирдамжийн дагуу уулзалт, ганцаарчилсан ярилцлага хийж мэдээлэл цуглуулсан. Мөн олон улсын эрх зүйн болон үндэсний хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт, өмнө хийгдсэн судалгааны тайлангуудад дүн шинжилгээ хийлээ.

2.1. Статистик, тоон мэдээ цуглуулах

2013-2023 оны эхний хагас жилийн байдлаар цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн ХХГХ, түүнд хяналт тавьсан прокурорын болон шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн статистикт дүн шинжилгээ хийсэн. Ингэхдээ ХХГХ-тэй ихэвчлэн давхар зүйлчлэгддэг, ялангуяа шүүхийн шатанд зүйлчлэл өөрчлөгддөг бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн статистик үзүүлэлтүүдийг нэгтгэн судаллаа. Тоон мэдээллийг цуглуулахдаа анхан шатны бүх шүүхээр хянан шийдвэрлэсэн хэргийн тоог он тус бүрээр авч, цагдаагийн байгууллага, прокурор, шүүхээс тус бүр хэргийн хувьд 68 үзүүлэлтээр, хохирогчийн хувьд 103 үзүүлэлтээр тус тус нэгтгэсэн.

График 1. Бүртгэгдсэн болон хянан шийдвэрлэсэн хэрэг



Шүүхээс сүүлийн 10 жилийн хугацаанд 30 хэрэгт холбогдох 59 хүнийг ХХГХ үйлдсэн гэм буруутайд тооцож, ял шийтгэсэн байна⁷. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн 91 гэмт хэрэгт 68 хүнийг холбогдуулан шалгасан байна. Цагдаагийн байгууллагад 91 хэрэг бүртгэгдсэнээс 30 хэргийг буюу 31.8 хувийг шүүх эцэслэн шийдвэрлэсэн хэмээн бүртгэсэн бөгөөд үүний 64.1 хувь

⁷ Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг тухайн тайлант хугацаанд хянан шийдвэрлэсэн хэргийг 1 гэж тоолох бөгөөд давж заалдах болон хяналтын шатны шүүхээс өөрчлөгдөж, хүчингүй болж буцсаны улмаас дараа онд ахин шийдэгдсэн тохиолдолд +1 гэж тоологддог. Шүүхийн Ерөнхий Зөвлөл, *Шүүн таслах ажиллагааны тайлан, 3/887 тоот албан бичиг* (2023)

нь хүн худалдаалах гэмт хэргийг үйлдсэн хэмээн үзэж шүүхээс ял шийтгэсэн байна. Шүүхээр эцэслэн энэ гэмт хэргийн хохирогч гэж тогтоосон тоон мэдээлэл нь 2018 оноос эхлэн гэмт хэргийн зүйл тус бүрээр гардаг болсонтой холбоотойгоор 2013-2017 оны хугацаанд хянан шийдвэрлэсэн хэрэгт хохирсон хохирогчийн тоон мэдээлэл гарах боломжгүй харин 2018-2022 оны бүтэн жилд 55 хүн хохирогчоор тогтоогдсон байна⁸.

Нэгтгэсэн тоон мэдээллээс гадна шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн. Энэ нь ХХГХ-ийг шийдвэрлэж буй шүүхийн практик, хуулийг хэрэгжүүлэхэд учирч буй хүндрэл, бэрхшээл, эрх зүйн хэм хэмжээний хийдэл ба зөрчилдөөн, гэмт хэргийн хохирогч, хохиролтой холбоотой асуудлыг хэрхэн шийдвэрлэж буй байдал зэрэгт дүн шинжилгээ хийхэд ач холбогдолтой юм. Статистик тоон мэдээллийн талаар дэлгэрүүлэн 3, 4 дүгээр бүлгээс үзнэ үү.

2.2. Чанарын судалгаа

Ярилцлагын судалгаа: ХХГХ-ийн оролцогч болон ХХТХ-ийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий хууль сахиулах, шүүх эрх мэдлийн, төрийн захиргааны төв байгууллага, төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагчдаас ярилцлагын аргаар анхан болон нэмэлт мэдээлэл, тодруулга, тайлбар авах бичил судалгааны удирдамж боловсруулж, түүний дагуу мэдээллийг цуглуулав.

Хүснэгт 4. Судалгаанд оролцогчид (хүйсээр)

№	Оролцогч	Түүвэр (n)	Үүнээс эмэгтэй
Хэргийн оролцогч		18	
1	Хохирогч (2) болон хохирогчийн ар гэр (1)	3	3
2	Цагдаа (мөрдөгч)	3	0
3	Прокурор	3	2
4	Өмгөөлөгч	2	1
5	Шүүгч	1	1
6	Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч	6	4
Байгууллага		8	
7	Гадаад харилцааны яам	1	0
8	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	1	1
9	Эрүүл мэндийн яам	1	1
10	Хил хамгаалах ерөнхий газар	1	0
11	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба	1	0

⁸ Шүүхийн Ерөнхий Зөвлөл, *Шүүн таслах ажиллагааны тайлан, 3/887 тоот албан бичиг* (2023)

12	Бүх шатны нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага	1	0
13	Төрийн бус болон Олон улсын байгууллага	2	2
		26	15

Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулахдаа дараах байдлаар судлах зүйлийг томъёолж мэдээлэл цуглуулсан. Үүнд:

- Хохирол (эдийн болон эдийн бус);
- Хохирогчийн аюулгүй байдал, хамгаалалт, хууль зүйн туслалцаа;
- Эмчилгээ, зөвлөгөө, нийгмийн ажил;
- Хэргийг шийдвэрлэхэд учирч буй хүндрэл бэрхшээл;
- Хууль, дүрэм, журмын хэрэгжилт;
- Төрийн байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, уялдаа;
- Төрийн бус болон олон улсын байгууллагын үйл ажиллагаа, идэвх санаачилга.

2.3. Баримт бичгийн шинжилгээ

Энэ бүлэгт олон улсын эрх зүйн болон үндэсний хууль тогтоомж, тэдгээртэй холбоотой жишиг хууль, сайн туршлага, Монгол Улс дахь хүн худалдаалахтай холбоотой асуудлаар хийгдсэн судалгаа, бусад ач холбогдол бүхий баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- А. Хүн худалдаалахтай тэмцэх жишиг хууль^{9 10}
- Б. Хүн худалдаалахын эсрэг жишиг хэм хэмжээнүүд^{11 12}
- В. НҮБ-ын Хүн худалдаалах гэмт хэргийн 2022 оны дэлхийн тайлан^{13 14}
- Г. Монгол Улсад хүн худалдаалахтай тэмцэх асуудлаар хийсэн судалгаанууд:

Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр 2016-2023 оны хугацаанд 20 гаруй судалгааны тайлан гарсан байна. Судлагдсан судалгаануудыг зорилгоор нь бүлэглэн үзвэл:

⁹ Model Law against Trafficking in Persons

¹⁰ United Nations Office on Drugs and Crime, *Model Law against Trafficking in Persons* (1990) https://www.unodc.org/documents/human-trafficking/UNODC_Model_Law_on_Trafficking_in_Persons.pdf сүүлд хандсан: 2023-07-05.

¹¹ Model Law against Trafficking in Persons

¹² United Nations Office on Drugs and Crime, *Model Legislative Provisions Against Trafficking In Persons* (2020) <https://humantraffickingsearch.org/resource/model-legislative-provisions-against-trafficking-in-persons/> сүүлд хандсан: 2023-07-05.

¹³ Global report on trafficking in persons 2022

¹⁴ United Nations Office on Drugs and Crime, *Trafficking in Persons*, (2022) <https://www.unodc.org/unodc/data-and-analysis/glotip.html> сүүлд хандсан: 2023-07-05.

1. Хүүхэд хамгааллын тогтолцоо, зураглал, хүүхдийн хөдөлмөр эрхлэх асуудал
2. ХХГХ-ийн хохирогчид туслалцаа үзүүлэх механизм, хохирогчийн нэр төрийг хамгаалах, хохирогч төвтэй хандлагыг төлөвшүүлэх, хохирогчийг тогтоох, тусламж үйлчилгээ үзүүлэх
3. Хүн худалдаалахтай тэмцэх хуулийн хэрэгжилт, хэргийн шийдвэрлэлт, зүйлчлэлийн асуудал, хэргийн шалтгаан нөхцөл
4. Хүний бэлгийн эрх чөлөө, биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөг зэрэг байдлаар судалсан байна.

Харин дээрх судалгаануудаас нийтлэг байдлаар хүрсэн дүгнэлт, зөвлөмждөө дараах саналуудыг дэвшүүлжээ. Үүнд:

- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийх замаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжиж буй эрх зүйн баримт бичгүүдийг уялдуулах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг илүү хохирогч төвтэй хандлагад үндэслэн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн тодорхойлолттой нийцүүлэх;
- Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлж буйг илрүүлэхэд анхаарлаа хандуулах, түүнтэй холбоотой эрх зүйн орчин сайжруулах ажлыг эхлүүлэх;
- Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, ХХГХ-т өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний нэгдсэн удирдамжийг боловсруулах, хэрэгжүүлэх;
- Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах замаар хүний наймааны төрөл, хэлбэрийг бие даасан гэмт хэрэг болгож хуульчилсан байдлыг засаж, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын дагуу гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй байдлыг бий болгохгүй байх нөхцөлийг хангах чиглэлээр эрх бүхий байгууллагад нь зөвлөмж хүргүүлэх;
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг яаралтай боловсруулан батлах талаар эрх бүхий байгууллагад зөвлөмж хүргүүлэх;
- Төр, ТББ хооронд салбар дундын мэдээлэл солилцох сүлжээг бий болгох замаар нэгдсэн ойлголттой болгох, уялдаа холбоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, оролцогч байгууллагууд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтын ажиллагааны гүйцэтгэлээ жил бүр үнэлж хэвших;
- Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, ялангуяа үндэстэн дамнасан байдлаар үйлдэгддэг гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хянах, шүүхээр шийдвэрлэх бүхий л шатанд зарцуулагдах өртөг зардлын тооцооллыг нарийвчлан гаргах хэрэгцээ нэгэнт бий болсон байна. ХХГХ нь зохион байгуулалттай, үндэстэн дамнасан гэмт хэрэг

учир энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд нэн шаардлагатай эдийн засгийн өртөг зардлын үнэлгээг хийж, хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт, гэрчийг хамгаалах, хохирогчдод туслалцаа үзүүлэх чиглэлээр төсвийг нарийвчлан улсын төсөвт тусгаж байх;

- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)-ийг даган гарсан 5 журам, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг даган гарсан 9 журмын хэрэгжилтийг сайжруулах;
- Зохион байгуулалттай гэмт хэргийн хохирогч болсон хүнд шууд туслалцаа үзүүлэх ажиллагааг эрчимжүүлэх, ялангуяа Засгийн газрын тусгай сангийн Гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх сангийн зардалд тусгах;
- Шүүхээс хохирогч нарт бодитоор учирсан хохирлыг тэдний цуглуулсан нотлох баримтад тулгуурлан гаргуулдаг хэдий ч энэ нь хохирогчдын хохирлын дөнгөж 6 хувьтай тэнцэж байна. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын хувьд бусад төрлийн гэмт хэргээс тусгайлан авч үзэж, ялангуяа сэтгэл санааны хохирол¹⁵, эрүүл мэндэд учирсан хохирол болон бусад бодит хохирлын нөхөн төлдөг эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Хохирогчдод сэтгэл санааны болон эд материалын хохирлын нөхөн олговор олгох, төрөөс эхэлж хохирлыг барагдуулж, гэмт хэрэгтнүүдээс сайн дураар болон албадлагын журмаар хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагааг хуульчлах, хэрэгжүүлэх;
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн хяналт шалгалт болон шууд утсанд ирсэн дуудлагаар илрүүлсэн хууль сахиулах байгууллагын албан хаагч холбогдсон буюу түүний үйлдсэн гэмт хэрэг болон хүлээн авагч орнуудын хууль сахиулах байгууллагатай хамтран шалгаж буй бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгаж, хэрэг үүсгэхдээ Захиргааны буюу Эрүүгийн хуулийн хөнгөн ял шийтгэл дагуулах алтернатив зүйл, заалтаас илүү тус хуулийн 12.3 болон 13.1-р зүйлчлэх байдлыг нэмэгдүүлэн, үүний дагуу алба хаагчдыг сургах хүчин чармайлтыг дээшлүүлэх;
- Хоорондоо зөрчилдсөн буюу давхацсан зүйл заалтуудыг арилгах зорилгоор хүний наймаатай тэмцэх хууль тогтоомжуудыг дахин хянан үзэж, нэмэлт өөрчлөлт оруулах замаар хүний наймаатай холбогдох шүүхийн процессын ажиллагааг тодорхой болгох;
- Төрийн алба хаагчид буюу цагдаа, гадаадын иргэн, харьяатын газар, хүүхдийн эрх болон хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн байгууллагуудын албан хаагчдад ХХГХ-ийн хохирогчийг, ялангуяа эрэгтэй хүмүүс, эрэгтэй хүүхдийг таньж илрүүлэх, мөн гадаадын ажилчид, томоохон хилийн боомтуудаар дамжин өнгөрч буй дотоод, гадаадын иргэд, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад байрлах хятад ажил

¹⁵ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)-ийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт.

олгогчдын зүгээс хөдөлмөрийг нь мөлжих буюу зүй бусаар харьцаж байгаа нүүрс тээвэрлэлтийн дотоодын ажилчид, уул уурхайн бүсэд амьдарч буй хүүхэд, эмэгтэйчүүд, болон ЛГБТ болон бусад бэлгийн чиг баримжаатай хүмүүсийн дундаас таньж илрүүлэх, хамгаалах үйлчилгээнд холбон зуучлахад удирдлага болгох албан ёсны журмуудыг системтэй болгож, бүрэн хэрэгжүүлэх;

- Хүн худалдаалсан сэжигтэнд албан ёсоор эрүүгийн хэрэг үүсгэсэн эсэхээс үл шалтгаалан хохирогчид хамгаалах үйлчилгээ авах боломжийг хангах үүднээс холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах;
- 2012 онд батлагдсан Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахад нэн шаардлагатай бусад холбогдох журам зааврыг баталж мөрдөх; зохих албаны хүмүүсийг дээрх журам зааврыг үр дүн, өгөөжтэй хэрэгжүүлэх сургалтад хамруулах¹⁶.

Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр хийгдсэн дээрх судалгаануудын зорилго, хүрсэн дүгнэлт, гаргасан санал, зөвлөмжийг нэгтгэн дүгнэвэл:

1. Хууль тогтоомжийн уялдаагүй байдлыг арилгаж нэгдмэл цогц байдлаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх;
2. Хүн худалдаалахтай тэмцэхэд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийг төсөвлөж, шийдвэрлэх;
3. Хүн худалдаалахтай тэмцэгч байгууллагуудыг дэд бүтэцжүүлэх, эрх хэмжээ олгох гэсэн байна.

¹⁶ Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, 2015 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан (2015) <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2015-trafficking-persons-report-mn/> Сүүлд хандсан: 2023-07-09.

3.1. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ БА ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны 55/25 тоот тогтоолоор “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцыг баталж, 2003 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр 147 улс гарын үсэг зурснаар Конвенц хүчин төгөлдөр болсон, өдгөө уг Конвенцыг улс орнууд дэмжиж нэгдэн орсоор 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 191 улс нэгдэн ороод байна.

Монгол Улс уг Конвенц болон түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай” протоколд 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсон хэдий ч үндсэн конвенцыг албан ёсоор орчуулсан Монгол хэл дээрх эх сурвалжгүй, зөвхөн нэмэлт протокол нь Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2012 оны №17/734 дугаарт хэвлэгдсэн байдалтай, цахим эх сурвалжид албан ёсоор байршуулаагүй байна. Иймд Конвенцыг Төрийн мэдээлэл сэтгүүлд, Конвенц болон Протоколыг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /legalinfo.mn/-д албан ёсоор орчуулж, байршуулах шаардлагатай гэж үзлээ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зорилт, зарчим, хэм хэмжээ нь НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенц, түүний нэмэлт протоколтой нийцэж буй эсэх:

1. Хуулийн зорилт

Конвенцын 1 дүгээр зүйлд “Энэхүү конвенцын зорилго нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх хамтын ажиллагааг илүү үр дүнтэй болгоход оршино” гэж заасан¹⁷. Харин Протоколын 2 дугаар зүйлд “Энэхүү протоколын зорилго нь:

- (a) Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, ингэхдээ хүүхэд, эмэгтэйчүүдэд онцгойлон анхаарах;
- (b) Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид хүндэтгэлтэй хандах, хүний эрхийг нь хамгаалах, тэдэнд туслах;
- (c) Дээрх зорилгодоо хүрэхийн тулд улс гүрнүүдийн хамтын ажиллагааг дэмжихэд оршино”¹⁸ гэжээ.

¹⁷ United Nations Office on Drugs and Crime, *United nations convention against transnational organized crime and the protocols thereto* (2004) 13. Сүүлд хандсан: 2023-07-10 <https://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf>

¹⁸ United Nations Office on Drugs and Crime, *United nations convention against transnational organized crime and the protocols thereto* (2004) 50. Сүүлд хандсан: 2023-07-10 <https://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf>

ХХТХ-ийн зорилтыг “Энэ хуулийн зорилт нь хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино”¹⁹ гэж томъёолсон.

ХХТХ-ийн зорилт болон Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын Конвенц, түүний нэмэлт Протоколын зорилгыг харьцуулан авч үзвэл хүн худалдаалахтай тэмцэх асуудалд “Хүүхэд, эмэгтэйчүүдийг онцгойлон анхаарах” тухай зохицуулалтыг эс тооцвол **нэгдэн орсон олон улсын гэрээнийхээ зорилготой бүрэн нийцсэн зорилтыг хуульд заасан** гэж үзэхээр байна.

2. Хүн худалдаалах тухай ойлголт ба гэмт хэргийн шинж

Конвенц, Протокол болон үндэсний хууль тогтоомжийн нийцлийн дараагийн асуудал нь хүн худалдаалах тухай ойлголт болно.

Эрүүгийн хуульд ХХГХ-ийн шинжийг тодорхойлж, хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тодорхойлсон бол ХХТХ-аар хүн худалдаалахыг нийгмийн сөрөг үзэгдэл буюу гэмт явдал болохын хувьд тодорхойлж түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалах зэрэг асуудлыг зохицуулсан байна. Хүн худалдаалах нь гэмт явдал талаасаа зохион байгуулалттай гэмт явдлын нэг төрөл, бүхэлдээ гэмт хэргийн хүрээнд тодорхойлогдох үзэгдэл байдаг. Тийм ч учраас Эрүүгийн хууль дахь ХХГХ-ийн шинж, ХХТХ дахь хүн худалдаалах тухай ухагдахууны хүрээ үндсэндээ давхцана.

НҮБ-ын Конвенцын 2 дугаар зүйлд “Зохион байгуулалттай гэмт бүлэг” гэж 3 ба түүнээс дээш тооны этгээд энэхүү конвенцод заасан аль нэг гэмт хэргийг эсхүл хэд хэдэн төрлийн хүнд гэмт хэргүүд үйлдэж шууд болон дам байдлаар ашиг хонжоо олох зорилгоор нэгдэж бүтэц зохион байгуулалттайгаар тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулсан байхыг хэлнэ²⁰ гэж тодорхойлсон бол Эрүүгийн хуулийн 3.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдлийг зохион байгуулалттай гэмт бүлэг гэнэ”²¹ хэмээн тодорхойлсон. Конвенцын тодорхойлолтыг Эрүүгийн хуулийн тодорхойлолттой харьцуулж үзвэл агуулгын зөрчилдөөн байхгүй, зөвхөн Эрүүгийн хуулийн тодорхойлолтод хамаарах зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн ойлголт нь илүү өргөн хүрээг хамрахаар байгаа ч энэ нь Конвенцын зорилгод нийцэхгүй гэсэн ойлголт биш юм.

Харин Протоколын 3 дугаар зүйлд “Хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх,

¹⁹ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)-ийн 1 дүгээр зүйлийн 1.1. дэх заалт.

²⁰ United Nations Office on Drugs and Crime, *United nations convention against transnational organized crime and the protocols thereto* (2004) 13. Сүүлд хандсан: 2023-07-10
<https://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf>

²¹ Эрүүгийн хууль (2015)-ийн 3.8 дугаар зүйлийн 1 дэх заалт.

эрх мэдлээ урвуулах ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ²² гэжээ. Тэгвэл Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт *“Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн, тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан”* бол ХХГХ-т тооцохоор, ХХТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д *“хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг”* хүн худалдаалах явдал гэж үзэхээр тус тус хуульчилсан болно. Эдгээр тодорхойлолтыг харьцуулан үзээд Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээн үүргээ биелүүлж үндэсний хууль тогтоомждоо ХХГХ-т тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх үйлдэл, эс үйлдэхүйн шинж болон хүн худалдаалах явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тогтолцоонд хэрэглэх ойлголтыг агуулгын ямар нэгэн зөрүүгүйгээр тодорхойлсон гэж үзэхээр байна.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 13.1.2-д *“Энэ гэмт хэргийг:”,* (1). хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж; (2). хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж; (3). *“Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол...”* гэж заасан бол 13.1.3-д *“Энэ гэмт хэргийг:”* (1). *“байнга тогтвортой;”,* (2) *“зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хүндрүүлж ял шийтгэнэ”* гэж тус тус заасан бөгөөд тайлбар хэсэгт *“Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй”. “Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй”* гэж тус тус зохицуулсан.

Дээрхээс үзвэл Монгол Улсын нэгдэн орсон Палермогийн Протоколын 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хүлээсэн “3 дугаар зүйлд дурдсан үйлдлүүдийг санаатайгаар үйлдсэн бол тэдгээрийг гэмт хэрэгт тооцох” үүргээ биелүүлжээ.

²² Төрийн мэдээлэл сэтгүүл (2012) №17/734, 912.

Эрүүгийн хууль дахь ХХГХ-ийн шинж нь Протоколын 3 дугаар зүйлээр тодорхойлсон мөлжих зорилго, үйлдэл, арга гэсэн 3 шинжийг бүгдийг нь агуулсан байна.

Протоколд заасны дагуу ХХГХ-ийн эхний шинж нь **үйлдэл** юм. Протоколд заасан элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан **үйлдлүүдийг нь** Эрүүгийн хуульд бүрэн тусгасан. Хоёр дахь шинж нь эдгээр үйлдлээ хэрэгжүүлэх **арга** болно. Мөн Протоколд заасан хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдах гэсэн бүх аргыг Эрүүгийн хуульд гэмт хэргийн шинж болгон тусгасан байна. ХХГХ-ийн 3 дахь шинж /элемент/ нь мөлжих **зорилго** юм.

Эрүүгийн хуулиар мөн л хүн худалдаалах гэмт хэргийг мөлжих зорилгоор хүнийг эрхшээлдээ оруулсан үйлдэл байх ёстойг хуульчилахаас гадна Протоколын 3 дугаар зүйлийн (b), (c)-д заасан хохирогч зөвшөөрснийг үл хэрэгсэх болон хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдэхэд гэмт хэргийн шинж болгон дурдсан аргыг хэрэглэсэн байх шаардлагагүй болохыг мөн хуульчилсан байна.

ХХГХ түүнтэй ойролцоо төрлийн гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн практикт хийсэн дүн шинжилгээ болон энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон мөрдөгч, прокурор, шүүгчид Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан ХХГХ нь мөн хуулийн 12.3-д заасан Бэлгийн мөлжлөг гэмт хэргийн 12.3.2, 12.3.4 дэх хэсэгт заасан хүндрүүлэх шинжид энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор гэж заасан нь Эрүүгийн хуулийн 13.1-д заасан ХХГХ-тэй өрсөлдүүлсэн хэм хэмжээ болсон байна²³. Эрүүгийн хуулийн 13.13-д заасан Албадан хөдөлмөрлүүлэх явдлыг гэмт хэрэгт тооцохдоо мөн хуулийн 13.1-д заасан ХХГХ-ийн албадан хөдөлмөрлүүлж мөлжих үйлдлийн шинжийг давхардуулсан байна²⁴. Эрүүгийн хуулийн 16 бүлгийн 16.4. Хүүхдээр гуйлга гуйлгах, 16.6. Хүүхэд худалдах, 16.8. Хүүхэд садар самууныг сурталчлах уруу татах, 16.9. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, 16.10. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийн шинжүүд нь ХХГХ-ийн шинжүүдтэй давхцаж байгааг анхаарах шаардлагатай²⁵ хэмээн дүгнэсэн байдаг.

ХХГХ нь үйлдэл, арга, зорилго гэсэн 3 шинжтэй. Бэлгийн мөлжлөг /12.3/, Албадан хөдөлмөрлүүлэх /13.13/ болон Хүүхдийн эсрэг гэмт хэрэг /16 бүлэг/-үүд нь ХХГХ-тэй өрсөлдөх хэм хэмжээ агуулсан боловч хүн худалдах гэмт хэрэг нь **“элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах”** гэсэн үйлдлийн шинжээрээ дээрх гэмт хэргүүдээс ялгагдаж зүйлчлэгдэх учиртай.

²³ Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ судалгааны тайлан (2022) 82.

²⁴ Мөн тэнд.

²⁵ Мөн тэнд.

Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг” гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид зориуд “зорчих эрхийг хязгаарлахгүйгээр” хэмээн онцолж дурдсан нь ч үүнтэй холбоотой.

Human trafficking буюу хүн худалдаалах хэмээн монгол хэлээр орчуулагдсан энэхүү гэмт хэргийн гол шинж нь хүнийг өөрийн гэр орон, оршин суугаа газраас нь өөр газарт аваачин улмаар эрхшээлдээ оруулдагт оршдог. “Traffick” гэх англи үг нь өөрөө аливаа юмыг нэг газраас нөгөөд тээвэрлэх, зөөвөрлөх, шилжүүлэх гэсэн утгатай²⁶. Улс гүрний хилийг дамнуулан хохирогчийг тээвэрлэж, зөөвөрлөн “хүний газар” аваачиж эрхшээлдээ оруулж, бэлгийн болон бусад мөлжлөгт оруулдаг учраас дэлхийн улс гүрнүүд энэ гэмт хэргийг үндэстэн дамнасан зохион байгуулалтай гэмт явдал хэмээн үзэж түүнтэй тэмцэхийн тулд Конвенц, Протокол зориулан баталсан билээ. Гэхдээ хүн худалдаалах нь зөвхөн улс дамнадаг гэж үзэж болохгүй. Улс орны дотоодод ч хүнийг энэ гэмт хэрэгт тооцох аргуудыг ашиглан эрхшээлдээ оруулан мөлжиж ашиглах явдал гардаг. Үүнийг “Дотоодын хүн худалдаалах хэрэг” гэдэг.

Иймд хохирогчийг заавал улс дамнаулан тээвэрлэсэн байх шаардлагагүй бөгөөд ямар нэг тээврийн хэрэгслээр эсхүл явганаар ч нэг байрлалаас нөгөө байрлалд шилжүүлсэн нь ХХГХ-т тооцох үндэслэл болох ба ингэхдээ Протоколд заасан аргуудын аль нэгийг ашиглан мөлжих зорилгоор үйлдсэн байхыг шаардана. Тодруулбал, хүнийг мөлжих зорилгоор, хуульд заасан аргуудыг ашиглаж нэг байшингаас нөгөө байшинд шилжүүлсэн байхад үүнийг “хохирогчийн зорчих эрхийг хязгаарласан”-д тооцож энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангасанд тооцох учиртай²⁷. Гэтэл ХХГХ-ийн энэхүү үйлдлийн шинж нь байхгүй буюу хохирогчийг орон гэр, оршин суудаг газраас шилжүүлж эрхшээлдээ оруулахгүйгээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн эсрэг дээр дурдсан олон төрлийн гэмт хэрэгт хохироох явдал гардаг. Эдгээр гэмт хэргийг бүгдийг Эрүүгийн хуулиар ерөнхийлөн хуульчилж ХХГХ-т хамаатуулж болохгүй. Иймд дурдан буй судалгаагаар²⁸ Эрүүгийн хуульд ХХГХ-ийн шинжийг буруу буюу давхардуулан тогтоосон гэж дүгнэсэн нь үндэслэлгүй юм.

Иймд Конвенц, Протокол, Эрүүгийн хууль, ХХТХ хоорондоо зөрчилтэй, эсхүл ХХГХ-ийн шинжийг өөр гэмт хэргийн шинжтэй давхардуулан хуульчилсан гэж дүгнэх нь үндэслэлгүй, харин шүүхийн практикт энэхүү ХХГХ-ийн нэг гол элемент болох “үйлдэл”-ийн шинжийг зөв тайлбарлаж хэргүүдийг амжилттай зүйлчилж шийдвэрлэж хэвших нь чухал гэж дүгнэж байна.

Гэхдээ НҮБ-ын конвенц, түүний нэмэлт протоколоор албан ёсоор ХХГХ-ийн “зорилго, арга, үйлдэл”-ийн шинжийг өөрчлөөгүй боловч дэлхийн улс

²⁶ The Oxford English Dictionary, <https://www.oed.com/search/dictionary/?scope=Entries&q=traffic> Сүүлд хандсан: 2023-07-12.

²⁷ Mission 89, *Defining human trafficking and its elements* (2022) <https://mission89.org/defining-human-trafficking-and-its-elements/> Сүүлд хандсан: 2023-07-12

²⁸ *Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ судалгааны тайлан* (2022) 82.

орнуудын ХХГХ-тэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал, бэрхшээлээс үүдэлтэй “элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан” буюу тодорхой байршлаас шилжүүлсэн үйлдэл нь зайлшгүй байх шинж эсэх талаар шүүмжлэл буйг анхаарах нь зүйтэй²⁹.

ХХТХ болон ЭХ-д хүн худалдаалах гэмт хэргийг хуульчлах үед ХХГХ-ийн шинжид заавал байх нэг шинж нь “элсүүлэх, дамжуулах, тээвэрлэх, хүлээн авах, орогнуулах үйлдэл” байсан, НҮБ-ын конвенц, протоколд хүн худалдаалах тухай ойлголтод ямар нэгэн өөрчлөлт ороогүйгээс үзвэл одоо ч энэ шинж хэвээр буй. Гагцхүү нийгэмд эл сөрөг үзэгдэл гарч буй нөхцөл байдлыг харгалзан хүн худалдаалах тухай ойлголтын агуулгыг хэрхэн авч үзэх тухайд бид “хүн худалдаалах” гэмт хэрэгт тооцохын тулд заавал movement буюу нэг газраас нөгөөд шилжүүлэхийг шаардахгүй хэмээн үзэж болох юм. Гэхдээ Эрүүгийн хуульд энэ нөхцөл байдлыг тооцон үзэж “хүн худалдаалах” болон “бэлгийн мөлжлөг” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг өрсөлдөх хэм хэмжээ болгон хуульчилж ойролцоо ялын бодлого баримталсан хэдий ч эдгээр хэм хэмжээний хэрэглээ шүүхийн практикт ихээхэн маргаан мэтгэлцээн дагуулж байна.

Хэрэв Эрүүгийн хуулийн 12.3, 13.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн шинжүүдийг нарийн шинжилж үзвэл аливаа хэлбэрийн бэлгийн мөлжлөг нь “элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах” үйлдэл хийсэн эсэхээс үл хамааран эрүүгийн хариуцлага хүлээнэ. Тэр тусмаа зохион байгуулалттай гэмт хэргийн шинжтэй буюу бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг “байнга тогтвортой үйлдсэн” бол оногдуулах ялын төрөл, хэмжээ нь “хоёроос найман жил” ижил байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хувьд Эрүүгийн хуулийн “13.1. Хүн худалдаалах” гэмт хэргийн шинжийг заавал өөрчлөхгүйгээр энэ төрлийн гэмт явдалтай ямар нэгэн ялгаваргүй, нэгдмэл бодлогоор амжилттай тэмцэх бүрэн боломжтой юм.

Эдгээрээс үзвэл Эрүүгийн хууль, ХХТХ-д заасан хүн худалдаалах тухай ойлголт нь Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Конвенц, түүний нэмэлт Протоколд заасан ойлголттой агуулгын хувьд зөрүүгүй томъёологдсон байх тул хуулийн эдгээр хэм хэмжээ нь ХХТХ-ийн 1 дүгээр зүйлд заасан Хуулийн зорилтод нийцсэн гэж үнэлэхээр байна. Түүнчлэн уг хуулийг хэрэглэж буй байдлаас үзвэл шүүхээс хүн худалдаалах тухай ойлголтыг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон шаардлагад нийцсэн практик тогтоож чадсан байх тул “практикт нийцсэн” гэж үзнэ. Харин ХХГХ-тэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлж буй зарим оролцогчид энэ төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг буруу томъёолсон, цаашид бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр эрхлүүлэх болон хүүхдийн эсрэг зарим гэмт хэрэгтэй давхцаж буй байдлыг арилгах шаардлагатай гэх санал дүгнэлт хийж буйг

²⁹ U.S.Department of State, *Major Forms of Trafficking in Persons*, (2008)
[Major Forms of Trafficking in Persons \(state.gov\)](https://www.state.gov/j/tip/rlc/cfr/11811.htm) Сүүлд хандсан: 2023-07-12

харгалзан хүн худалдаалах тухай ойлголтын хууль зүйн тодорхойлолтын “хүлээн зөвшөөрөгдсөн байдал” хангалтгүй, цаашид шүүхийн практик, олон улсын эрх зүйн болон үндэсний эрх зүйн хэм хэмжээний талаарх нэгдмэл ойлголт хэрэглээг хэвшүүлэхийн тулд сургалт, нөлөөллийн арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна.

3. Хохирогчийн асуудал

Конвенц, Протокол болон үндэсний хууль тогтоомжийн нийцлийн дараагийн асуудал нь хохирогчийг тодорхойлох болон түүнийг хамгаалах асуудал юм. Иймд судалгааны тус хэсэгт конвенц болон протоколын холбогдох заалтыг нэг бүрчлэн авч үзнэ.

Конвенцын 25 дугаар зүйл

- 1. Орлоцогч улс бүр энэхүү Конвенцод хамаарах гэмт хэргийн хохирогчийг халдлага, заналхийлэхээс хамгаалах, туслалцаа үзүүлэх арга хэмжээ авах ёстой.*
- 2. Орлоцогч улс бүр энэхүү Конвенцод хамаарах гэмт хэргийн хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэх дотоодын хууль тогтоомжийг батална.*
- 3. Орлоцогч улс бүр эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зохих шатанд хохирогч эрх ашгаа хамгаалан оролцох боломжийг дотоодын хууль тогтоомжийнхоо хүрээнд бүрдүүлнэ’.*

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн талаар зохицуулсан бөгөөд 10.3 дахь хэсэгт “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг ... Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/...” гэмт хэргийн хохирогч энэхүү сангаас нөхөн төлбөр авах эрхтэй байхаар хуульчилсан байна. Мөн хуулийн 10.5 дахь хэсэгт “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 220 дугаар тогтоолоор уг журмыг баталж мөрдүүлж байна.

Протоколын 6 дугаар зүйлээр улс орнуудыг “ХХГХ-ийн хохирогчдын хувийн амьдралыг ба тэдгээрийг бие хүний хувьд, тухайлбал, хүн худалдаалахтай холбогдох тухайн хэргийн шүүн таслах ажиллагааг нууц байлгах арга замаар, дотоодын хууль тогтоомжоор байж болох хэмжээнд хамгаалах”-ыг даалгасан.

ХХТХ-ийн 3.1.2-д "хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг" хэлнэ гэж заасан. Энэхүү хохирогчийг ЭХХШТХ-ийн 8.1-д заасан журмаар хохирогчоор тогтоож, 8.2-д заасан эрхээр хангаж, 8.3-д заасан журмаар мэдээллээр хангаж, ХХТХ-ийн 9-11, ГХХТХ-ийн 7-16, ЭХХШТХ-ийн 13.1,

13.2, 35.18-д заасны дагуу аюулгүй байдлыг хамгаалах, 29.3-д заасан үндэслэл, журмаар нууцлалыг хангах эрх зүйн зохицуулалт хийжээ.

Протоколын 6 дугаар зүйлийн 2(а) заалт. Оролцогч улс бүр дотоодын хууль зүйн буюу захиргааны тогтолцооны хүрээнд хүн худалдаалах хэргийн хохирогчдод, зохих тохиолдлуудад: шүүхийн болон захиргааны хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны талаар мэдээлэл өгөх

Үүний дагуу ГХХТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.3.2-д хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын үүрэг болгон хуульчилсан байна. Түүнчлэн мөн хуулийн 17 дугаар зүйлд “17.2.2. Гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх”, “17.2.3. Шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх” үүргийг ч мөн холбогдох этгээдэд хүлээлгэсэн. Харин ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлийн “8.2.1.8. Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй танилцах” 8.3 дугаар зүйлд “1.1. Яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эсэхийг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэг; 1.2. Хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг харьяаллын дагуу шилжүүлэх; 1.3. Ялтныг хорих ялаас хугацааны өмнө суллах асуудлыг шийдвэрлэх хуралдаан”-ыг хийх талаарх мэдээллийг эдгээр ажиллагааг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэх; Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авсан, өөрчилсөн, хүчингүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, хаасан, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хэргийг прокурорт шилжүүлсэн талаар тус тус мэдэгдэх ёстой талаар хуульчилсан. Эдгээрээс үзвэл Протоколын 6 дугаар зүйлийн 2 (а) хүлээсэн үүргийг биелүүлэх эрх зүйн орчин бүрджээ³⁰.

Протоколын 6 дугаар зүйлийн 2 (b) заалт. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд холбогдох эрүүгийн шүүн таслах ажиллагааны зохих үе шатуудад өмгөөлөх талын эрхэд хохирол учруулахгүй байх хэлбэрээр санал бодол, болгоомжлолыг нь илэрхийлэх, хэлэлцүүлэх боломжийг бүрдүүлэх талаар туслалцаа үзүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан байх нөхцөлийг хангана.

ЭХХШТХ-ийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудад хохирогчийн оролцоо, эрх, үүргийг хуульчилсан. Хохирогч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах, мөрдөн шалгах тодорхой

³⁰ Хэдийгээр ийнхүү Конвенц болон Протоколд үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэн хохирогчийг мэдээллээр хангах эрх зүйн үндэс бүрдсэн боловч энэхүү мэдээллээр хангах зохицуулалтын хэрэгжилтийг дараагийн бүлэгт нарийвчлан авч үзнэ.

ажиллагаа явуулах, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах, шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцох, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй танилцах, нэмэлт ажиллагаа хийлгэх тухай хүсэлт гаргах, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах, шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлтийн өөрт хамааралтай хэсэгтэй танилцах зэрэг эрхийг эдэлдгээс үндэслэн Протоколд заасан шаардлагатай үндэсний хууль тогтоомж нийцсэн байна гэж дүгнэж болохоор байна.

Протоколын 6 дугаар зүйлийн 3-д “Оролцогч улс бүр хүн худалдаалах хэргийн хохирогчдыг бие бялдар, сэтгэл зүй болон нийгэмд эзлэх байр суурийн хувьд нөхөн сэргээх арга хэмжээг, тухайлбал зохих тохиолдлуудад дор дурдсан арга хэмжээг засгийн газрын бус байгууллагууд, бусад холбогдох байгууллагууд болон иргэний нийгмийн бусад хэсэгтэй хамтран хэрэгжүүлэх асуудлыг авч үзнэ” гэж үндсэн 4 асуудлыг зохицуулсныг тус бүрд нь дүгнэе.

Протоколын 6 дугаар зүйлийн 3(а) зохих орон байраар хангах

ГХХТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт болон 13 дугаар зүйлд заасны дагуу шаардлагатай тохиолдолд хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.

ХХТХ-ийн 9 дүгээр зүйлд заасны дагуу “Хамгаалах байр”-нд байрлуулж хамгаалахаар заасан. Энэхүү “Хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг Засгийн газар батална” гэж мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-д заасан³¹.

Протоколын 6 дугаар зүйлийн 3 (b) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод ойлгогдох хэлээр, ялангуяа хуулиар тогтоосон эрхийн талаар зөвлөгөө ба мэдээлэл өгөх

ГХХТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.3.5 дахь заалт хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхээр, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэгт энэ үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн баг хохирогчийг хамгаалах байгууллагын дэргэд ажиллахаар, ХХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад ХХГХ-ийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх ёстойг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт энэхүү

³¹ Хуулийн энэхүү хэм хэмжээний хэрэгжилтийн талаар дараагийн бүлэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

үйлчилгээг үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар хуульчилсан байна³².

Протоколын 6 дугаар зүйлийн 3(с) эмнэлгийн, сэтгэл зүйн болон материаллаг туслалцаа үзүүлэх

Хохирогчид эмнэлгийн тусламж үзүүлэх асуудлыг ХХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 12.1.2³³ дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын үүрэг болгож холбогдох журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоохоор, ГХХТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтад хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх талаар, 18.3 дахь хэсэгт Эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журмыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар тус тус заасан³⁴.

Протоколын 6 дугаар зүйлийн 3(d) хөдөлмөрлөх, боловсрол эзэмших, болон суралцах бололцоогоор хангах.

ГХХТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалтад хохирогчид нийгмийн бусад туслалцаа буюу хохирогчийн амьдралын зайлшгүй хэрэгцээт хоол хүнс, хувцас, шаардлагатай бусад ахуйн хэрэгцээ болон насанд хүрээгүй гэрч, хохирогчийн суралцах хэрэгцээг хангахад чиглэсэн тусламж үйлчилгээ үзүүлэхээр заасан. Харин ХХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтад ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэхээр зааж энэхүү үйлчилгээ үзүүлэх журмыг нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар зохицуулсан³⁵.

Эдгээрээс Протоколын 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс хууль зүйн хувьд бүрдсэн гэж дүгнэж болох хэдий ч хэрэгжилтийг дараах бүлгүүдэд үнэлэх юм.

Харин ХХГХ-ийн хохирогчоор хэдий үеэс тооцох талаар Монгол Улсын хууль тогтоомжоор ялгаатай зохицуулалт хийсэн нь ойлгомжгүй байдал үүсгээд байна. ХХТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад "хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг

³² Холбогдох хуулийн зохицуулалтын дагуу ийнхүү хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээний акт үйлчилж байгаа эсэх болон түүний хэрэгжүүлэх дэд бүтэц байгаа эсэх талаар судалсан үр дүнг дараагийн бүлэгт танилцуулна.

³³ Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн, А/356, А/182 дугаар тушаалын хэрэгжилтийг дараагийн бүлэгт авч үзнэ.

³⁴ Эдгээр эрх зүйн хэм хэмжээний актууд батлагдсан эсэх талаар болон бусад хэрэгжилтийн талаар дараагийн бүлэгт тусгайлан судалсан.

³⁵ Энэхүү зохицуулалтын дагуу Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 тоот тушаалаар баталсан журмын хэрэгжилтийн үнэлгээг дараагийн бүлэгт хийсэн.

үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг тооцохоор заасан. Үүнийг ХХГХ-ийн хохирогчид хуулийн олон шат дамжлага бүхий урт удаан процессыг хүлээлгүй яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх, хохирогчийг хамгаалалтад авах хэрэгцээнд үндэслэсэн гэж үздэг.

Харин “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “гэрч, хохирогч” гэж ЭХХШТХ-д заасан гэрч, хохирогчийг тооцохоор заасан.

ЭХХШТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д “1.Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ. 2.Шүүх, прокурор, мөрдөгч хохирогчоор тогтоох тухай шийдвэр гаргана” гэж заасан.

Ийнхүү хүн худалдаалахын хохирогчоор тогтоох талаар илэрхий зөрүүтэй дээрх хоёр хуулийн зохицуулалт нь хэнийг хохирогч гэж үзэх, хохирогчийг хамгаалах, тусламж, үйлчилгээ үзүүлэх ажиллагааг хэзээнээс эхлүүлэх зэрэг хууль зүйн хувьд авч хэрэгжүүлэх олон процессыг тодорхойгүй байдалд оруулж байна.

Нэг талаас гэмт хэргийн хохирогч нь хуулиар тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээсэн ЭХХША-ны оролцогч тул зайлшгүй эрх бүхий этгээдийн шийдвэрээр тодорхой цаг хугацаа, үе шатнаас “албан ёсоор” хохирогчоор тогтоох нь зүйтэй. Гэтэл хүн худалдаалахын хохирогчийн хувьд бие махбод, сэтгэл санааны ноцтой хохирол амсаж, эрүүл мэнд, сэтгэл зүйн, хууль зүйн туслалцаа яаралтай үзүүлэх, хамгаалалтад даруй авах шаардлагатай байдаг. Иймд ХХТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д “хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг” гэсний ард “ЭХХШТХ, ГХХТХ-д заасан үндэслэл журмын дагуу “Шүүх, прокурор, мөрдөгч хохирогчоор тогтоох тухай шийдвэр гаргасан эсэхээс үл хамааран хүн худалдаалахын улмаас хохирсон гэж үзэх үндэслэл байгаа тохиолдолд хохирогчид энэ хуульд заасан хамгаалах, халамж үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг авна” гэсэн заалт нэмж оруулах нь зүйтэй. Эсхүл ийм агуулга бүхий тайлбар уг зүйлтэй холбоотойгоор оруулж болох юм.

4. Урьдчилан сэргийлэлт, хамтын ажиллагаа болон бусад арга хэмжээ

Протоколын 9 дүгээр зүйлд Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх талаар оролцогч улсууд дараах асуудлаар бүрэн цогц бодлого, хөтөлбөрүүд болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгайлан зохицуулсан асуудлыг тус бүрд нь хэрэгжилтийг нь авч үзнэ.

Протоколын 9 дүгээр зүйлийн 1(а) Хүн худалдаалах хэргээс урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх

Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд ХХТХ-аар энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэхийг зорьсон. Хуулийн зорилтыг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдал хэмээн тогтоогоод 5 дугаар зүйлд Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлохдоо:

1. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх;
2. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
3. Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхээр зохицуулсан.

Энэхүү зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Харин хэрэгжилтийг үнэлж үзвэл, холбогдох төрийн захиргааны байгууллагын ажилтан, албан тушаалтнууд **хангалтгүй** гэж үзэж байна. ХХГХ-тэй тэмцэх ажил 2006-2012 оны хооронд идэвхтэй байсан бол 2012 оноос хойш орхигдсон шинжтэй байна гэж үзэж байна.

Шигтгээ 1. ХНХЯ-ны мэргэжилтэн, эмэгтэй, 15 жил ажилласан

Монгол Улс 2006 оноос эхэлж ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр анхаарч ажиллаж эхэлсэн. Үүний жишээ нь Хүн худалдаалахтай тэмцэх Палермогийн конвенцод нэгдэж орсон. 2006 оноос 2012 оны хооронд хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр бодлогын болон шийдвэр гаргах түвшинд маш сайн анхаарч байсан бол 2012 оноос 2016 оны хооронд хэн ч тоогоогүй орхигдсон гэхэд болно. ХХГХ-тэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт бол аль ч шатандаа хангалтгүй байгаа.

Мөн нутгийн захиргааны болон өөрийгөө удирдах байгууллагын ажилтнууд ХХТХ болон Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаар мэдлэг, мэдээлэл хангалтгүй гэж үзэж байна.

Шигтгээ 2. Баянзүрх дүүргийн засаг даргын орлогч, эрэгтэй, 4 жил ажилласан

Ер нь энэ ХХТХ болон хөтөлбөрийн талаарх мэдээлэл миний хувьд маш хангалтгүй байна. Миний хувийн бодлоор бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлтэй холбоотой асуудал хавтгайрсан шинжтэй харагдаж байна.

Энэ чиглэлээр тодорхой тушаал, захирамж, удирдамж гарч байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зэргийг л баримтлаад явж байгаа болохоос яг ХХТХ болон хөтөлбөрийн заалтыг мөрдлөг болгоод явж байгаа зүйл байхгүй.

ГХХТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.3.2-д заасан “Гэрч, хохирогчийг мэдээллээр хангах” ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой зохицуулалт,

журам, заавар байхгүй, практикт шүүхийн болон захиргааны хянан хэлэлцэх ажиллагааны талаар мэдээлэл өгсөн тохиолдол гараагүй байна. Чанарын судалгааны явцад хохирогчтой хийсэн ярилцлагаас хохирогч өөрийн ямар эрхтэй болох, хэргийн явц байдал ямар шатандаа байгаа зэргийг огт мэдэхгүй байсан.

Стандартчиллын Үндэсний Зөвлөлийн 2013 оны 12 сарын 19-ний өдрийн 58 дугаар тогтоолоор “ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих, нийтлэг шаардлага”³⁶-ыг баталсан. Тус стандартад хууль зүйн туслалцаа үзүүлэх шаардлагыг зохицуулсан боловч дээрх хохирогчтой хийсэн ярилцлагаас үзэхэд практикт хэрэгжихгүй байгаа нь харагдаж байна.

Иймд Конвенц болон Протоколын 6 дугаар зүйлийн 2 (а)-р хүлээсэн үүрэгт нийцүүлэн ХХТХ, ЭХХШТХ, ГХХТХ-уудыг нийцүүлэн хуульчилсан боловч түүнийг хэрэгжүүлэн эрх зүйн зохицуулалтыг бүрэн хийгээгүй тул хуулийн хэрэгжилтийг хангалтгүй гэж үзнэ.

Шүүхийн практикт ХХГХ-ийн үйлдэл нь элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан үйлдэл байх ёстойг үл хэрэгсэн хохирогчийн бэлгийн болон бусад хэлбэрийн мөлжлөгт орж буйгаа өөрөө хүлээн зөвшөөрсөн байдал зэргийг үндэслэл болгон хөнгөрүүлэн зүйлчилж буй нь үндэслэлгүй байна.

5. Хүүхдийн эрхийн конвенцын нэмэлт болох Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол:

2002 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан уг протоколд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самууныг сурталчлах зорилгоор олон улсын хэмжээнд хууль бусаар хил давуулан тээвэрлэх явдал мэдэгдэхүйц нэмэгдсэн, хүүхдэд аюултай секс аялал өргөжин үргэлжилж, ялангуяа энэ нь хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлахад шууд нөлөө үзүүлж байгаа бөгөөд бэлгийн хүчирхийлэлд өртөгсдийн дийлэнх хувийг бага насны охид эзэлж байгаа, интернэт болон бусад дэвшилтэт технологийн хүчээр хүүхдийг садар самуунд сурталчлах явдал нэмэгдэж байгаа зэргийг гол үндэслэл болгосон байдаг. Улмаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд улс орнуудын эрүүгийн болон гэмт хэргийн талаарх хуульдаа тусгах үйлдэл болон үйл ажиллагааг бүрэн хамааруулж, эдгээр гэмт хэрэг улсын дотоодод буюу үндэстэн дамнасан болон ганцаарчилсан буюу зохион байгуулалттай хэлбэрээр үйлдэгдсэнийг харгалзахгүйгээр хариуцлага хүлээлгэх талаар зааж өгснөөрөө онцлогтой³⁷.

³⁶ Монгол Улсын Стандарт, MNS 6418:2013, *Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих, нийтлэг шаардлага*, (2013)-ын 2 дугаар зүйлийн 2.2.4 дэх хэсэг.

³⁷ Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам нар, *Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгааны тайлан* (2021)

3.2. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ

ХХТХ-ийн 5 дугаар зүйлд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн байгууллагуудыг тодорхойлж, тэдгээрийн эрх хэмжээ, зохион байгуулалтыг тусгасан. Үүнээс хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой журмуудыг батлан хэрэгжүүлэхийг зарим төрийн захиргааны төв байгууллагуудад даалгасан. Үүнд:

Хүснэгт 5. ХХТХ-ийн Төрийн захиргааны төв байгууллагын хуулиар хүлээсэн бүрэн эрхийн хэрэгжилт

Төрийн захиргааны төв байгууллага	Хуулиар хүлээлгэсэн бүрэн эрх	Хэрэгжилт
1. Монгол Улсын Засгийн газар	Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх	Монгол Улсын Их Хурлын 2017 оны №148-р тогтоолоор Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсан.
	Хамгаалах байрны журам батлах	Батлагдаагүй тул хэрэгжилтийг үнэлэх боломжгүй.
2. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Хүн худалдаалахтай тэмцэх мэдээллийн сан бүрдүүлэх	Батлагдаагүй тул хэрэгжилтийг үнэлэх боломжгүй ба шалтгааныг ХЗДХЯ-наас тодруулсан боловч хариу ирүүлээгүй.
	УЕП-той хамтран хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам батлах	
	Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам батлах	
	ХХТХ тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуй нэгж, байгууллага, албан тушаалтныг урамшуулах журам батлах	
	Дэд зөвлөлийн ажиллах журмыг батлах	2021 оны №01 дугаартай Дэд зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг баталсан.

<p>3. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</p>	<p>Хуулийн 12.1.5-д заасан журам батлах</p> <p>Гадаад улсын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын насанд хүрээгүй иргэний эрх, ашиг сонирхлыг хамгаалах</p>	<p>Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91 тушаалаар Гадаад улсад МУ-ыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр хоол хүнсээр хангах, гадаад паспорт түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах журам батлагдсан.</p>
<p>4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</p>	<p>12.1.3-д заасан үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих</p> <p>Хохирогчийг хамгаалах, халамж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, туслалцаа үзүүлэх.</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 7 сарын 09-ний өдрийн А/135 дугаар тушаалаар “Ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах журам”-ыг баталсан.</p> <p>Журмын хэрэгжилтийн талаар 5.4. хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.</p>
<p>5. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</p>	<p>Хуулийн 12.1.1-д “Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ хийх” журам,</p> <p>12.1.2-д “Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээ үзүүлэх” журмыг батлан хэрэгжүүлэхийг заасан.</p>	<p>12.1.2-д заасан Сэтгэцийн нөхөн сэргээх журам батлагдсан.</p> <p>12.1.1-д заасан Эрүүл мэндийн нөхөн сэргээх журам батлагдаагүй.</p> <p>Батлагдаагүй шалтгаан нь Эрүүл мэндийн тухай хуульд байхгүй нэр томъёо бүхий журам батлан хэрэгжүүлэх тухай заасан нь хуулийн нийцэл хангагдаагүй.</p>

1. Монгол Улсын Засгийн Газар бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал

ХХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д Хүн худалдаалахтай тэмцэх талаар Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэх бүрэн эрхийг тусгайлан хуульчилсан байдгийг хэрэгжилтийн дүн шинжилгээг хуулийн заалт тус бүрээр нь энэ хэсэгт авч үзнэ.

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний бодлого хөтөлбөр, хэрэгжүүлэх

Засгийн газрын 2017 оны 5 сарын 24-ний өдрийн 148 дугаар тогтоолоор “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах цогц үйлчилгээг бий болгох, цаашид энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэнэ” гэх зорилгоор баталж, 2017-2021 он хүртэл 4 жилийн хугацаанд хэрэгжүүлж дууссан байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн захиалгаар “Эс Ай Си Эй” ХХК 2022 онд гүйцэтгэжээ. Тус үнэлгээнд хөтөлбөр 4 зорилт, 26 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хөтөлбөрийн үнэлгээг 91.9 хувьтай дүгнэсэн ба хэрэгжүүлсэн 26 үйл ажиллагааны 13 нь үр дүнтэй, 11 нь тодорхой үр дүнтэй, 2 нь эрчимжүүлэх шаардлагатай гэж үзсэн бөгөөд эрчимжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны хувьд:

- ХХГХ-тэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудыг нэгдсэн мэдээллийн сүлжээгээр холбож, шаардлагатай техник хэрэгсэл, мэргэжилтнээр хангах
- ХХГХ-ийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх төвийг байгуулах зэрэг үйл ажиллагаа байна.

Мөн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхдээ: ХХГХ-тэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаа эрчимжиж, энэ төрлийн гэмт хэрэг хүрээгээ тэлж хохирогчийн тоо нэмэгдэхээс урьдчилан сэргийлж чадсан бөгөөд ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагаа нэгдсэн нэг төлөвлөгөөтэй болж, түүнд холбогдох байгууллага бүрийг татан оруулж, улсын төсөв болон олон улсын төсөл хөтөлбөрөөс санхүүжиж байна. Иргэд энэ төрлийн гэмт хэргийн талаар тодорхой ойлголт мэдлэгтэй болж, хүний эрхийн зөрчлийг мэдээлэх үүргээ ухамсарладаг болсон нь эерэг үр дүнгүүдийн нэг болсныг онцолж тэмдэглэж байна. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээнд хүний нөөцийг нэмэгдүүлснээр гэмт хэргийн илрүүлэлт өссөн үр дүн гарчээ. ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ажилладаг ТББ-уудын үйл ажиллагаа сайн байгаа нь сайшаалтай үр дүн байлаа.

Цаашид байгууллага хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагаа цахим системд оруулах, статистикийн тоон мэдээлэлд зөрүүтэй байдал үүсгэхгүй байхад анхаарах шаардлагатай. Мөн ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ХХГХ-тэй тэмцэх тасгийн

албан хаагчдын тоог нэмэх, тэдний ур чадварын өсөлт, тогтвортой байдалд анхаарах хэрэгтэй. Гэмт хэргийн илрүүлэлт өссөнөөр хохирогчдыг хамгаалах, нийгэм сэтгэл зүй, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж хэвийн амьдралдаа эргэн ороход нь тусалцаа үзүүлэхэд анхаарах нөхцөл бүрдэх юм. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, хохирогчид туслалцаа үзүүлэх чиглэлээр ажиллаж буй ажилтан, албан хаагчдын ажлын ачаалал, онцлог нөхцөл байдлыг нарийвчлан судалж, тэдний ажлын онцлогт тохирсон уян хатан нөхцөл бүхий дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага байна. Цаашид ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах, зөвлөгөө мэдээлэл өгөх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, иргэний нийгмийн үйл ажиллагааг илүүтэй татан оруулахад анхаарч тэдний үйл ажиллагааны онцлогт тохирсон бодлогын дэмжлэг үзүүлэх шаардлагатай³⁸ байна гэжээ.

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах

ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын байгууллагатай чиглэл бүрээр хамтран ажиллаж ирсэн. Тухайлбал:

- 2001 онд Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (IOM)- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран “Мөрөөдлийн шүхэр” ХХГХ, бэлгийн мөлжлөгийн талаар ойлголт мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх үндэсний мэдээллийн аян өрнүүлсэн.
- НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF)- Төрийн болон ТББ-ын урьдчилан сэргийлэх чиглэлийн төслүүд, сургалт, сурталчилгааны ажлуудад техникийн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, санхүүжүүлэх, 2018 оноос хойш “We protect” төслийг хэрэгжүүлэхэд МУ-ын Засгийн газарт дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. “We protect” үндэсний загвар нь
 1. Бодлого засаглал,
 2. Хуулийн хэрэгжилт
 3. Хохирогчдод үзүүлж буй үйлчилгээний нөхцөл байдал.
 4. Нийгмийн хүчин зүйл,
 5. Хувийн хэвшлийн хамтын ажиллагаа,
 6. Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа гэсэн зургаан зүйлтэй цогц бүтцийн зураглал гаргаад ажиллаж байна.
- ОУХБ (ILO)- Хөдөлмөрийн харилцааны суурь найман конвенцыг соёрхон батлуулсан ба үүнээс хоёр нь албадан хөдөлмөртэй холбоотой, Олон улсын шүүхийн практикийг хэрэгжүүлэх, Техникийн

³⁸ Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам нар, *Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ судалгааны тайлан (2022)*

зөвлөгөө өгөх, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулах, Модуль сургалтын хөтөлбөр боловсруулах, Сэтгүүлчид, хүүхдийн эрхийн байцаагч зэрэг мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтууд зохион байгуулах, Албадан хөдөлмөрийг тодорхойлох ОУХБ-ын шалгуур үзүүлэлтийг Монгол хэл дээр орчуулан гаргасан, ОУХБ-ын 3R (rights, responsibilities and representation) буюу орон нутагт нь хүүхэд залуучуудыг хэрхэн хүнд хөдөлмөрөөс салгах талаар олон улсын модулийг Монголд нутагшуулах ажлыг зохион байгуулж байна.

- Дэлхийн Зөн Монгол ОУБ (World Vision International Mongolia)- 1998-2017 оны хооронд ДЗМОУБ нь Хүүхэд Хөгжил Хамгаалал Хөтөлбөрийн хүрээнд эмзэг бүлгийн болон гудамжны хүүхдүүдийг гэр бүлд нь эргэн нийгэмшүүлэх, хөгжүүлэх, амьдрах ухаанд сургах чиглэлээр төсөл хэрэгжүүлж байсан, 2014 оны 3 дугаар сараас Хүүхдийн төлөө үндэсний газар, Мобиком корпорац, Дэлхийн зөн Монгол ОУБ хамтран “Хүүхдийн тусламжийн утас 108” төслийг хэрэгжүүлсэн. ДЗМОУБ нь 2023 он гэхэд хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагаагаараа дамжуулан 500,000 хүүхэд, ялангуяа хүнд нөхцөлд амьдарч байгаа 140,000 хүүхдийн амьдралд эерэг өөрчлөлт авчрахын төлөө зорин ажиллаж байна. 2020 оноос эхлэн Европын холбооны санхүүжилтээр “Time’s up –Sexual Violence Against Children project” төслийг хэрэгжүүлж байна.
- Гүүд Нэйборс ОУТББ (Good neighbours)- Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр болон Гэрээр зочлох үйл ажиллагаа, бусад хөтөлбөрүүдийн хүрээнд зорилтот орон нутгийн хүүхдүүдийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд холбон зуучлах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг, Цахим хуудсаар дамжуулж ХХГХ, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрөөс сэргийлэх талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна.
- Азийн сан (The Asia Foundation)- АНУ-ын Засгийн газрын санхүүжилтээр 2017-2019 онд хэрэгжүүлсэн төслийн хүрээнд “хүн худалдаалах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч төвтэй хандлага төлөвшүүлэх” сургалтаар нийслэл, аймгийн цагдаа, прокурор, шүүгч, хил хамгаалах, иргэн, харьяатын алба хаагчдын хамтарсан сургалтуудыг зохион байгуулсан ба үүнд төрийн байгууллагын 700 гаруй албан хаагч хамрагдсан.
- Японы Хүүхдийг Ивээх Сан (Save the Children Japan)- Хүүхдийн эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, боловсролыг дэмжих, ядуурлыг бууруулах, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, гамшиг, онцгой байдлын

чиглэлээр судалгаа, мэдээ мэдээлэл, зөвлөгөө, сургалт, нөлөөллийн ажлын чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг. 2015 оноос эхлэн Хүүхэд хамгааллын төвийг ажиллуулж эхэлсэн бөгөөд Хүүхдийн эрх, нөлөөллийн ажлын чиглэлээр хамтарсан багаар хэрхэн ажиллах, нийгмийн ажилтнуудад чиглэсэн кейс менежментийн үйлчилгээг хэрхэн, яаж үзүүлэх талаар арга зүйн чадавхжуулах сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг³⁹.

- Талита Ази ТББ-2013 оноос Шведийн Хаант Улс дахь “Талита” олон улсын байгууллагын Ази дахь төлөөлөл болон тэдний тусламж дэмжлэгтэйгээр 2 хамгаалах байртай Улаанбаатар хотод ажиллаж байгаа бөгөөд бэлгийн мөлжлөгийн зорилгоор ХХГХ болон биеэ үнэлэх явдлын хохирогч болсон эмэгтэйчүүд, охидод удаан хугацааны сэтгэл зүйн болон нийгмийн үйлчилгээг үзүүлдэг.

Мөн түүнчлэн Монгол Улс “Bali process”-д нэгдэн орсон. “Bali process” нь Ази-Номхон далайн бүс нутаг болон бусад орнуудад хүн хууль бусаар хил нэвтрүүлэх, хүн худалдаалах, түүнтэй холбоотой үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд туслах, хууль бус цагаачлалын асуудлаарх хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох, бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2002 онд байгуулагдсан олон улсын, олон талт форум юм. Бали процесст 45 гишүүн улс, 4 олон улсын байгууллага /НҮБ-ын Дүрвэгсдийн агентлаг (UNHCR), Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ), НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC), Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)/ нэгдсэн⁴⁰.

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3. Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх

ХХГХ-ийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээг төсөл, хөтөлбөрийн хүрээнд ОУБ-ын дэмжлэгтэйгээр ТББ-ууд хэрэгжүүлж байна. ХХГХ-ийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээний зураглалаас үзэхэд ТББ-уудын хохирогч руу чиглэсэн үйлчилгээ нь анхан шат болон нөхөн сэргээх, холбон зуучлах гэсэн төрөлтэй бөгөөд үйлчилгээнд зарцуулж буй хугацаа нь харилцан адилгүй байлаа. Тодруулбал ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлэх чиглэлээр тогтмол үйлчилгээ үзүүлж байгаа нь “Хүйсийн тэгш эрх төв” ТББ, “Талита Ази” ТББ, “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ зэрэг байгууллагууд бөгөөд тэд хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилго бүхий хамгаалах байр

³⁹ Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа (2021)

⁴⁰ The Bali Process, *Bali Process Members*, <https://www.baliprocess.net/bali-process-members/> Сүүлд хандсан: 2023-07-12.

ажиллуулдаг байна. “Талита Ази” ТББ-ын хамгаалах байранд хохирогчийг урт хугацаагаар буюу 3 жил хүртэл байрлуулж байсан туршлагатай. Бусад үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд (“Гүүд нейборс” ТББ, “Анбаунд Монгол” ТББ, “Иргэдэд туслах хүний эрх төв” ТББ, “Хөөрхөн зүрхнүүдийн аян” ТББ, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн эсрэг үндэсний сүлжээ, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ, “Лантуу дохио” ТББ) нь бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хохирогчдод анхан шат, нөхөн сэргээх, холбон зуучлах үйлчилгээ үзүүлдэг ба эдгээр байгууллагууд нь ХХГХ-ийн хохирогчийг илрүүлсэн тохиолдолд дагнасан, мэргэжлийн байгууллагууд болох дээрх нэр бүхий байгууллагууд руу холбон зуучлах үйлчилгээ үзүүлдэг байна.⁴¹

ХХТХ-аар Засгийн газарт хүлээлгэсэн Үндэсний бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, урьдчилан сэргийлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлсэн байдлаар нь хуулийн үр дагаврын үнэлгээний хувьд зорилгодоо хүрсэн, практикт нийцсэн, хүлээн зөвшөөрөгдсөн гэж дүгнэж болохоор байна.

2. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал

ХХТХ-д Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бүрэн эрхийг тусгайлан зохицуулсан байдгийг дараах хэсэгт хэрэгжилтийг хуулийн заалт тус бүрээр нь авч үзнэ.

ХХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2.1. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд зохион байгуулах

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлд Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр зохицуулсан. Үүнд:

- Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон шүүх, прокурор, хууль сахиулах бусад байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа ажлыг уялдуулан зохицуулах, Зохицуулах зөвлөлийг удирдах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавих, шалгах;

⁴¹ Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа (2021)

- Шүүх, прокурор, цагдаа болон хууль сахиулах бусад байгууллагатай зөвшилцөн улсын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх;
- Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах;
- Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар гадаад улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах⁴² гэжээ.

Дээрх ажил нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиг үүрэг тул энд дэлгэрүүлэн үнэлэх боломжгүй юм.

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2.2. Хүн худалдаалах асуудлаар мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах

ХХГХ-тэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээнд “ХХГХ-ийн мэдээллийн сан бий болгох үйл ажиллагааг тодорхой үр дүнтэй” гэж үнэлжээ. Учир нь 2018 онд хүн худалдаалахтай холбогдох мэдээллийг хүлээн авч боловсруулах цахим мэдээллийн санг бий болгож, Цагдаагийн байгууллагаас ХХГХ-тэй тэмцэх цахим санд 2020 оны эхний хагас жилийн байдлаар ХХГХ-ийн хохирогч, холбогдогч, энэ төрлийн гэмт хэрэгт өртөж болзошгүй давхардсан байдлаар 1700 орчим хүний мэдээллийг оруулсан байсныг давхцалыг арилгаж, 1520 хүний мэдээллийг оруулжээ. Мөн тус цахим санг хөгжүүлэх чиглэлээр тээврийн хэрэгсэл, гэр бүлийн байдал, жолооны үнэмлэх, үл хөдлөх хөрөнгө, нийгмийн даатгал, хилийн лавлагаа, ял шийтгэл зэрэг дамжуулах серверүүдийг байршуулсан “ХУР” системтэй холбосон байна. Чанарын судалгааны үр дүнгээс харахад ХХГХ-тэй тэмцэх үндсэн чиг үүрэг бүхий Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба нь дотоод бүртгэлийн цахим сантай болсон бөгөөд тус сан нь энэ төрлийн гэмт хэргийн холбогдогч талуудын бүхий л мэдээллийг бүртгэдэг байна.

2022 оны 9 дүгээр сарын байдлаар тухайн санд нийт 1870 иргэний мэдээлэл бүртгэгдэж өссөн байдалтай байна. Ийнхүү мэдээллийн сан бий болсон ч зөвхөн цагдаагийн байгууллагад ашиглаж байгаа нь учир дутагдалтай юм. Дээрх мэдээллийн санг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн байгууллагуудыг хамтран ашиглах боломжтойгоор хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байгаа нь судалгааны үр дүнгээс харагдах болно. Шигтгээ 4-д одоо хэрэглэж байгаа мэдээллийн сан нь зөвхөн ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны ХХГХ-тэй тэмцэх хэлтсийн албан хаагчдын дотооддоо ашигладаг

⁴² Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2019)-ийн 26 дугаар зүйл.

мэдээллийн сан бөгөөд харилцан мэдээлэл солилцдог сан болгон хөгжүүлэх шаардлагатай талаар ярилцсан байна.

Шигтгээ 4. Эрүүгийн цагдаагийн албаны ХХГХ-ийн ахлах мөрдөгч

Хэргийн хохирогч, холбогдогчийн талаар мэдээллийн сан, харилцан мэдээлэл солилцох сүлжээ байхгүй. Дотооддоо цагдаагийн бүртгэлийн системд энэ хэргийг бүртгэдэг. Анхан шатанд ХХГХ-т өртсөн талаар гүйцэтгэх ажлын шугамаар авсан мэдээлэл, эсхүл гомдлоор энэ хэрэг манайд харьяаллын дагуу ирдэг. Хэргээ хүлээж аваад хохирогчоо Хүйсийн тэгш эрх төв, Талита ази гэх зэрэг төрийн бус байгууллагын хамгаалах байранд утсаар эсхүл тоотоор хүлээлгэж өгдөг. Манайд байгаа бүртгэл нь зөвхөн дотооддоо албаны шугамаар буюу Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэл солилцох сан юм.

Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаа нь нэг талаас хүний хувийн мэдээллийг хамгаалах⁴³, нөгөө талаас нэгдмэл цогц байх⁴⁴, олон улсын хамтын ажиллагаа, иргэний нийгмийн оролцоонд түшиглэх⁴⁵ зарчмаар явагдах ёстой. Гэтэл зөвхөн цагдаагийн байгууллага дотоод хэрэгцээндээ ашигладаг, иргэний нийгмийн байгууллага, прокурор, шүүх болон бусад төрийн байгууллага албан тушаалтан ашиглах бололцоогүй мэдээллийг “мэдээллийн сан” гэж үзэх нь зохисгүй юм. Учир нь хуулийн дээрх зарчмуудыг мөрдөхийн тулд хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаанд оролцогч талууд дээрх мэдээллийн сангаас мэдээлэл авч үйл ажиллагааг төлөвлөх, уялдуулан зохицуулах зайлшгүй шаардлагатай. Учир нь ярилцлагын судалгаанд оролцсон холбогдох байгууллагын ажилтан, албан хаагчид мэдээллийн сангийн талаар дараах асуудлуудыг дэвшүүлж байв.

Шигтгээ 5. Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор, эмэгтэй

Энэ төрлийн гэмт хэргийн мэдээллийн сангийн талаар мэдэхгүй байна. Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сул байна. Прокурорын өөрийн дотоод сүлжээгээр энэ төрлийн гэмт хэргийн мэдээллийг хайж байж өмнө нь хяналт тавьсан хэргийг хайж уншиж судалдаг.

Шигтгээ 6. ХНХЯ-ны мэргэжилтэн, эмэгтэй, 15 жил ажилласан

ХНХЯ-ны мэдээллийн санд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг бүртгэх www.etuslamj.mn сайтыг 2022 оноос хөгжүүлж эхэлсэн байгаа. Одоогийн байдлаар ХХГХ-ийн хохирогчдыг бүртгэх, хохирогчдод үзүүлсэн үйлчилгээг бүртгэж авдаг байхаар хөгжүүлэхээр төлөвлөлтийн шатанд явж байна.

Шигтгээ 7. Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч, эрэгтэй, 4 жил ажилласан

Дүүрэг дээр мэдээллийн сан байхгүй. Нөгөөтэйгүүр энэ нь хувь хүний нууцтай холбоотой далд явагддаг ажиллагаа байх гэж бодож байна. Дүүрэг дээр энэ талаарх мэдээлэл бусад төрийн байгууллагаас ирдэггүй.

⁴³ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт

⁴⁴ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт

⁴⁵ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт

Шигтгээ 8. СЭМҮТ-ийн эмч, эрэгтэй, 18 жил ажилласан

ХХГХ-ийн хохирогч болон эмчилгээний талаарх тусдаа мэдээллийн сан байхгүй. Сэтгэцийн гэмтэл дотор холилдоод орсон боловч тусдаа ХХГХ-ийн хохирогч гэж байхгүй. Хүн худалдаалах, хүчирхийллийн хохирогч нь нийгэмд би хохирсон, гэдгээ хэлээд яваад байдаггүй, нууцалдаг яагаад гэвэл хувь хүн дотроо их ичдэг, айдаг, өөрийгөө жигшдэг ийм сэтгэцийн эмгэгтэй болдог. Асууж тодруулахад зарим үед дарамт стресттэй болдог мөн энэ асуудлаасаа үүдээд сургуулиа солих, шилжилт хөдөлгөөн хийдэг.

Шигтгээ 9. Өмгөөлөгч, ХХГХ-т дагнан хууль зүйн туслалцаа үзүүлдэг

Хохирогч, холбогдогчийн талаарх ямар нэг мэдээллийн сан байхгүй эрүүгийн цагдаагийн газар дотооддоо мэдээллийн сантай. Манай үйлчлүүлэгч хохирогч хаана, ямар байдалтай байгаа талаар эргэн мэдээлэл авах ямар нэг мэдээллийн сан байхгүй. Хүн худалдаалахтай тэмцэх ажлыг төрийн байгууллага хуулиар үүрэг хүлээсэн ч маш хангалтгүй хийж байгаа ихэнх ажлыг төрийн бус байгууллага төслийн шугамаар хийж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээнээс болон ярилцлагад оролцсон бусад албан хаагчдын мэдээллээс үзвэл энэ нь зөвхөн ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны ХХГХ-тэй тэмцэх хэлтсийн албан хаагчдын дотооддоо мэдээлэл солилцдог хэрэгсэл болох нь тодорхой байна. Харин бусад байгууллагын төлөөллүүд мэдээллийн санд оролцож харилцан мэдээлэл бүртгэх, солилцох хэрэгцээ байгаа талаар дээрх ярилцлагууд харуулж байна.

Иймд хүн худалдаалах чиглэлээр дээрх хуулиар үүрэг хүлээсэн байгууллага хоорондын мэдээлэл солилцох зориулалт бүхий мэдээллийн сан бүрдсэн гэж үзэх үндэсгүй бөгөөд энэ заалт хэрэгжээгүй байна гэж дүгнэж байна.

ХХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2.3. Улсын ерөнхий прокурортой хамтран хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам батлах

Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын Ерөнхий Прокурортой хамтран хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам батална хэмээн заасан боловч одоог хүртэл уг журам нь батлагдан гараагүй байна. Гараагүй шалтгаан тодорхойгүй. Харин уг журмыг батлан гарах хэрэгцээ шаардлага байгаа талаар хууль сахиулах, өмгөөллийн болон шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагчид ярилцлагадаа дурджээ.

Шигтгээ 10. Өмгөөлөгч, эрэгтэй.

Мөн ХХТХ-ийн хэрэгжилтэд саад болж буй нэг асуудал нь хуулийг дагаж гарах журмууд бүрэн гүйцэт гараагүй байгаатай холбоотой байна. Хууль зүйн сайд болон УЕПГ хамтран гаргах хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам батлагдан гараагүй. Ийм учраас хэн ямар үйл ажиллагаа хийх нь тодорхойгүй хэвээр байна. Энэ байдал нь хохирогч давхар хохирогч болох эрсдэлтэй байдаг.

Дээрх өмгөөлөгчийн ярилцлагаас үзвэл хохирогчийн нэр төрийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах ажиллагаа ямар нэг журамлагдсан зохицуулалтгүй орхигдсон байна.

Дүгнэвэл ХХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дугаар зүйлд заасан хэм хэмжээ “зорилтдоо хүрээгүй”, нэгэнт зорилтот журам батлагдаагүй тул “практикт нийцсэн байдал”, “хүлээн зөвшөөрөгдсөн байдал”-ыг үнэлэх боломжгүй байна. Хэдийгээр практикт нийцсэн байдал, хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг үнэлэх боломжгүй ч хуулиар хүлээсэн наад захын шаардлага буюу журмаа урьдчилан боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй.

ХХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.4. Хууль зүйн туслалцаа үзүүлэх.

ХХГХ-ийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална хэмээн ХХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хэдий ч одоогийн байдлаар батлагдан гараагүй байна. Журам батлан хэрэгжүүлээгүй шалтгааныг холбогдох яамнаас тодруулахад судалгааны багт тодорхой хариу өгөөгүй юм.

Практикт Монголын Хуульчдын холбооны гишүүн 12 өмгөөлөгчтэй хүүхдийн эсрэг бэлгийн болон бие махбодын хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогч хүүхдэд мэргэшсэн өмгөөллийн туслалцаа үзүүлэх, хохирогчийн бие амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээ, туслалцаа шуурхай үзүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж тус санамж бичгийн хүрээнд 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 11 хэрэгт 7 өмгөөлөгчтэй эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан хамтран ажилласан байна. Үүнээс 10 хэрэг бүрэн хаагдаж гэрээг дүгнэж нийт 12,840,000 төгрөг дээрх арга хэмжээнд зарцуулаад байна⁴⁶ гэж Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын Дэд зөвлөлийн 2020 оны ажлын тайланд дурджээ.

Гэтэл Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Хууль зүйн туслалцааны тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулиар төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх талаар зохицуулсан ба хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчид хамаарна. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6-д Хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд батлахаар заасны дагуу 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр №А/351 “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ыг баталсан байна.

Харин ХХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэг “ХХГХ-ийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн

⁴⁶ Дэд зөвлөлийн ажлын тайлан (2020) 3.4 дэх хэсгээс...

захиргааны төв байгууллага батална” гэсэн хэсэгтэй дээрх Хууль зүйн туслалцааны тухай хууль давхардал үүсгэсэн буюу хохирогчид ХХТХ-ийн дагуу, эсхүл Хууль зүйн туслалцааны тухай хуулийн дагуу үйлчилгээ үзүүлэх эсэх нь тодорхой бус, давхардсан хэм хэмжээ болсон байгааг нэгтгэх шаардлагатай гэж үзлээ.

ХХТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.3.4. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуй нэгж, байгууллага, албан тушаалтныг урамшуулах

ХХТХ-ийг хэрэгжүүлэх чиглэлээр үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуй нэгж, байгууллага, албан тушаалтныг урамшуулах журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар зохицуулсан⁴⁷ байна. Үүнтэй холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн сайд 2016 оны 01 сарын 11-ний өдөр А/08 дугаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд үр бүтээлтэй, идэвх санаачилгатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд “Урамшуулал олгох журам”-ыг баталсан. Гэвч тус журамд урамшууллын хэмжээ нь аж ахуйн нэгж, байгууллагад 500,000 (таван зуун мянган) төгрөг, иргэн, албан тушаалтанд 300,000 (гурван зуун мянган) төгрөг хүртэл байх бөгөөд өргөмжлөл олгохоор зохицуулсан⁴⁸ нь тус гэмт хэргийг илрүүлэх, нийгмийн хор аюулыг бууруулахтай харьцуулахад хэт бага урамшууллын хэмжээ тогтоосон гэж үзэхээр байна.

Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн нь дээр дурдсан чиг үүргээс ХХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2.3.-д заасан “Улсын ерөнхий прокурортой хамтран хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам батлах”, мөн тус хуулийн 12.1.4-д заасан “Хууль зүйн туслалцаа үзүүлэх” журам батлах, Мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргүүдийг хэрэгжүүлээгүй байна.

3. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал:

ХХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.3-д Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг хуульчилсныг тус хэсэгт нэг бүрчлэн авч үзнэ.

⁴⁷ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)-ийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь заалт.

⁴⁸ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд үр бүтээлтэй, идэвх санаачилгатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд “Урамшуулал олгох журам”, А/08 дугаар, (2016)-ийн гуравдугаар зүйлийн 3.1 дэх заалт.

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.3.1. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан олон улсын гэрээнд нэгдэн орох санал боловсруулах, энэ талаар гадаад улс, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр хийх, нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах

2023 оны 04 дүгээр сарын байдлаар Унгар Улс, Бүгд Найрамдах Болгар Улс, Румын Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Словак Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Украин Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс зэрэг 19 улстай Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээтэй байна. Ийм гэрээгүй зарим улсын хувьд байгууллага хоорондын хамтын ажиллагаа, санаж бичгийн хүрээнд зохицуулж байна.

Харин Бүгд Найрамдах Турк улстай эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулахаар болжээ. Бүгд Найрамдах Филиппин Улс, Малайз Улс, Тайландын Хаант Улстай байгуулах гэрээний төсөл эхэлсэн байна. Мөн Европын зөвлөлөөс баталсан эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх гэрээг соёрхон батлахаар хүлээгдэж байна.

2020 оноос ҮДЗБГХ-ийн Конвенцын хэрэгжилтийг улс орнууд гурав гурван жилээр тайлан гаргадаг болсон байна. Харин одоогоор гэрээг дүгнэсэн тохиолдол гараагүй байна.

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.3.2. Гадаад улсад хохирогч болсон Монгол Улсын иргэний эрх ашгийг хамгаалах, түүнд туслалцаа үзүүлэх

ГХУСАЗЗАА, ГХЯ, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба, ОУШХБ, Азийн сан олон улсын байгууллага, ХТЭТ ТББ-тай хамтран Малайз Улс, Тайландын Хаант Улсад хүний наймааны хохирогч болсон байж болзошгүй Монгол Улсын 18 иргэнийг тусгай үүргийн нислэгүүдээр эх оронд нь эргүүлэн авчирсан⁴⁹.

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.3.3. Энэ хуулийн 12.1.5-д заасан үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих

ХХТмХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтад “гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол, хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах” талаар хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээг үзүүлэх журмыг батлан гаргахыг

⁴⁹ Дэд зөвлөлийн ажлын тайлан (2020) 2.1 дэх хэсгээс

Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгажээ.

Гадаад харилцааны сайдын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/91 дугаар тушаалаар “Гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг, эх оронд нь буцаан авчрах үйлчилгээ үзүүлэх” журам батлагдсан байна. Уг журмын зорилго нь хилийн чанадад хүн худалдаалах болон бусад төрлийн хүнд, онц хүнд гэмт хэргийн хохирогч болсон Монгол Улсын иргэний аюулгүй байдлыг хангах, эх оронд нь буцаах хүртэлх хугацаанд Дипломат төлөөлөгчийн газраас түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах бичиг баримт олгох, эх оронд нь буцаан авчрах зэрэг хуульд заасан бусад үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан байна.

Харин журмын хэрэгжилт ямар түвшинд байгаа талаар ярилцлагын мэдээллээс үзвэл журам боломжийн хэмжээнд хэрэгжиж байгаа бөгөөд бусад эрх зүйн актуудтай зөрчилдсөн зүйл алга гэж үзжээ. Харин төсөв хүрэлцдэггүйгээс өргөн, далайцтай үйл ажиллагаа явуулж чаддаггүй гэжээ. Мөн бусад улсад гэмт хэрэгт өртсөн иргэнээ консулын хамгаалалтад авахад зарим дипломат төлөөлөгчдийн газар өөрсдийн байргүй, байртай нь хамгаалах байрны стандартад нийцэхгүй асуудлууд үүсдэг байна. Ялангуяа Бүгд Найрамдах Турк болон Бүгд Найрамдах Солонгос Улсад Монгол Улсын төлөөлж буй дипломат болон консулын газраас стандартад нийцсэн хамгаалах байртай болох зайлшгүй шаардлагатай гэж үзжээ.

Шигтгээ 11. ГХЯ-ны Консулын газрын 3-р нарийн бичгийн дарга

Хохирогчдод үйлчилгээ үзүүлэх журмын хэрэгжилтийг өшөө сайжруулахын бидэнд төсөв өгдөггүй юм гэхэд хохирогчдыг эх оронд нь авчрахад төрөөс дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байгаа юм.

Одоогоор журам нь бусад эрх зүйн актуудтай зөрчилдөөд байгаа зүйл алга. ГХЯ-д тулгардаг нэг асуудал нь хилийн чанадад гэмт хэрэгт өртсөн иргэнээ Консулын хамгаалалтад авах гэхээр зарим Дипломат төлөөлөгчдийн газар өөрсдийн байргүй, байртай нь хамгаалалтад авах гэхээр яг хамгаалах байрны стандартад нийцэхгүй тийм асуудал байна. Тиймээс хохирогч төвтэй асуудлыг шийднэ гэж бодож байгаа бол хилийн чанадад байгаа Монголчууд ихтэй, гэмт хэргийн гаралт ихтэй улсуудад хохирогчийг хамгаалалтад авах асуудал дээр Элчин сайдын яамтай хамтраад дэмжлэг үзүүлж ажиллавал их зүгээр. Одоогийн байдлаар хохирогчийг хамгаалалтад авна гэхээр буудлын өрөө, цагдаагийн хажуу талын өрөө гэх мэт газар хамгаалалтад авснаас Элчин сайдын яамны байранд юм уу эсвэл гэрээтэй байгууллагуудтай хамтран хамгаалалтад авах түүнтэй холбоотой зардлыг шийдэж өгвөл зүгээр байна.

Дээрх албан хаагчийн ярилцлагаас үзвэл Гадаад харилцааны сайдын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/91 дүгээр журмыг хэрэгжүүлэхэд журмын 1 дүгээр зүйлийн 1.3-д заасан “зохих шаардлага хангасан хохирогчийг хамгаалах, байрлуулах өрөөг тохижуулах”-д журмын 3 дугаар зүйлийн 3.8-

д заасан “тусгай сангаас олгох” ёстой санхүүжилтийг шийдвэрлээгүйгээс шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байгаа талаар санал илэрхийлж байна.

Тус А/91 дүгээр журамд гэмт хэргийн хохирогч болсон иргэний аюулгүй байдлыг хангах, тэдэнд үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардлыг Засгийн газрын 2018 оны 110 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдэд туслах сан”-аас гаргаж зохицуулахыг даалгасан байна. Харин хэрэгжилтийн талаар ГХЯ-аас ирүүлсэн мэдээлэлд:

“Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан”-гийн чиглэлээр: Сангийн зөвлөлийн 2023 оны I, II хурлаар гадаад улсад нас барсан, гэмт хэргийн хохирогч болсон 30 орчим иргэнд 127.8 сая төгрөгийн тусламж олгон, гарсан шийдвэр, зарцуулалтын тайланг ГХЯ-ны Консулын газрын consul.mn-д байрлуулсан. 2023 оны 6 дугаар сарын байдлаар гадаад улсад 65 иргэн нас барж, 195 иргэн гэмт хэрэг, зөрчилд холбогдож, 157 иргэн хорих ял эдэлж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар Дипломат төлөөлөгчийн газруудад нийт 1000 ширхэг буцах үнэмлэх хүргүүлж, иргэдэд олгож дууссан бөгөөд дахин нэмэлт захиалга өгсөн байна.

Зүүн Өмнөд Ази дахь цахим луйвар, биеэ үнэлэлт, хөдөлмөрийн мөлжлөг, хүний наймаа болон мансууруулах бодисын хууль бус наймааны гол зангилаа болсон “Алтан гурвалжин” гэж олон улсад нэрлэгддэг бүс нутгийн Мьянмар, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улс, Тайландын Хаант Улсад Монгол Улсын иргэд хөдөлмөрийн мөлжлөгт өртөж, эрх чөлөөгөө хязгаарлуулан, ХХГХ-ийн хохирогч болох тохиолдол нэмэгдсээр байна. 2022 онд 2, 2023 оны эхний 5 сард ХХГХ-ийн хохирогч болсон байж болзошгүй 12 тохиолдол гарсан. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс дахь ЭСЯ-ны туслалцаатайгаар ЦЕГ-тай хамтран “Хүйсийн тэгш эрх төв” ТББ-ын зардлаар 2023 оны 6 сард эх орондоо ирсэн. ЭСЯ-наас Консулын хамгаалалт зохион байгуулж зочид буудалд байршуулсан. Түүнчлэн Бүгд Найрамдах Турк, Бүгд Найрамдах Филиппин болон Камбожийн Хаант Улсад зорчиж байсан Монгол Улсын иргэд ХХГХ-ийн хохирогч болсон байж болзошгүй тохиолдол гарсан. Дээрх иргэдийг Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хот дахь ерөнхий консулын газар, Бүгд Найрамдах Сингапур Улс дахь ЭСЯ-ны туслалцаатайгаар эх орондоо ирсэн. Хохирогчдын нийтлэг байдлыг үзвэл:

- Хохирогчид бүгд 21-28 насны эмэгтэйчүүд
- Визгүй зорчдог улсууд руу зорчсон
- Хохирогчид хоорондоо танил, найзууд бөгөөд биесээ уруу татдаг
- Бүгд нэг зуучлагчаар дамжсан байдаг.

ИТС-гийн зарцуулалтын 70-80 хувь нь хилийн чанадад нас барсан иргэдийн шарилыг чандарлуулах, эх оронд нь авч ирэхтэй холбоотой зарцуулагдаж байгаа бөгөөд ХХГХ-ийн хохирогч болсон иргэдэд зарцуулах зарцуулалтад харьцангуй бага байна. Иймд эл төрлийн гэмт хэргийн хохирогчид зарцуулах

зориулалтаар зарцуулах төсвийг тусад нь тусгаж батлуулах шаардлагатай юм. Хилийн чанадад 49 ЭСЯ, ДТГ-ууд байгаагаас өөрөө байртай 23, түрээсийн байртай 26 газар байгаа бөгөөд өөрийн байртай газруудын хувьд иргэдийг консулын хамгаалалтад авах боломжтой Бээжин, Дели, Анкара, Астана дахь ЭСЯ болон Кызыль, Улаан-Үүд, Эрээн дэх консулын газруудын хувьд боломжтой байна.

Иймд цаашид ДТГ бүрийг зайлшгүй шаардлагатай үед иргэдийг консулын хамгаалалтад авах байрыг бэлтгэх, боломжгүй тохиолдолд хөнгөлөлттэй нөхцөлөөр буулгах зочид буудалтай гэрээ хийсэн байх, хохирогчийг хамгаалалтад авах байртай болох энэ чиглэлийн төсөл хөтөлбөрт хамрагдахад анхаарах зэрэг саналыг зөвлөмжид тусгаж өгөх шаардлагатай байгаа талаар дурджээ.

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.3.4. Гадаад улсын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын насанд хүрээгүй иргэний эрх, ашиг сонирхлыг хамгаалах

Гадаадын иргэн харьяатын газар нь Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэн гэр бүлд үрчлүүлэх чиг үүргийн хүрээнд Монгол Улс 1990 онд нэгдэн орсон “Хүүхдийн эрхийн тухай” НҮБ-ын конвенц, 1998 онд нэгдэн орсон Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенц, 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хууль, 2010 онд батлагдсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, 1999 онд батлагдсан Харьяатын тухай хууль болон Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2001 оны 100/32 дугаартай тушаалаар батлагдсан “Гадаадын иргэнд Монгол улсын хүүхдийг үрчлүүлэх журам, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ыг мөрдлөг болгон ажилладаг бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газарт 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 11 хүүхэд үрчлэгдсэн байна⁵⁰ гэсэн статистик гарчээ.

Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдлыг дүгнэвэл хуулийн дагуу холбогдох журмыг батлан хэрэгжүүлсэн нь “зорилтдоо хүрсэн” байна. Харин практикт нийцэж буй байдал, хүлээн зөвшөөрөгдсөн байдлын хувьд дутагдалтай. Учир нь уг журмыг хэрэгжүүлэгч болон харилцаанд оролцогч төрийн бус байгууллагуудын өгсөн ярилцлагад болон Дэд зөвлөлийн тайлангуудад дээрх журмын хэрэгжилт санхүүжилтээс шалтгаалан хангалтгүй хэрэгжиж байгаа, уг журмын хэрэгжилтийг төрийн бус байгууллагууд хэрэгжүүлдэг талаар дурджээ.

⁵⁰ “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийн тайлан” (2021)

4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал:

ХХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.4-д Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэхээр зохицуулсан асуудлыг тус хэсэгт дэлгэрүүлэн авч үзнэ.

ХХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.4.1. Энэ хуулийн 12.1.3-д заасан үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих

ХХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтад “ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах” талаар хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээг тусгаж, холбогдох журмыг батлахыг Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгасны дагуу Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2015 оны 7-р сарын 09-ний өдрийн А/135 дугаар тушаалаар “Ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах журам”-ыг батлан гаргажээ. Тус журам нь (1) ажлын байраар хангах, (2) мэргэжлийн ур чадвар олгох сургалтад хамруулах үндсэн зорилготой⁵¹ байна.

Журмын 1 дүгээр зүйлийн 1.2-д Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан хохирогчоор тодорхойлогдсон иргэнд үйлчилгээ үзүүлэхийг заасан. Харин журмын 1 дүгээр зүйлийн 1.3-д хохирогчийг мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байраар хангах ажлыг “Тахарын алба”-тай хамтран хэрэгжүүлнэ гэж заасан нь Тахарын алба татан буугдсантай холбоотойгоор хариуцах эзэнгүй болсон байна.

Хохирогч эдгээр үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ ХХГХ-тэй тэмцэх, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Дэд зөвлөлд гаргаснаар, Дэд зөвлөл уг хүсэлтийг судалж Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа мэдээллийн үндэсний төвд хүргүүлж үйлчилгээ авахыг тухайн журмын 3 дугаар зүйлийн 3.2-3.4 дэх хэсгүүдэд заажээ. Гэтэл журмын энэ зохицуулалт нь ХХТХ-д заасан Дэд зөвлөлийн бүрэн эрхэд хамаарахгүй эрх хэмжээ хэрэгжүүлэхээр байгаа нь хуультай зөрчилдсөн журам батлан гаргасан байна.

Гэтэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн мэдээлэлд журам батлагдсанаар 2019 оноос хойш ХХГХ-ийн хохирогч 52 хүнийг мэргэжлийн сургалтад хамруулж, үйлчилгээ үзүүлээд байна. Мөн хохирогчийг ажлын байртай болгох чиглэлээр ХХГХ-ийн хохирогч 20 хүнийг жижиг бизнесийн дэмжих үйл ажиллагаанд хамруулсан талаар дурджээ.

⁵¹ Монгол Улсын Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.

Мөн журмын хэрэгжилтийг хангах зорилгоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/16 дугаар тушаалын 9 дүгээр зүйлийн 9.6-д ХХГХ-ийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах талаар тусгажээ.

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.4.2. Хохирогчийг хамгаалах, халамж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, туслалцаа үзүүлэх

ХХГХ-тэй тэмцэх талаар дэмжигч болон ажиллагч гэсэн хоёр чиглэлээр төрийн бус байгууллагууд ажиллаж байна. Хохирогчид шууд туслалцаа үзүүлж ажилладаг хоёр байгууллага байна. Бусад төрийн бус байгууллага нь дэмжигч байгууллагын чиглэлээр ажиллаж байна.

ХНХЯ-аас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.2-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр БНСУ-ын Жендэрийн тэгш эрх, гэр бүлийн яамтай хамтран “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх” төслийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлж, гүйцэтгэгчээр “Хүйсийн тэгш эрх төв” ТББ ажиллаж байна хэмээн мэдээлэл ирүүлжээ.

5. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал

ХХТтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт хүн худалдаалахтай тэмцэх талаар Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг тусгайлан хуульчилсныг тус хэсэгт дэлгэрүүлэн авч үзнэ.

ХХТтХ-ийн 5.5.1. Хүн худалдаалахтай тэмцэх хуулийн 12.1.1, 12.1.2-д заасан үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих

ХХТтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ”, 12.1.2-д “сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ” үйлчилгээ үзүүлэх журмыг тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д зааснаар Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан хэрэгжүүлэхээр тусгажээ.

Гэсэн хэдий ч 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасан “Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам” одоог хүртэл батлагдаагүй байна. Шалтгааныг Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газраас ирүүлсэн албан бичигтээ “Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуульд “Эрүүл мэндийн нөхөн сэргээх” гэдэг нэр томъёо байдаггүй

учраас дээрх журмыг батлан гаргах боломжгүй...” хэмээжээ. Харин уг үйлчилгээг Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 356, А/182 дугаар тоот тушаалаар Гэрч хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журмын дагуу хэрэгжүүлж байна. Гэхдээ ХХГХ-ийн хохирогчид үзүүлсэн үйлчилгээг тусад нь бүртгэдэггүй тул ХХГХ-ийн хэдэн хохирогчид үйлчилгээ үзүүлсэн талаарх мэдээллийг гаргах боломжгүй байдаг байна.

ХХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.2-д заасан “Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам”-ыг Эрүүл Мэндийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 462 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Уг журмын зорилго нь ХХГХ-ийн хохирогч болсон, сэтгэл зүйн цочмог болон архаг хариу урвалууд илэрсэн, сэтгэц, зан үйлийн эмгэг (айдсын эмгэг, сэтгэл түгших, нойрны, биеийн хэлбэрийн, сэтгэл гутрах ба мэтгэл хөөрөх эмгэг, гэмтлийн дараах стрессийн эмгэг, дасан зохицохуйн эмгэг, хувирах болон хуваагдах эмгэг, солиорох эмгэг)-т өртсөн өвчтөнүүдэд сэтгэцийн эрүүл мэндийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээ үзүүлэхэд оршино гэжээ. Мөн энэхүү журмыг сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд мөрдөж ажиллаж байна. Тус журамд ХХГХ-ийн хохирогчдод сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ Өвчний олон улсын 10-р ангиллыг баримтлан оношилгоо, эмчилгээний дараах стандартуудыг мөрдөнө гэж заасан байна. Үүнд:

- MNS 5481- 5:2005, Айдас эмгэгийн оношилгоо, эмчилгээ
- MNS 5481- 6:2005, Биеийн хэлбэрийн өвчний оношилгоо, эмчилгээ
- MNS 5929-2008, Уй гашуу тохиолдох үеийн сэтгэлзүйн оношилгоо
- MNS 5935-2008, Өөрийгөө сургах дасгал (тайвшруулах буюу булчин сулруулах) хамаарна гэжээ.

Түүнчлэн ХХГХ-ийн хохирогчид сэтгэцийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхийг тусгайлан зохицуулсан Стандартчиллын үндэсний зөвлөлийн баталсан MNS 6418:2013, ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих, нийтлэг шаардлага⁵², стандарт батлагдаж, хэрэгжиж байна.

2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд дараах гэмт хэргийн хохирогчдод тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

- Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн 14, Гэр бүлийн хүчирхийллийн 1 хохирогчид тус тус сэтгэцийн эмчийн үзлэг, сэтгэл зүйн оношилгооны тестээр оношилж, эмийн болон сэтгэл заслын эмчилгээг хийсэн байна.

Хохирогчдыг асран хамгаалагч нь эмнэлэгт авчирсан 10 тохиолдол, Гэр

⁵² Монгол Улсын Стандарт, MNS 6418:2013, *Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих, нийтлэг шаардлага*, (2013)-ын 2 дугаар зүйлийн 2.2.3 дахь хэсэг.

бүл хүүхэд залуучуудын газар 108 төвөөс ирсэн 4 тохиолдол, Төрийн бус байгууллагаас дамжин хандсан 1 тохиолдол тус тус бүртгэгджээ.

Эдгээрээс үзвэл хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасан хэм хэмжээ “зорилтдоо хүрээгүй”, буюу батлагдаагүй байна. Зорилтдоо хүрээгүй тул “практикт нийцсэн байдал”, “хүлээн зөвшөөрөгдсөн байдал”-ыг үнэлэх боломжгүй юм.

Харин ХХТТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.2-д заасан журам батлагдсан байх “зорилтдоо хүрсэн” гэж үзэх үндэстэй. Түүнчлэн уг журмын дагуу бэлгийн хүчирхийллийн 14, гэр бүлийн хүчирхийллийн 1 хохирогчид тус тус сэтгэцийн эмчийн үзлэг, сэтгэл зүйн оношилгооны тестээр оношилж, эмийн болон сэтгэл заслын эмчилгээг хийсэн байх тул “практикт нийцсэн” гэж үзнэ. Гэтэл уг журмын хэрэгжилтийн талаар хийсэн чанарын судалгаагаар практикт зөвхөн “асуултын дагуу сэтгэцийн байдлыг тогтоож байгаа, эмчилгээ хийх боломжгүй байдаг” нь тогтоогдсон⁵³. Иймд журмын “хүлээн зөвшөөрөгдсөн байдал”-ыг хангалтгүй гэж үзнэ.

ХХТТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5.2. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх асуудлаар эмнэлгийн байгууллагын ажилтанд сургалт явуулах

ЭМЯ-аас ирүүлсэн албан бичиг болон ярилцлагын судалгаанд хамрагдсан эмч, ажилтнуудын мэдээллээс үзвэл хүн худалдаалахтай тэмцэх тухай сургалт, сурталчилгаа, мэдээллээр хангах ажил хангалтгүй байна. Үүнийг сайжруулах, цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллах, бусад төрлийн гэмт хэргээс ХХГХ-ийг хэрхэн ялгах, ялгаатай эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрхэн хүргэх талаар сургалт, мэдээлэл хэрэгцээтэй байгаа тухай илэрхийлжээ.

⁵³ Чанарын судалгаа, ярилцлага: СЭМҮТ-ийн эмч

Шигтгээ 12. Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн эмч, эмэгтэй

Хууль цагдаагийн байгууллагаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, мэдээллээр хангах ажлаа эрчимжүүлэх, эрүүл мэндийн салбар нь өөрөө гэмт хэргийн хохирогч болсон хүний эрүүл мэндийн үнэлгээ, тусламж үйлчилгээ талаасаа хуулийн байгууллагадаа сургалтаа хийх гэх мэт хамтарсан ажил хэрэгтэй байна. Аль аль талдаа ийм ажил байдаг гэдгээ мэдээд байгаа хирнээ тус тусдаа яваад байна. Бэлгийн хүчирхийлэл, дарамтад өртсөн гээд ирж буй хүмүүсийг ХХГХ-ийн хохирогчийг хэрхэн тодорхойлох вэ? энэ төрөлд хамаатуулж ойлгох уу үгүй юу? гэдэг талаар мэдэхгүй, гэмт хэргийн хохирогчийн цөөнгүй хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдаг.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн мэдээллийг ЭМЯ-ны тайланд давхар явуулдаг. Жишээлбэл 2022.01 сараас 2023.04 сар хүртэлх хугацаанд хүчирхийллийн хохирогч болсон хүүхдийн мэдээллээс харахад 15 хүүхэд бүртгэгдсэнээс 14 нь бэлгийн хүчирхийллийн хохирогч энэ нь магадгүй үүнийг нарийн судалбал гэмт хэргийн шинж нь өөрөө хүн худалдаалах байсан уу үгүй юу гэдгийг хэлж мэдэхгүй байгаад байна. Яг юуг нь хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг вэ? авч яваад наймаалцсанаа хэлдэг үү? Эсвэл бэлгийн хүчирхийллийн тохиолдол болгоноо хэлээд байгаа юу? гэдгээ ялгахгүй байна. Төрийн байгууллагуудын мэдээлэл бүртгэлүүд нь ялгаатай байгаад байна нэгдсэн болгомоор байна. Онош тогтоох, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх 14 хүүхдийн 12 нь хүүхэд өсвөр үе клиникт хэвтэн эмчлүүлсэн үүнээс 8 нь анх удаа, 4 нь давтан хэвтсэн жишээтэй.

Дээрх ярилцлагаас болон журмын хэрэгжилтийг дүгнэвэл ХХГХ-т хохирсон хохирогчид эрүүл мэндийн үйлчилгээг өрхийн эмнэлэг хэрхэн үйлчилгээ үзүүлэх, яаралтай дуудлагаар ирсэн хохирогчийг хэрхэн хүлээн авч үйлчлэх, эрүүл мэндийн даатгалыг төлөөгүй тохиолдолд олон жилээр нөхөн төлөх үү эсвэл үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх үү, даатгалын зохицуулалтаар шийдвэрлэх нь зүйтэй юу зэрэг журмын зохицуулалт байхгүй байгаагаас хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх асуудал тодорхойгүй нөхцөл байдал үүсгэж байна. Мөн түүнчлэн бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдыг бүртгэх бүртгэлүүдэд “хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч” гэсэн нарийвчилсан байдлаар тоон мэдээллийг гаргадаггүйгээс дүн шинжилгээ хийх, тоон мэдээлэл гаргах, улмаар хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх боломжгүй, тодорхойгүй байдал үүсгэж байна.

6. Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал

ХХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт зохицуулсан хүн худалдаалахтай тэмцэх талаар Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагийн хэрэгжүүлсэн чиг үүргийг энэ хэсэгт дэлгэрүүлэн авч үзнэ.

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.6. дахь заалт

- 5.6.1. Боловсролын байгууллага, оюутан, сурагчдын дунд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах*
- 5.6.2. Хүн худалдаалахын хор уршиг, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тайлбарлан таниулах талаар ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөр, стандартад тусгах*

Хэдийгээр ЕБС-ийн шинэчилсэн сургалтын хөтөлбөрт хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох сэдвүүдийг насны онцлогт тохируулан тодорхой хичээлүүдэд тусгасан ч хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ, түүний хэлбэрийг танин мэдэх, урьдчилан сэргийлэх талаар тухайлсан бүлэг сэдэв аль нэг хичээлд хараахан тусгагдаагүй байна. Холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр салбар бүрийн тухайлсан сэдвийг ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт багтаах нь цаг хугацаа болоод нөөцийн хувьд хязгаарлагдмал байдаг. Иймд тохиолдол шинжлэх замаар аливаа гэмт хэргийн төрөл, хэлбэрийг ялган таних агуулгыг ахлах ангийн сургалтын хөтөлбөрт тусгадаг талаар дурдаж байв. Тусгайлсан ХХГХ-ийн эсвэл бусад гэмт хэргүүдийн агуулгыг нэг бүрчлэн ЕБС-ийн сургалтын агуулгад тусгана гэхээр сургалтын цаг хүрэлцдэггүй. Иймд багш нар ерөнхий ойлголт мэдлэгээ өгөөд, дараа нь тохиолдол шинжлэх, жишээ тайлбарлах замаар тухайн хэргийг задалж, таниулдаг. Тухайлбал, авто тээврийн осол, ХХГХ-ийн тохиолдлуудыг авч үзэх замаар тэдгээрийн төрөл, хэлбэрийг таниулна гэсэн санаа юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/253, А/252 дугаар хамтарсан тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий сайн дурын “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалт, чадавхжуулах, сургуулийн эргүүлийн үйл ажиллагаатай уялдуулах, бүлгэмийн үйл ажиллагааны журмыг баталсан. Ингэснээр хүүхдийн үе тэнгийн зөрчил, хэрэг, хүүхдүүд бие биеэ уруу татах, урьдчилан сэргийлэх, эрх зүйн хэм хэмжээний талаар мэдлэг олж авах боломж бүрдэж байгаа нь цаашид гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад ач холбогдолтой гэж үзэж байна гэжээ.

Дээрх ирүүлсэн мэдээллээс үзвэл боловсролын салбарт ХХГХ-тэй холбоотой урьдчилан сэргийлэх, хүүхдүүдийг энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдээлэл, мэдлэгтэй болгох талаарх чиглэсэн сургалт явуулдаг талаарх мэдээлэл байсангүй.

7. Цагдаагийн болон тагнуулын байгууллагын бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байдал

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.7. Цагдаагийн болон тагнуулын байгууллага нь хүн худалдаалах үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, хүн худалдаалахтай холбоотой зар сурталчилгаанд хяналт тавина

Цагдаагийн байгууллагын албан хаагчийн өгсөн ярилцлага болон шүүхийн шийтгэх тогтоолд дурдсан хэргийн оролцогчийн мэдүүлгээс үзвэл ХХГХ нь цахим орчинд тэр дундаа фэйсбүүк хуудаст “Санхүү авна, өгнө”, “SS авна” “Гулгаа массаж хийнэ” гэх зарын дор холбон зуучилж, хөгжиж байна. Үүнийг тухайн цахим хаяг болон веб сайтыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос хааж шийдвэрлэж байгаа хэдий ч шинээр үүсэх цахим хаягийн тоо буурахгүй байна. Харин саун, массажны газрыг тусгай зөвшөөрлийн дагуу ажиллуулдаг хуулийн зохицуулалт хүчингүй болсонтой холбоотой ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба тухайн саун массажны газарт шалгалт хийх эрх хэмжээгүй болж, хяналт тавих боломжгүй болсон гэжээ. Иймд энэ чиглэлээр хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиг үүргийн хэрэгжилт зогссон байна.

8. Улсын хил хамгаалах байгууллагын бүрэн эрхийн хэрэгжилт

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.8. Хүн худалдаалахтай тэмцэх талаар улсын хил хамгаалах байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ

- 5.8.1. Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа хүүхдийн биеийн байцаалтыг тодруулах, итгэмжлэлийн үндсэн дээр бусдын хүүхдийг харгалзан яваа этгээдийн биеийн байцаалт, ямар зорилгоор хүүхдийг дагуулан явж байгаа, тухайн хүүхэдтэй ямар холбоотой болох, хүлээн авагч гадаад улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг шалгаж нягтлах*
- 5.8.2. Итгэмжлэлийн үндсэн дээр гадаад улсад зорчиж байгаа хүүхэд тухайн улсад удаан хугацаагаар сурах, амьдрах тохиолдолд хүлээн авах этгээдийн талаарх мэдээллийг нягтлах*
- 5.8.3. Улсын хилээр хамт гарсан насанд хүрээгүй хүнийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд эргэж ирээгүй шалтгааныг нь тодруулах, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх*

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тогтоолоор “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ыг баталж, хүүхдийг асран хамгаалагчаас өөр хүн харгалзан авч явж байгаа бол итгэмжлэлийг шалгах, тухайн иргэн хүүхдийн гадаад улсад үлдээх шаардлага гарвал эцэг, эхийн овог нэр, төрсөн он, сар, өдөр, баримт бичгийн хуулбар,

холбоо барих мэдээлэл зэргийг бүрэн баримтжуулж авч үлдэх, эргэлзээтэй тохиолдолд цагдаагийн байгууллагад шилжүүлж байна. 2022 онд 102 хүүхэд гадаадад үлдсэнээс 29 хүүхэд итгэмжлэлээр гарсан бол 73 хүүхэд эцэг, эхийн хамт хилээр гарч, гадаадад үлджээ.

Шигтгээ 13. ХХЕГ-ын мэргэжилтэн, эрэгтэй, 10 гаран жил ажилласан.

Хуулийн хүрээнд хамгийн сайн хэрэгжиж буй журам гэж үзэж байгаа. Бас нэг асуудалтай зүйл яригдана жишээ нь 16-17 настай хүүхдүүд гадаадад зорчиход аль нэг улсад суралцахад тухайн хүүхдийг итгэмжлэлээр авч явах хүн олддоггүй асуудал байдаг. МУ-ын хуульд заавал 18 настай хүн л насанд хүрсэн тэрнээс доош настай бол хүүхэд буюу эрх зүйн бүрэн чадамжгүй гэж заасан байдаг нь асуудал үүсгэдэг. Гадаадад байгаа хүн бол консулын байгууллагаар дамжуулан хэн нэгэн хүнд итгэмжлэл хийлгээд өгдөг яг сурч байгаа хүүхдийн хувьд боломж байхгүй байна.

Дүгнэвэл, энэ журмын агуулга нь хүүхдийг хилээр гаргах асуудалд голлон анхаарч хяналт тавьж байгаагаас ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлийг анхаарсан зохицуулалтгүй байна.

9. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хэрэгжилт

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.10 Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих бүрэн эрхийг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

2021 онд Монгол Улсад ХХГХ-ийн хохирогч болсон байж болзошгүй гадаадын иргэний мэдээлэл бүртгэгдээгүй байна. Харин ОУШХБ-ын мэдээлэлд дурдсанаар дараах 2 гадаадын иргэнийг эх оронд нь буцаажээ.

Шигтгээ 14. ГХЯ-ны Консулын газрын 3-р нарийн бичгийн дарга

Гэр бүлийг эргэн нийлүүлэх хөтөлбөр"-ийн санхүүжилтээр АНУ-д ХХГХ-ийн хохирогч болсон нэг эмэгтэйн гэр бүлийн нэг гишүүнийг АНУ-руу явууллаа. Мөн "Өөрийн хүсэлтээр эх орондоо эргэн ирэх хөтөлбөр"-ийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэрэг, хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болсон нэг иргэнийг Швейцар Улсаас эх орондоо аюулгүй эргүүлэн авчирсан.

10. Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийн хэрэгжилт.

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.11. Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүн худалдаалахад өртөх эрсдэлтэй хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж, сургалт, судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, санал боловсруулна.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр тусгайлсан сургалт, сурталчилгаа явагдаагүй байна.

11. Бүх шатны нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрхийн хэрэгжилт

ХХТмХ-ийн 5 дугаар зүйлийн 5.12. Бүх шатны нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

5.12.1. Нутаг дэвсгэртээ хүн худалдаалахтай тэмцэх, шалтгаан нөхцөлийг нь тогтоож арилгах арга хэмжээг авах

5.12.2. Хохирогчдод үзүүлэх халамж, үйлчилгээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

5.12.3. Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах;

5.12.4. Хүн худалдаалахтай холбоотой байж болзошгүй зар сурталчилгаанд харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хяналт тавих

ХХТмХ-ийн 13.4. Хохирогч хүүхдийг зохих шатны сургуульд хамруулах үүргийг тухайн сум, дүүргийн Засаг дарга хариуцна

Дээрх заалтуудын хэрэгжилтийн талаар ярилцлагад оролцсон дүүргүүдийн Засаг даргын тамгын газрын ажилтнуудын мэдээллээс үзвэл, ХХТХ-ийн тухай мэдлэг, мэдээлэл, хэрэгжилтийн талаарх ойлголт хангалтгүй байна. Бусад төрлийн гэмт хэргийн мэдээлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хуулийн байгууллагатай хамтарч зурагт хуудас тараах, ЕБС-уудад мэдээлэл хүргэхээс хэтрэхгүй байна.

Шигтгээ 15. Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч, эрэгтэй, 4 жил ажилласан.

ХХТХ-ийн хэрэгжилт БЗД-ийн хэмжээнд ямар ч хэрэгжилтгүй байна. Хуулийн тухай мэдлэг, хэрэгжилтийн талаарх ойлголт маш хангалтгүй мэдэхгүй байгаа. Урьдчилсан сэргийлэх ажлын хүрээнд бага насны хүүхдийг гэмт хэрэгт өртсөн эсэхэд хэрвээ өртсөн юм шиг мэдрэмж байвал холбогдох газарт нь мэдэгдээрэй гэсэн сурталчилгаа, ийм чиглэлийн агуулгатай номыг хэвлүүлээд ЕБС-ийн сурагчдад тараасан байна. Энэ нь яг бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлтэй холбоотой ажлыг зохион байгуулсан боловч хүн худалдаалах урьдчилсан сэргийлэхтэй холбоотой манай зөвлөл ажиллаагүй байна. ЕБС-ийн 34 сургуулиудад боломжит хэмжээгээр тараасан. Хамгийн сүүлд прокурорын газартай хамтраад 4000 гаруй номыг тараасан. Хүн худалдаалах гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс энэ номыг гаргаагүй хүүхдүүдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах чиглэлээр гаргасан.

12. Дэд зөвлөлийн бүрэн эрхийн хэрэгжилт

ХХТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1-6.5 дахь хэсэгт Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн, үүрэг, үйл ажиллагааны зардал зэргийг зохицуулжээ.

Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг 2021 оны 01 дугаартай Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн тогтоолоор Хууль зүй, Дотоод хэргийн сайд баталжээ. Уг журамд зааснаар Дэд зөвлөл нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомж журмыг удирдлага болгон ажиллаж, жилд хоёроос дээш удаа хуралдаж, энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлын талаар сонсож, салбар дундын уялдаа, хамтын ажиллагааны талаар хэлэлцсэн үйл ажиллагааныхаа үр дүнг хагас бүтэн жилээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга болон Хууль зүй, Дотоод хэргийн сайдад тайлагнахаар зохицуулжээ.

ХХТмХ-ийн 6 дугаар зүйлийн 6.6. Дэд зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 6.6.1. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тайлан мэдээллийг сонсох, шалгалт явуулах, зөвлөмж гаргах;*
- 6.6.2. Хүн худалдаалах нөхцөл байдлын талаар мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагаар судалгаа хийлгэх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөр уламжлан Засгийн газарт оруулах;*
- 6.6.3. Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр бусад орны холбогдох байгууллагатай хамтран ажиллах чиглэл гаргаж хэрэгжүүлэх;*
- 6.6.4. Хүн худалдаалахтай тэмцэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, хамтран ажиллах, санал санаачилгыг нь дэмжих, олон нийтэд чиглэсэн урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;*
- 6.6.5. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомж зөрчсөн, гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцөлийг бүрдүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэх саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд гаргах, биелэлтийг шаардах;*
- 6.6.6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг энэ хуулийн 16.5–д заасан журмын дагуу урамшуулах арга хэмжээ авах;*
- 6.6.7. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгуулах талаар санал боловсруулах;*
- 6.6.8. Хүн худалдаалах, түүний хор уршгийн талаарх нэгдсэн мэдээг гаргах;*
- 6.6.9. Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээний стандартын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;*
- 6.6.10. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагын ажилтныг мэргэшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.*

Дээрх бүрэн эрхийн хэрэгжилтийг ГХУСАЗЗАА-аас ирүүлсэн Дэд зөвлөлийн “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017-2021 оны үйл ажиллагааны тайлан”-гийн биелэлтээс үзвэл:

Хүснэгт 6. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх
2017-2021 оны үйл ажиллагааны тайлангийн биелэлт

Он/төлөвлөсөн үйл ажиллагаа	6.6.1	6.6.2	6.6.3	6.6.4	6.6.5	6.6.6	6.6.7	6.6.8	6.6.9	6.6.10	НИЙТ
2017/25	4	4	-	14	-	-		-	-	3	25
2020/55	14	6	-	13	-	-	2	-	-	12	47
2021/35	12	2	5	2	-	-	1	-	-	8	30

Хүснэгтээс үзвэл Дэд зөвлөл хуульд заасан хэрэгжүүлэх ёстой бүрэн эрхийн 6.6.1 буюу тайлан мэдээг сонсох, уялдуулах, 6.6.2 ба 6.6.4, 6.6.10-т заасан сургалт, судалгаа хийх ажлыг түлхүү хийдэг нь харагдаж байна. Харин 6.6.3, 6.6.5, 6.6.6, 6.6.7, 6.6.8, 6.6.9 заасан шалгалт явуулж, холбогдох санал, зөвлөмжийг гаргах, хүргүүлэх, шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгуулах санал гаргах, түүнийг зарцуулах, урамшуулах ажлыг хангалтгүй хийжээ. Нэгтгэвэл, Дэд зөвлөлд олгосон бүрэн эрхийн 50 хүрэхгүй хувийг хэрэгжүүлдэг байна. Шалтгаан нь дээрх Дэд зөвлөлд олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлэх, хянах, зөвлөх эрх мэдэл бүхий Дэд зөвлөл нь тус тусдаа бие даасан төрийн байгууллагуудын төлөөлөл бөгөөд төрийн тогтолцооноос тусдаа институт учир өөрийн гаргаж байгаа шийдвэрээ хэрэгжүүлэх төсөвгүй, дэд бүтэцгүй, шийдвэр нь заавал биелэгдэх шинжгүй, эрх мэдэлгүй тул бусад байгууллагын тайлан мэдээг сонсох төдийгөөр хүн худалдаалахтай тэмцэх ажлыг хэрэгжүүлж байгаа нь тайлангуудаас харагдаж байна.

Харин ГХУСАЗЗАА-ны даргын 2021 оны А/17 дугаартай тушаалаар АНУ-ын Засгийн газар болон МУ-ын Засгийн газар хоорондын Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний хэрэгжилтийг хангахад салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон ажиллах удирдамжийг баталж, зорилго нь ХХГХ-ийн хохирогч, тэр дундаа хүүхэд төвтэй арга барилаар мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, гэрч, хохирогчид үйлчилгээ үзүүлэх тус гэмт хэргийн бүхий л хэлбэрээс урьдчилан сэргийлэх таслан зогсооход салбар дундын хамтын ажиллагаа уялдаа холбоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр “Салбар дундын хамтарсан баг”-ийг туршилтын журмаар байгуулжээ. Туршилтаар уг хамтарсан багийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа талаар талууд илэрхийлсэн байна.

13. Хуулийн этгээдийн чиг үүргийн хэрэгжилт

ХХТмХ-ийн 7 дугаар зүйл.

- 7.1. Хуулийн этгээд нь хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах ажлын хүрээнд хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн заавар, зөвлөмж, мэдэгдэл, шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.*
- 7.2. Хуулийн этгээд нь үйл ажиллагааныхаа халхавчин дор хүн худалдаалах үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдвол тухайн хуулийн этгээдийг шүүхийн шийдвэрээр татан буулгана.*

ХХТмХ-ийн 7 дугаар зүйлд ХХГХ-тэй тэмцэхэд хуулийн этгээд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн заавар, зөвлөмж, мэдэгдэл, шаардлагыг биелүүлэх үүрэгтэйг тусгажээ. Мөн түүнчлэн үйл ажиллагааныхаа халхавчин дор хүн худалдаалах үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдвол тухайн хуулийн этгээдийг шүүхийн шийдвэрээр татан буулгана гэж зохицуулсан бөгөөд бидний ХХГХ-ийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээгээр ийм тохиолдолд гарч байгаагүй буюу бүртгэгдээгүй байна.

14. Хэвлэл, мэдээллийн байгууллагын чиг үүргийн хэрэгжилт

ХХТмХ-ийн 8 дугаар зүйл.

- 8.1. Хэвлэл, мэдээллийн байгууллага дор дурдсан зар сурталчилгаа, мэдээлэл тараахыг хориглоно:*
 - 8.1.1. хохирогчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр хохирогчийн талаарх мэдээлэл;*
 - 8.1.2. гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах тухай зар сурталчилгаа;*
 - 8.1.3. хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд хүргэхүйц бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, холбоо, цахим сүлжээ ашигласан ил буюу далд зар сурталчилгаа.*

Хэвлэл, мэдээллийн байгууллага нь хохирогчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр хохирогчийн талаарх мэдээлэл, гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах тухай зар сурталчилгаа, ил болон далд сурталчилгаа явуулахыг хориглодог байна.

3.3. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГА ХЭЛБЭР ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

ХХТмХ-ийн 9 дүгээр зүйлд хохирогчийн нэр төр, алдар хүнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор хамгаалах байранд байрлуулах, хамгаалах байрны бүтэц зохион байгуулалт, ажиллах журмыг Засгийн газар баталж, үйл

ажиллагааг нь төрийн бус байгууллагад хариуцуулж болох тухай зохицуулжээ. Гэсэн хэдий ч одоогоор тухайн хамгаалах байрны журам батлагдаагүй ба практикт ХХГХ-ийн хохирогч түр хамгаалах байранд Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу батлагдсан журмын дагуу байрлаж байна.

ХХТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4-д хамгаалах байрны журмыг Засгийн газар батална гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон Монгол Улсын Засгийн газрын чиг үүрэг, бүрэн эрхэд хамаарахгүй асуудал юм.

ХХТХ-ийн 10 дугаар зүйлд хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хохирогчийн нэртөр, алдар хүндийг хамгаалж, хувийн мэдээллийг нь бусдад тараахыг хоригложээ. Энэ талаар Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2022 оны 39 дугаартай “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам”-д шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж байгаа шүүхийн шийдвэрийг цахим хуудас буюу “shuukh.mn”-д байршуулахдаа “... шүүхийн шийдвэрт дурдсан хүн, хуулийн этгээдийн нэр, регистрийн болон улсын бүртгэлийн дугаар, оршин суугаа болон үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг, эд хөрөнгийн бүртгэлийн дугаар зэрэг мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нууцлах” байдлаар нийтлэхийг журамлажээ⁵⁴.

ХХТХ-ийн 11 дүгээр зүйлд гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт ХХГХ-т өртсөн тохиолдолд хамгаалах, шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх хүртэл оршин суух зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх талаар эрх бүхий байгууллага хариуцахыг даалгажээ. 2021 оны байдлаар Монгол Улсад ХХГХ-ийн хохирогч болсон байж болзошгүй гадаадын иргэний мэдээлэл бүртгэгдээгүй байна⁵⁵.

ХХТХ-ийн 12 дугаар зүйлд хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээг үзүүлэхтэй холбогдох журмыг батлан хэрэгжүүлэхийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгасан бөгөөд энэ талаар 5 дугаар зүйлийн хэрэгжилтийн байдлаас дэлгэрүүлэн үзнэ үү.

ХХТХ-ийн 13 дугаар зүйлд хохирогч хүүхдийг хэрхэн хамгаалах талаар зохицуулсан бөгөөд 13.4 дүгээр зүйлд хохирогч хүүхдийг зохих шатны сургуульд хамруулах үүргийг тухайн сум, дүүргийн Засаг даргад хариуцуулахаар даалгасан байна. Ярилцлагын явцад Засаг дарга ХХГХ-ийн хохирогчийг сургуульд хамруулах талаар зохицуулалт хэрэгждэггүй талаар хамгаалах байрны нийгмийн ажилтнууд ярилцлагад дурдсан хэд хэдэн тохиолдол гарсан. Сургууль завсардах, боловсрол эзэмшүүлэхэд төрийн бус байгууллагын нийгмийн ажилтан анхаардаг ба хамгаалах байранд байгаа хохирогчийг харьяаллын бус гэх үндэслэлээр сургуульд хамруулдаггүй, хамруулсан ч тухайн хохирогчтой харьцдаггүй, даалгавар өгдөггүй, дүн

⁵⁴ Монгол Улсын Шүүхийн Ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам батлах тухай тогтоол (2022) ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ (judcouncil.mn) сүүлд хандсан: 2023-07-11.

⁵⁵ Дэд зөвлөлийн үйл ажиллагааны тайлан (2021) 2.2.1 дэх хэсгээс...

тавьдаггүй гэх зэргээр эс үйлдэхүйгээр хохирогчид ялгаварлан гадуурхалт үүсгэдэг.

ХХТХ-ийн 14 дүгээр зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлж, таслан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдүүлэг өгсөн гэрч, бодит мэдээлэл өгсөн иргэний аюулгүй байдлыг хангах, иргэдээс төлбөртэй мэдээлэл авах талаар тусгасан хэдий ч энэ хуулийн заалтын талаарх ойлголт олон нийтэд төдийлөн сайн хүрдэггүй, хэрэгжсэн тохиолдол гараагүй.

Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчид хохирол нөхөн төлүүлсэн талаар

ХХТХ-ийн 15 дугаар зүйл.

15.1. Хохирогч нь эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй.

15.2. Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө.

15.3. Хохирогчийн сэтгэл санааны хохирлын хэмжээг түүний нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хохирогчид учирсан гэм хорын хэр хэмжээг харгалзан шүүх тогтооно.

ХХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1-15.3 дахь хэсэгт хохирогч өөрт учирсан эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санаанд учирсан хохирлоо гэм буруутай этгээдээс шаардаж, нөхөн төлүүлэх эрхтэй талаар дурдаж, хохирлын хэмжээг шүүх тогтоохоор заажээ. Шүүхээр эцэслэн шийдэгдсэн хэргийн шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхэд нийтлэг байдлаар “иргэний журмаар нэхэмжлэх эрхтэй” гэсэн уламжлалт хариу бичигдсээр байна. Харин хохирогчдоос өгсөн ярилцлага болон төрийн бус байгууллагын нийгмийн ажилтан өмгөөлөгчид хэлэхдээ шүүхийн тухайн шийдвэр нь практикт хэрэгждэггүй, учир нь эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлсэн өмгөөлөгч үргэлжлүүлэн иргэний хэрэгт нэхэмжлэл гаргаж процессыг үргэлжлүүлэх боломжгүй байдаг.

Энэ нь өмгөөлөгчийн эрүүгийн эрх зүй, захиргааны эрх зүй, иргэний эрх зүй хэмээн тусгайлан дагнан мэргэшиж ажилладагтай холбоотой байж болох бөгөөд эрүүгийн хэрэгт ажилласан өмгөөлөгч иргэний хэрэгт үргэлжлүүлэн ажилладаггүй. Хохирогчийн гэмт хэрэгт өртсөн асуудал нь эрүүгийн эрх зүйн харилцаа байдаг бол хохирол төлбөр нэхэмжлэх нь иргэний эрх зүйн харилцаа юм. Иймд хохирогч дахин төлбөр төлж өмгөөлөгч авах хэрэгцээ үүсэж байгаа нь цаг хугацааны хувьд маш удаан үргэлжилж хохирогч тухайн хэргийн үйл явцыг цааш үргэлжлүүлэхээс эцэстээ залхдаг. Ийм учраас асуудал зөвхөн эрүүгийн хэргийн шүүх хуралдааны шийдвэрээр төгсдөг. Нэгэнт энэ харилцаа эрүүгийн хэрэгт ял шийтгэл оногдуулах үе шатаар төгсөж, хохирогчид цаашид

гарах зардал, сэтгэл санааны хохирлыг нэхэмжилж иргэний шүүхэд ханддаггүй тул үүнээс улбаалан шүүхэд энэ чиглэлийн хохирлыг хэрхэн төлж барагдуулах тухай нэгдсэн заавар, журам байхгүй байна.

2017-2022 оны байдлаар шүүхээр шийдэгдсэн Хүн худалдаалах, Бэлгийн мөлжлөг, Биеэ үнэлэхийг зохион байгуулахтай холбоотой 41 хэргийн тогтоолд дүн шинжилгээ хийхэд:

- 7 хэрэгт 4,132,565 төгрөгийг сэтгэл санааны хохиролд тооцож гаргуулсан,
- 6 хэрэгт цаашид гарах зардлыг иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэй талаар шүүхийн тогтоолд дурдсан,
- 4 хэрэгт хохирлыг хэрхэх талаар шүүхийн тогтоолд дурдаагүй
- 25 хэрэгт хохирогч сэтгэл санааны болон бусад төлбөрийн талаар нэхэмжилсэн эсэхийг дурдаагүй, тодорхойгүй,
- Шүүхээр шийдэгдсэн бүх тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалгүй тухай дурдсан.

Үүнээс үзвэл мөрдөн байцаалтын болон прокурорын хяналтын шат, шүүхийн шатанд гарсан хохирол төлбөрийг нэхэмжлэх, холбогдох баримтыг хэрэгт нотлох баримтаар тооцуулж, шүүх түүнийг үнэлэх талаар хуулийн зохицуулалтын хэмжээнд шийдвэрлэх боломж байгаа хэдий ч практикт түүнийг хэрэгжүүлэхгүй байгаа байдал ажиглагдаж байна.

Зүй нь хохирогчид олгох нөхөн олговрыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар 24 тусгай сан байгаагийн ХХГХ-ийн хохирогчид хамааралтай нь:

1) Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан,

2) Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан гэсэн 2 сангаас нөхөн олговор олгох юм.

1) Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг эрүүгийн хуулийн зүйлчлэлээр зааж өгсөн бөгөөд эрүүгийн хуулийн 13.1 буюу Хүн худалдаалах гэмт хэргийг оруулж өгсөн байна.

Тус сангаас 2012 оноос хойш авч үзвэл, 478 нөхөн төлбөр төлөгч, 468 нөхөн төлбөр авагч байгаа ба нийт 2,648,945,962 төгрөгийг хохирогчдод нөхөн төлбөр хэлбэрээр олгосон боловч үүнд ХХГХ-ийн хохирогчид нөхөн төлбөр олгосон тохиолдол гараагүй байна.

Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тусгай сангаас Монгол Улсад үйлдэгдсэн ХХГХ-ийн улмаас амь насаа алдсан этгээдийн хууль ёсны төлөөлөгч эсвэл хүнд гэмтэл учирсан хохирогч нөхөн төлбөр авах эрхтэй. Ингэхдээ дараах баримтыг бүрдүүлж аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай хүсэлтийг гаргахаар зохицуулжээ. Үүнд:

- Хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шийтгэх тогтоол болон гүйцэтгэх хуудасны хуулбар;
- Өргөдөл гаргагчийн иргэний баримт бичгийн хуулбар;
- Дансны талаар тодорхойлолт;
- Хохирлыг гэм буруутай этгээд буюу түүний хууль ёсны төлөөлөгчөөс барагдуулаагүй, эсхүл дутуу барагдуулсныг нотлох баримт байна.

Харин Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь өргөдлийг хүлээн авч, 30 хоногт нөхөн төлбөрийг шийдвэрлүүлэх саналыг улирал тутам шаардлагатай тохиолдолд сар бүр Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. ХЗДХЯ-ны холбогдох нэгж өргөдлийг хянаад нөхөн төлбөрийг бүрэн эсхүл хэсэгчлэн олгох, нөхөн төлбөр олгохоос татгалзах гэсэн шийдвэрийг гаргадаг. Сангаас олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, нөхөн төлүүлнэ.

Гэсэн хэдий ч дээрх сангаас ХХГХ-ийн хохирогчид хохирол нөхөн олгосон тохиолдол гараагүй тул гэм буруутай этгээдээс тухайн санд төлсөн төлбөрийн талаарх мэдээлэл ч мөн байхгүй байна.

2) Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас нийт 2009 оноос хойш 3,125,239,532 төгрөгийн тусламж гадаадад байгаа Монгол Улсын иргэнд олгосон байна. ИТС-ийн зарцуулалтын 70-80 хувь нь хилийн чанадад нас барсан иргэдийн шарилыг чандарлуулах, эх оронд нь авч ирэхтэй холбоотой зарцуулагдаж байгаа бөгөөд ХХГХ-ийн хохирогч болсон иргэдэд зарцуулах зарцуулалтад харьцангуй бага зарцуулагддаг. 2022-2023 оны байдлаар ХХГХ-ийн хохирогч болсон байж болзошгүй 14 тохиолдлыг ХТЭТ-ийн зардлаар эх оронд нь авчирсан талаар ГХЯ-аас мэдээлсэн байна.

Үүнээс үзвэл ХХГХ-ийн төсөвлөлт, төлөвлөлтийг тусгайлан батлуулж, зарцуулалтыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны санхүүжилтийн зарцуулалтын хэрэгжилт

ХХТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгээр хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны санхүүжилтийг доорх эх үүсвэрээс бүрдүүлэхээр зохицуулсан байна. Тухайлбал:

- (1) Улс орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгө
- (2) Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал
- (3) Гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламж
- (4) Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлуулсан хөрөнгө

(5) Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр зэрэг аргаар санхүүжүүлнэ.

Харин төвлөрсөн санхүүжилтийг хамгаалах байрны үйл ажиллагаанд, мэргэжлийн болон эрдэм шинжилгээний судалгаанд, сургалт, сурталчилгаанд, иргэн, аж ахуй нэгж байгууллагыг урамшуулах, төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх байдлаар санхүүжилтийг зарцуулахаар зохицуулсан байна.

Төрөөс хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр олгож байгаа санхүүжилтийн хувьд авч үзвэл 2018-2023 оны байдлаар Тендер сонгон шалгаруулалтын “tender.gov.mn” цахим хуудаст 35 удаагийн тендерийн урилга зарлагдсан байна. Тухайлбал: Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зөвлөх сонгон шалгаруулахаар: 2018 онд 95 сая төгрөг, 2019 онд 126 сая төгрөг, 2020 онд 114 сая төгрөг, 2021 онд 76 сая төгрөг тус тус төсөвлөсөн байна.

Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжид 299 сая төгрөг, 2022 онд 60 сая төгрөг, 215 сая төгрөг, 2023 онд 50 сая төгрөг, 120 сая төгрөгийн тендерийг тус тус зарласан байна. Харин зарлагдсан тендерийн сонгон шалгаруулалтад хэдэн байгууллага оролцсон, түүнээс шалгарсан хэд, цуцлагдсан талаарх мэдээлэл нийтэд нээлттэй мэдээлэгддэггүй байна.

Иймд хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны санхүүжилт болон зарцуулалтын холбогдох хууль, журмын хэрэгжилтийг практикт нийцсэн болон хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байна.

3.4. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК ТООН МЭДЭЭЛЭЛ

3.4.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан ХХГХ сүүлийн 10 жилийн хугацаанд 68 хүнд холбогдох 91 хэрэг, бүртгэснээс 42 хүнд холбогдох 27 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх санал хүргүүлж, 9 хүнд холбогдох 8 хэргийг нэгтгэж, 1 хэргийг бусад газар шилжүүлж, 17 хүнд холбогдох 49 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн бөгөөд 6 хэргийн үлдэгдэлтэй буюу 29 хэргийг эцэслэн шийджээ.

Хүснэгт 7. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл		13.1	124	12.3	12.6
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Хэрэг	91	94	23	43
	Хүн	69	106	15	29
Шийдвэрлэвэл зохих	Хэрэг	91	94	23	43
	Хүн	69	106	15	29

Бүртгэсэн, хяналт тавьсан	Шийдвэрлэсэн	Хэрэг		85	94	22	36
			Хүн	68	106	15	29
		Яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай хүргүүлсэн	Хэрэг	27	53	11	22
			Хүн	42	69	13	28
		Нэгтгэсэн	Хэрэг	8	23	1	4
			Хүн	9	21	0	1
		Бусад газар шилжүүлсэн	хэрэг	1	0	0	0
			хүн	0	0	0	0
		Хэргийг хэрэгсэхгүй болгосон	Хэрэг	49	18	10	10
			Хүн	17	16	2	0
Тайлангийн эцсийн үлдэгдэл	Хэрэг		6	0	1	7	
	Хүн		1	0	0	0	

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд заасан Бэлгийн мөлжлөг гэмт хэрэг сүүлийн 10 жилийн хугацаанд 15 хүнд холбогдох 23 хэрэг, бүртгэснээс 13 хүнд холбогдох 11 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх санал хүргүүлж, 1 хэргийг нэгтгэж, 2 хүнд холбогдох 10 хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.6 дугаар зүйл анги Биеэ үнэлэхийг зохион байгуулах, Эрүүгийн хууль /2002 он/-ийн 124 дүгээр зүйл “Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах” гэмт хэрэгт нийт 135 хүнд холбогдох 137 хэргийг бүртгэснээс 97 хүнд холбогдох 75 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх санал хүргүүлж, 22 хүнд холбогдох 27 хэргийг нэгтгэж, 16 хүнд холбогдох 28 хэргийг хэрэгсэхгүй болгож, 7 хэргийн үлдэгдэлтэй байна.

Үүнээс дүгнэвэл цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн 29.7 хувийг прокурорын хяналтын шат руу яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай шилжүүлж, 53.8 хувийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

3.4.2. Шүүхээр шийдсэн хэрэг

Монгол Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2013-2023 оны хугацаанд хүн худалдаалах 30 хэргийг хянан шийдвэрлэж 59 хүнийг ял шийтгэсэн байна.

Хүснэгт 8. Хүн худалдаалах гэмт хэрэг шүүхээр
шийдвэрлэгдсэн байдал /2013-2022 он/

ЭХ /2002 он/-н 113 дугаар зүйл, ЭХ /2015 он/-н 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах гэмт хэрэг		2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Шийдвэрлэсэн бүгд хэрэг		1	1	2	0	0	3	6	8	6	3
Ял шийтгүүлсэн бүгд хүн		1	1	5	2	0	5	7	19	10	9
Үүнээс	Урьд ял шийтгүүлсэн хүн	0	0	1	1	0	1	3	11	4	1
	2 дахь удаагаа	0	0	1	1	0	1	3	1	3	1
	3 ба түүнээс дээш	0	0	0	0	0	0	0	0	10	1
Үүнээс	Гэмт хэрэг давтан үйлдсэн	0	0	0	1	0	0	0	0	0	0
	Бүлэглэж үйлдсэн	0	0	5	1	0	3	4	1	0	1
	Согтуугаар үйлдсэн	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Эмэгтэй хүн	1	1	2	1	0	2	2	0	10	3
	Насанд хүрээгүй этгээд	0	0	0	0	0	0	0	0	0	0
Үүнээс эмэгтэй		0	0	0	0	0	0	0	0	0	0
Торгох ял		0	0	0	0	0	0	0	0		0
Албадан ажил хийлгэх ялаар бүгд /Нийтэд тустай ажил хийлгэх ял/		0	0	0	0	0	0	0	0	0	0
Зорчих эрхийг хязгаарлах ял		0	-	-	-	-	-	-	0	0	0
Баривчлах ялаар бүгд		0	0	0	0	0	0	0	0	0	0
Хорих ял оногдуулсан бүгд		1	1	5	2	0	5	7	19	10	9
Хорих ял оногдуулсан бүгд эмэгтэй хүн		1	1	2	1	0	2	2	1	7	9
Үүнээс: Биечлэн эдлүүлсэн эмэгтэй		1	1	0	1	0	2	2	19	7	3

Үүнээс	Хорих ялыг биечлэн эдлүүлэх бүгд	1	1	3	2	0	5	7	19	10	9	
	Тэнссэн	0	0	0	0	0	0	0	0	0	0	
	Тогтоол биелүүлэхийг хойшуулсан	Насанд хүрээгүй этгээд	0	0	0	0	0	0	0	0	0	0
		Жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг	0	0	2	0	0	0	0	0	0	0
Ял шийтгүүлэгсдийн нас	14-15	0	0	0	0	0	0	0	0	0	0	
	16-17	0	0	0	0	0	0	0	0	0	0	
	18-29	0	1	2	1	0	2	2	2	5	7	
	30-34	0	0	2	0	0	1	1	10	3	0	
	35-аас дээш	1	0	1	1	0	2	4	7	2	2	
Боловсрол	Дээд	0	0	2	0	0	1	0	0	1	0	
	Техникийн болон мэргэжлийн анхан шатны	0	0	0	0	0	0	0	0	0	0	
	Тусгай мэргэжлийн дунд	0	0	0	0	0	0	0	0	0	0	
	Бүрэн дунд	1	1	3	0	0	3	4	13	6	4	
	Суурь	0	0	0	0	0	1	1	5	3	2	
	Бага	0	0	0	0	0	0	1	0	0	3	
	Боловсролгүй	0	0	0	2	0	0	1	1	0	0	

Ял шийтгүүлэгсдийн эрхэлж байсан ажил, сургууль	Төрийн албан хаагч	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Оюутан	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Сурагч	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Цэрэг	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Малчин	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Бусад	0	0	2	0	0	1	2	4	1	3
	Эрхэлсэн ажил, сургуульгүй	1	1	3	2	0	4	5	15	9	6
	Ялтан	0	0	0	0	0	0	0	0	0	0
Иргэний харьяалал	Монгол Улсын иргэн	1	1	5	2	0	5	7	19	10	9
	Гадаадын харьяат	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Аль ч улсын иргэн биш	0	0	0	0	0	0	0	0	0	0

Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүний 22 буюу 37.3 хувь нь эмэгтэй хүн, 15 буюу 25.4 хувь нь бүлэглэж үйлдсэн, 22 буюу 37.3 хувь нь урьд ямар нэгэн байдлаар гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдсон иргэн байна.

Ял шийтгүүлсэн иргэд бүгд хорих ялаар шийтгүүлсэн бөгөөд 57 буюу 96.6 хувь нь биечлэн эдэлж, 2 буюу 3.4 хувь нь хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсан байна.


Ял шийтгүүлэгчдийн насны ангиллыг авч үзвэл 22 буюу 37.3 хувь нь 18-29 насны иргэд, 17 буюу 28.8 хувь нь 30-34 насны иргэд, 20 буюу 33.9 хувь нь 35-аас дээш насны иргэд тус тус эзэлж байна.

Боловсролын хувьд 4 буюу 6.8 хувь нь дээд боловсролтой, 35 буюу 59.3 хувь нь бүрэн дунд боловсролтой, 12 буюу 20.3 хувь нь суурь боловсролтой, 4 буюу 6.8 хувь нь тус тус бага боловсролтой болон боловсролгүй иргэд эзэлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд 46 буюу 78.0 хувь эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд байна.

График 2. Хүн худалдаалах гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын хугацаа /2013-2016 он/


Хүн худалдаалах гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын хугацаа /2013-2016 он/



2013-2016 оны хугацаанд хянан шийдвэрлэсэн ХХГХ-т оногдуулсан хорих ялын хугацааг үзвэл 4 буюу 44.4 хувьд нь 5-8 жилийн хугацаагаар хорих ялаар, 5 буюу 55.6 хувьд нь 10-15 жилийн хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэгсэн байна.

График 3. Хүн худалдаалах гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын хугацаа /2017-2022 он/

Хүн худалдаалах гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын хугацаа /2017-2022 он/



2017-2022 оны хугацаанд ХХГХ-т оногдуулсан хорих ялын хугацааг үзвэл 5 буюу 12.2 хувь нь 6 сараас 3 жилийн хугацаагаар хорих ял, 1 буюу 2.4 хувь нь 3-5 жилийн хугацаагаар хорих ял, 13 буюу 31.7 хувь нь 5-8 жилийн хугацаагаар хорих ял, 1 буюу 2.4 хувь нь 8-10 жилийн хугацаагаар хорих ял, 10 буюу 24.4 хувь нь 10-15 жилийн хугацаагаар хорих ял, 10 буюу 24.4 хувь нь 15-20 жилийн хугацаагаар хорих ялаар, 1 буюу 2.4 хувь нь бүх насаар хорих ялаар тус тус ял шийтгүүлсэн.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн 29 буюу 31.9 хувь нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж, цагдаагийн байгууллага өөрөө бүртгэгдсэн гэмт хэргийн 53.8 хувийг хэрэгсэхгүй болгож, прокурорын байгууллага үлдэх 14 орчим хувийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Хорих ялын хугацааны хувьд Эрүүгийн хууль /2002 он/-ийн дагуу оногдуулах ялын хэмжээ багассан бол Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд оногдуулсан хорих ялын дундаж хугацааг харвал 20 буюу 48.8 хувь нь 10-20 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгүүлжээ.

Биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 2013-2017 оны бүтэн жилийн хугацаанд 32 хэрэг хянан шийдвэрлэж 45 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон.

Хүснэгт 9. Биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах хэрэг, шүүхээр шийдвэрлэгдсэн байдал /2013-2017 он/

ЭХ /2002 он/-н 124 дүгээр зүйл Биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах хэрэг		2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Шийдвэрлэсэн бүгд хэрэг		7	7	6	6	6
Ял шийтгүүлсэн бүгд хүн		11	8	9	9	8
Үүнээс	Урьд ял шийтгүүлсэн хүн	2	0	3	2	2
	Үүнээс					
	2 дахь удаагаа	1	0	1	2	1
	3 ба түүнээс дээш	1	0	2	0	1
Үүнээс	Гэмт хэрэг давтан үйлдсэн	0	0	1	1	0
	Бүлэглэж үйлдсэн	2	0	0	1	0
	Согтуугаар үйлдсэн	0	0	2	0	0
	Эмэгтэй хүн	8	6	8	8	5
	Насанд хүрээгүй этгээд	0	0	0		0
	Үүнээс эмэгтэй	0	0	0	8	0
Торгох ял		0	0	0	0	0
Албадан ажил хийлгэх ялаар бүгд		1	1	0	2	1
Баривчлах ялаар бүгд		0	0	0	0	0
Хорих ял оногдуулсан бүгд хүн		10	7	9	7	7
Хорих ял оногдуулсан бүгд эмэгтэй хүн		8	5	4	6	5

Үүнээс	Хорих ялыг биечлэн эдлүүлэх бүгд	6	0	3	1	1	
	Тэнссэн	3	7	4	2	5	
	Тогтоол биелүүлэхийг хойшлуулсан. /Эрүүгийн хуулийн 62,63-р зүйл/ Үүнээс	Насанд хүрээгүй этгээд	0	0	0	0	0
		Жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг	1	0	1	4	1
Ял шийтгүүлэгсдийн нас	14-15	0	0	0	0	0	
	16-17	0	0	0	0	0	
	18-29	3	5	7	5	2	
	30-34	2	2	1	1	4	
	35-аас дээш	6	1	1	3	2	
Боловсрол	Дээд	0	2	1	1	1	
	Техникийн болон мэргэжлийн анхан шатны	0	0	0	0	0	
	Тусгай мэргэжлийн дунд	3	0	1	1	1	
	Бүрэн дунд	7	4	5	4	4	
	Суурь	1	2	2	1	1	
	Бага	0	0	0	2	1	
	Боловсролгүй	0	0	0	0	0	
Ял шийтгүүлэгсдийн эрхэлж байсан ажил, сургууль	Төрийн албан хаагч	0	0	0	0	1	
	Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан	0	0	0	0	0	
	Оюутан	0	0	1	0	0	
	Сурагч	0	0	0	0	0	
	Цэрэг	0	0	0	0	0	
	Малчин	0	0	0	0	0	
	Бусад	3	4	1	0	0	
	Эрхэлсэн ажил, сургуульгүй	8	4	7	9	7	
	Ялтан	0	0	0	0	0	
Иргэний харьяалал	Монгол Улсын иргэн	11	8	9	9	8	
	Гадаадын харьяат	0	0	0	0	0	
	Аль ч улсын иргэн биш	0	0	0	0	0	

Ял шийтгүүлэгчдийн 35 буюу 77.8 хувь нь эмэгтэй хүн байна. Оногдуулсан ялын төрлийг авч үзвэл 5 буюу 11.1 хувь нь албадан ажил хийлгэх ял, 40 буюу 88.9 хувь нь хорих оногдуулсан байна. Хорих ял оногдуулсан хүмүүсийн 12 буюу 30.0 хувь нь хорих ялыг биечлэн эдэлж, 21 буюу 52.5 хувь нь тэнсэж, 7

буюу 17.5 хувь нь тогтоол биелүүлэхийг хойшлуулсан байна. Насны ангиллын хувьд 22 буюу 48.9 хувь нь 18-29 насны иргэд, 10 буюу 22.2 хувь нь 30-34 насны иргэд, 13 буюу 28.9 хувь нь 35-аас дээш насны иргэд тус тус эзэлж байна. Боловсролын хувьд 5 буюу 11.1 хувь нь дээд боловсролтой, 6 буюу 13.3 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 24 буюу 53.3 хувь нь бүрэн дунд боловсролтой, 7 буюу 15.6 хувь нь суурь боловсролтой, 3 буюу 6.7 хувь нь бага боловсролтой иргэд байна. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд 1 буюу 2.2 хувь нь төрийн албан хаагч, 1 буюу 2.2 хувь нь оюутан, 8 буюу 17.8 хувь нь бусад, 35 буюу 77.8 хувь нь эрхэлсэн ажилгүй иргэд байна.

Бэлгийн мөлжлөг гэмт хэрэг 2017 оноос 2022 оны бүтэн жилд 8 хэрэг хянан шийдвэрлэж 25 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 17 хүнд ял шийтгэл оногдуулжээ.

Хүснэгт 10. Бэлгийн мөлжлөгийн хэрэг, шүүхээр шийдвэрлэгдсэн байдал /2017-2022 он/

Эрүүгийн хууль /2015 он/-н 12.3 дугаар зүйл Бэлгийн мөлжлөг		2017 ⁵⁶ ОН	2018 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН	2022 ОН	
Шийдвэрлэсэн бүгд хэрэг		0	1	0	0	2	5	
Ял шийтгүүлсэн бүгд хүн		0	1	0	0	3	13	
Үүнээс	Урьд ял шийтгүүлсэн хүн	0	0	0	0	1	4	
	Үүнээс							
	2 дахь удаагаа	0	0	0	0	1	2	
	3 ба түүнээс дээш	0	0	0	0	0	2	
Үүнээс	Бүлэглэж үйлдсэн	0	0	0	0	2	0	
	Согтуугаар үйлдсэн	0	0	0	0	0	0	
	Эмэгтэй хүн	0	1	0	0	0	7	
	Насанд хүрээгүй этгээд	0	0	0	0	0	0	
	Үүнээс эмэгтэй	0	0	0	0	0	0	
Торгох ял		0	0	0	0	0	0	
Нийтэд тустай ажил хийлгэх ял		0	0	0	0	0	0	
Зорчих эрхийг хязгаарлах ял		0	0	0	0	0	0	
Хорих ял оногдуулсан бүгд хүн		0	1	0	0	3	13	
Хорих ял оногдуулсан бүгд эмэгтэй хүн		0	1	0	0	3	7	
Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх		0	0	0	0	1	7	
Үүнээс	Хорих ялыг биечлэн эдлүүлэх бүгд	0	1	0	0	3	13	
	Тогтоол биелүүлэхийг хойшлуулсан	Насанд хүрээгүй этгээд	0	0	0	0	0	0
		Жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг	0	0	0	0	0	0

⁵⁶ 2015 оны Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 12.3 дугаар зүйлээр эцэслэн шийдвэрлэсэн хэрэг байхгүй. 2017 оны тайлан мэдээгээр 1 хэргийн үлдэгдэлтэй гарсан байна.

Шүүхээс оногдуулсан ял эдлэх дэглэм	Нээлттэй	0	1	0	0	3	13
	Хаалттай	0	0	0	0	0	0
Ял шийтгүүлэгсдийн нас	14-15	0	0	0	0	0	0
	16-17	0	0	0	0	0	0
	18-29	0	0	0	0	1	5
	30-34	0	0	0	0	1	4
	35-аас дээш	0	0	1	0	1	4
Боловсрол	Дээд	0	0	0	0	1	2
	Техникийн болон мэргэжлийн анхан шатны	0	0	0	0	0	0
	Тусгай мэргэжлийн дунд	0	0	0	0	0	0
	Бүрэн дунд	0	0	0	0	0	7
	Суурь	0	1	0	0	0	4
	Бага	0	0	0	0	2	0
	Боловсролгүй	0	0	0	0	0	0
Ял шийтгүүлэгсдийн эрхэлж байсан ажил, сургууль	Төрийн албан хаагч	0	0	0	0	0	0
	Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан	0	0	0	0	0	0
	Оюутан	0	0	0	0	0	0
	Сурагч	0	0	0	0	0	0
	Цэрэг	0	0	0	0	0	0
	Малчин	0	0	0	0	0	0
	Бусад	0	0	0	0	0	2
	Эрхэлсэн ажил, сургуульгүй	0	1	0	0	3	11
	Ялтан	0	0	0	0	0	0
Иргэний харьяалал	Монгол Улсын иргэн	0	1	0	0	3	13
	Гадаадын харьяат	0	0	0	0	0	0
	Аль ч улсын иргэн биш	0	0	0	0	0	0

Ял шийтгүүлэгчдийн 8 буюу 44.4 хувь нь эмэгтэй хүн байна. Оногдуулсан ялын төрлийг авч үзвэл 100 хувь хорих ял оногдуулж, бүгд хорих ялыг биечлэн эдлүүлэхээр заасан байна. Мөн 8 хүнд нэмж хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх албадлагын арга хэмжээ авсан байна. Ял шийтгүүлэгчдийн 6 буюу 35.3 хувь нь 18-29 насны, 5 буюу 29.4 хувь нь 30-34 насны, 6 буюу 35.3 хувь нь 35-аас

дээш насны иргэд тус тус эзэлж байна. Боловсролын хувьд 2 буюу 11.7 хувь нь бусад, 15 буюу 88.3 хувь нь эрхэлсэн ажил төрөлгүй иргэн байна.

Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 2020-2022 оны бүтэн жилд 20 хэрэг хянан шийдвэрлэж 32 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 11 хүнд ял шийтгэл оногдуулж, 21 хүн хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх албадлагын арга хэмжээг хэрэглэсэн байна.

Хүснэгт 11. Биеэ үнэлэхийг зохион байгуулах хэрэг, шүүхээр шийдвэрлэгдсэн байдал /2020-2022 он/

Эрүүгийн хууль /2015 он/-ийн 12.6 дугаар зүйл Биеэ үнэлэхийг зохион байгуулах		2020 он	2021 он	2022 он
Хянан шийдвэрлэсэн хэрэг		0	4	16
Ял шийтгүүлсэн хүн		0	3	8
Үүнээс	Эмэгтэй	0	0	2
	Өсвөр насны хүн	0	0	0
Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх		0	5	16
Урьд нь ял шийтгүүлсэн хүн-бүгд		0	1	0
Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал	Эмэгтэй	0	0	0
	Өсвөр насны хүн	0	0	0
	эмэгтэй	0	0	0
	2 дахь удаа	0	1	0
	3, түүнээс дээш	0	0	0
	Урьд гэм буруутайд тооцогдож байсан	0	0	0
	Бүлэглэж үйлдсэн	0	0	0
	Согтуурсан үедээ	0	0	0
Торгох ялаар шийтгүүлсэн хүн-бүгд		0	0	0
Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүн-бүгд		0	0	0
Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн хүн-бүгд		0	0	7
Хорих ял шийтгүүлсэн хүн-бүгд		0	3	1
Хорих ялыг биечлэн эдлүүлэх -бүгд		0	3	1
Тогтоол биелүүлэхийг хойшлуулсан	Өсвөр насны хүн	0	0	0
	Жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх хүүхэдтэй эх, ганц бие эцэг	0	0	0

Ял шийтгүүлэгчид, насны ангиллаар	14-15	0	0	0	
	16-17	0	0	0	
	18-21	0	0	0	
	22-29	0	1	2	
	30-34	0	2	1	
	35-аас дээш	0	0	5	
	55-аас дээш насны эмэгтэй	0	0	0	
	60-аас дээш насны эрэгтэй	0	0	0	
Ял шийтгүүлэгчид, боловсролын түвшнээр	Дээд	Доктор	0	0	0
		Магистр	0	0	0
		Бакалавр	0	0	2
	Техникийн болон мэргэжлийн		0	0	0
	Тусгай мэргэжлийн дунд		0	1	0
	Бүрэн дунд		0	2	5
	Суурь		0	0	1
	Бага		0	0	0
	Боловсролгүй		0	0	0
Ял шийтгүүлэгчид, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар	Улс төрийн албан тушаалтан		0	0	0
	Төрийн захиргааны албан хаагч		0	0	0
	Төрийн тусгай албан хаагч		0	0	0
	Төрийн үйлчилгээний албан хаагч		0	0	0
	Төрийн бус байгууллагын ажилтан		0	0	0
	Аж ахуйн нэгжийн албан тушаалтан		0	0	0
	Оюутан		0	0	0
	Сурагч		0	0	0
	Малчин		0	0	0
	Ажилгүй		0	1	4
	Ялтан		0	0	0
	Бусад		0	2	4
Иргэний харьяалал	Монгол Улсын иргэн		0	3	8
	Гадаадын харьяат		0	0	0
	Харьяалалгүй		0	0	0
	Тодорхойгүй		0	0	0

Ял шийтгүүлэгчдийн 7 буюу 63.6 хувь нь зорчих эрхийг хязгаарлах ялаар, 4 буюу 36.4 хувь нь хорих ял шийтгүүлсэн байна. 8 буюу 44.4 хувь нь эмэгтэй хүн байна. Насны ангиллын хувьд 3 буюу 27.3 хувь нь тус тус 22-29, 30-34 насны иргэд, 5 буюу 45.3 хувь нь 35-аас дээш насны иргэд тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирсон
хохилогчийн мэдээлэл /2018-2022 он/

Огноо		2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	Нийт	
Гэмт хэргийн улмаас хохирогч хүн-бүгд		3	10	35	2	5	55	
Эмэгтэй		3	10	35	2	5	55	
Хохирогч хүн, насны ангиллаар	Өсвөр насны хохирогч	0-4	0	1	0	0	0	1
		5-9	0	0	0	0	0	0
		10-14	0	1	0	0	0	6
		15-17	0	3	11	1	2	18
	18-21	3	2	6	2	3	16	
	22-24	0	3	9	0	0	12	
	25-29	0	0	7	1	0	8	
	30-34	0	0	1	0	0	1	
	35-39	0	0	1	0	0	1	

2018-2022 оны бүтэн жилд хянан шийдвэрлэсэн ХХГХ-т нийт 55 хүн хохирогчоор тогтоогдсон байна. 2017 оноос өмнөх хугацаанд шүүхийн статистикийн мэдээ гаргах маягтад гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн тоон мэдээлэл зүйл анги тус бүрээр гардаггүй байсан байна.

Насны ангиллаар авч үзвэл 18 буюу 32.7 хувь нь насанд хүрээгүй хүүхэд энэ гэмт хэргийн хохирогчоор тогтоогдсон байна. Насанд хүрсэн хүмүүсийн насны ангиллыг авч үзвэл 15 буюу 27.3 хувь нь 18-21 насны иргэд, 12 буюу 21.8 хувь нь 22-24 насны иргэн, 8 буюу 14.5 хувь нь 25-29 насны иргэн, 1 буюу 1.8 хувь нь тус тус 30-34, 35-39 насны иргэн эзэлж байна.

ХХГХ-т хохирогчоор тогтоогдсон иргэдийн 32.7 хувь нь насанд хүрээгүй хүн хохирогчоор тогтоогдсон нь 3 хүн тутмын нэг нь насанд хүрээгүй хүүхэд гэж үзэхээр байна. Мөн ХХГХ-т эмэгтэй хүн бэлгийн мөлжлөгөөр хохирч байна. Харин албадан хөдөлмөрлүүлсэн болон эрэгтэй хохирогчийн талаарх гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

ДҮГНЭЛТ

Хүснэгт 13. Үнэлгээний хураангуй

№	Үнэлэх бүлэг	Зорилгод хүрсэн байдал	Практикт нийцэж байгаа байдал	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
Нэг дүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл (конвенц ба үндэсний хууль тогтоомжийн нийцэл)				
1	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	Тийм	Тийм	Үгүй
	2 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомж	Тийм	Тийм	Үгүй
	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	Тийм	Тийм	Үгүй
	4 дүгээр зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зарчим	Тийм	Тийм	Үгүй
Хоёрдугаар бүлэг. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зохион байгуулалт				
2	5 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх	Тийм	Үгүй	Үгүй
	6 дугаар зүйл. Дэд зөвлөл, түүний бүрэн эрх	Тийм	Үгүй	Үгүй
	7 дугаар зүйл. Хуулийн этгээдийн үүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
	8 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг	Тийм	Тийм	Тийм
Гуравдугаар бүлэг. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны арга хэлбэр				
3	9 дүгээр зүйл. Хамгаалах байр	Тийм	Үгүй	Үгүй
	10 дугаар зүйл. Хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах	Тийм	Үгүй	Үгүй
	11 дүгээр зүйл. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамгаалах	Тийм	Үгүй	Үгүй
	12 дугаар зүйл. Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ	Тийм	Үгүй	Үгүй
	13 дугаар зүйл. Хохирогч хүүхдийг хамгаалах	Тийм	Үгүй	Үгүй
	14 дүгээр зүйл. Хүн худалдаалах талаар мэдээлэл өгсөн иргэнийг хамгаалах, урамшуулах	Тийм	Үгүй	Үгүй
	15 дугаар зүйл. Хохирол нөхөн төлүүлэх	Тийм	Үгүй	Үгүй
	16 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны санхүүжилт	Тийм	Үгүй	Үгүй
	Нийт/хувь	15/16	5/16	1/16
		93.8%	31.3%	6.3%

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг бүхэлд нь буюу 3 бүлэг 16 зүйлээр үнэлбэл **Зорилгод хүрсэн байдал нь 93.8 хувь, Практикт нийцэж буй байдал нь 31.3 хувь, Хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь 6.3 хувь** байна.

НҮБ-ын “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц 2000 онд батлагдаж, уг Конвенц болон түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд Монгол Улс 2008 онд нэгдэн орсон байна. Гэвч Монгол Улсын нэгдэн орсон тус конвенц болон протоколыг албан ёсоор Төрийн мэдээлэл сэтгүүл болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд нийтлээгүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж, иргэдийн мэдээлэл авах боломжийг хязгаарлаж байгаад анхаарах шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурал 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хуулийг баталж мөрдүүлж эхэлсэн. Тус хуульд өнөөдрийн хүртэл нийтдээ 14 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байдаг. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зорилго болон хүн худалдаалах гэмт хэргийн нэр томъёоны тайлбарын хувьд Конвенц болон Протоколд нийцсэн гэж үзсэн. Гэвч Нэгдсэн үндэстний байгууллагын конвенц, түүний нэмэлт протоколоор албан ёсоор хүн худалдаалах гэмт хэргийн **“зорилго, арга, үйлдэл”**-ийн шинжийг өөрчлөөгүй боловч дэлхийн улс орнуудын хувьд тус гэмт хэргийн “элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, хүлээн авсан, орогнуулсан” буюу тодорхой байршлаас шилжүүлсэн үйлдэл нь энэхүү гэмт хэргийн зайлшгүй байх шинж биш гэх үзэл давамгайлж байгааг харгалзан үзэх шаардлагатай. Мөн шүүхээс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг заавал улс, орон нутаг дамнуулан тээвэрлэсэн байх шаардлагагүй бөгөөд ямар нэг тээврийн хэрэгслээр эсхүл явганаар ч нэг байрлалаас нөгөө байрлалд шилжүүлсэн нь хүн худалдаалах гэмт хэрэгт тооцох үндэслэл болох талаар шүүхийн практик тогтооход цаашид анхаарах шаардлагатай.

Монгол Улсын хэмжээнд 2013-2023 онд шүүхээр хүн худалдаалах гэмт хэрэгт холбогдсон 30 маргааныг хянан шийдвэрлэснээс 59 хүнийг гэм буруутайд тооцож, ял шийтгэл ногдуулснаас хуулийн этгээд тус гэмт хэргийг үйлдсэн баримт бүртгэгдээгүй. Эдгээр хэргээс хууль тогтоомжийн тодорхойгүй, эргэлзээтэй байдал хэмээн шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлэн хөнгөрүүлэн зүйлчилсэн тохиолдлууд байгаа нь Конвенцын үүргээсээ ухарч байгааг харуулж байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн дээрх хэрэгт улс дамнуулан хүн худалдаалсан гэмт хэргийн тохиолдол бүртгэгдээгүй мөн тус гэмт хэргийн хохирогчид нь бүгд эмэгтэй хүйсийн хохирогчид бөгөөд давхар бэлгийн мөлжлөгөд өртсөн. Үүнээс үзвэл Монгол Улсад гарч буй хүн худалдаалах гэмт хэргийн дийлэнх нь бэлгийн мөлжлөгийн замаар үйлдэгдэж байх тул эдгээр

ижил төстэй гэмт хэргийг ялгаж хуульчлах хэрэгцээ шаардлага тулгарсан байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд тус гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн байгууллагын эрх үүргийг тусгайлан хуульчилж өгснийг энэхүү судалгаагаар нэг бүрчлэн хэрэгжилтийг үнэлж судалсан. Монгол Улсын Засгийн газрын хувьд 2017 онд тус гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор Үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлсэн боловч энэ талаарх төрийн захиргааны албан хаагчдын мэдлэг, мэдээлэл хангалтгүй байсан нь тус хөтөлбөр бүрэн зорилгодоо хүрээгүйг илтгэж байна. Мөн хуулиар тусгайлан журам батлах эрх олгосон субъектүүд тэдгээр журмыг өнөөдрийн байдлаар батлаагүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байдлыг бий болгосон байна. Тухайлбал, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд хамаарах “Хохирогчийн нэр төр аюулгүй байдлыг хангах журам”, “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, мөн Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хувьд “Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам” зэргийг батлаагүй.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд хохирогчийг хэрхэн тогтоох, хохирогчид хэрхэн туслалцаа үзүүлэх асуудлыг шийдвэрлэх нь чухал юм. Гэтэл Монгол Улсын хувьд хохирогч гэх ойлголтыг хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах хуулиар ялгаатай байдлаар хуульчилсан байгаа нь хууль хэрэглээний хувьд төөрөгдөл үүсгэсэн зохицуулалт болсон. Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргийн онцлогоос хамааран тус гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байр нь гадаад улс болон дотоодод стандартын дагуу байгуулагдсан байх шаардлагатай.

Энэхүү хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлангаар Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хамгаалах байрны хувьд Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” стандартаар зохицуулж байгаа боловч тус стандартад нийцсэн хамгаалах байр байхгүй, хилийн чанадад хэрхэн энэ асуудлыг шийдэх талаар төсвийн асуудлыг шийдвэрлээгүй. Одоогийн байдлаар тус гэмт хэргийн хохирогчдыг тусгайлсан, дээрх стандартад нийцсэн хамгаалах байранд бус бусад гэмт хэргийн хохирогчдыг түр хамгаалах байранд байрлуулж, үйлчилгээ үзүүлж буй нь Монгол Улсын нэгдэн орсон конвенцын үүргээ биелүүлээгүй үйлдэл гэж үзэж болохоор байна.

Зарим хуулийн зохицуулалт, журмын заалтууд нь хоорондоо зөрчилдөх, хоорондын уялдаа холбоогүй заалтуудыг оруулснаас үүдэлтэйгээр бодит байдал дээр хэрэгжихгүй, давхардах зэрэг асуудал бий болдог. Тухайлбал, тус хуульд батлахаар зохицуулсан хүн, хуулийн этгээдийг урамшуулах журмын хувьд Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулсан ижил төстэй журам хэрэгжиж буйтай давхцалтай. Хохирогчийг ажлын байраар

хангах, мэргэжлийн сургалтад хамруулах тухай Хөдөлмөрийн сайдын 2015 оны 7 сарын 09-ний өдрийн А/135 дугаар тушаалын хувьд тус үйл ажиллагааг Тахарын албатай хамтран хэрэгжүүлэхээр заасан ч тус алба татан буугдсан тул хэрэгжих боломжгүй. Эрүүл мэндийн сайдын батлахаар зохицуулсан журмын хувьд Эрүүл мэндийн тухай хуульд байхгүй нэр томъёо бүхий журам батлахаар зохицуулсан нь зөрчил үүсгэсэн.

Түүнчлэн Гэрч хохирогчийг хамгаалах тухай асуудлыг хууль зүйн туслалцааны тухай хууль, гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар давхардуулан өөр өөр байдлаар зохицуулсан нь эрх зүйн давхардсан зохицуулалтыг бий болгож хэм хэмжээний ерсөлдөөн үүсгэсэн.

Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллийн сан, хохирогчийг бүртгэсэн бүртгэлийн хувьд хангалтгүй байгаагаас хохирогчид туслалцаа үзүүлэхэд бэрхшээлтэй байна. Судалгаанаас үзэхэд тус гэмт хэргийн хохирогчийн мэдээллийн санг одоогоор зөвхөн цагдаагийн байгууллага ашиглаж байгаагаас бусад үүрэг хүлээсэн эрх бүхий байгууллага ашиглах боломжгүй мөн хохирогчид туслалцаа үзүүлэх анхан шатны байгууллага болох эрүүл мэндийн салбарын хувьд хүчирхийллийн хохирогчийн тоон мэдээллийг бүртгэдэг боловч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн тоон мэдээллийг нарийвчлан бүртгэдэггүй нь хохирогчдод тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Судалгаанаас үзэхэд зарим улс орнууд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчийн бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэж шилжүүлэх эсхүл хуульд тусгайлан заасан тохиолдолд мэдээллийг нь зөвшөөрөл авалгүйгээр шилжүүлэх зэрэг зохицуулалтыг хуульчилсан сайн туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай.

Дээрх судалгаанаас үзэхэд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хувьд төрийн холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн мэдлэг мэдээлэл хангалтгүй, чиг үүрэг хэрэгжүүлэх байгууллагын ажилтнуудын тайлбараас үзвэл хуулийн хэрэгжилтийг хангалттай түвшинд зохион байгуулдаггүй байна. Харин тус ажлын дийлэнх хувийг төрийн бус байгууллагууд гадны төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлж, таслан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдүүлэг өгсөн гэрч, бодит мэдээлэл өгсөн иргэний аюулгүй байдлыг хангах, иргэдээс төлбөртэй мэдээлэл авах талаар тусгаж, үүнтэй холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 01 сарын 11-ний өдрийн А/08 дугаар “Урамшуулал олгох журам”-ыг баталсан ч тус журам хэрэгжээгүй, урамшууллын хэмжээ хэт бага, иргэд төдийлэн мэддэггүй зэргээр практикт огт хэрэгжээгүй байна.

Мөн хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Дэд зөвлөл нь хуулиар олгосон бүрэн эрхийн 50 хүрэхгүй хувийг хэрэгжүүлж ажилладаг. Шалтгаан нь тус бүрэн эрхийг хэрэгжүүлэх, хянах, зөвлөх эрх мэдэл бүхий Дэд зөвлөлийн гишүүд нь бие даасан төрийн байгууллагуудын төлөөлөл бөгөөд төрийн тогтолцооноос тусдаа институт учир өөрийн гаргаж байгаа шийдвэрээ хэрэгжүүлэх төсөвгүй, дэд бүтэцгүй, шийдвэр нь заавал биелэгдэх шинжгүй тул бусад байгууллагын тайлан мэдээг сонсох төдийгөөр хүн худалдаалахтай тэмцэх ажлыг хэрэгжүүлж байгаа нь тайлангуудаас харагдаж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго нь тус гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хохирогчид туслалцаа үзүүлэх гэсэн үндсэн хэсгээс бүрдэнэ. Дээрх хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээгээр гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн байгууллагуудын хэрэгжүүлж буй арга хэмжээ, чиг үүрэг нь хангалтгүй түвшинд үнэлэгдсэн бөгөөд хуулиар тусгайлан журмаар зохицуулахаар заасан журмыг батлаагүй нь хууль практикт хэрэгжих боломжгүй байдлыг бий болгосон. Түүнчлэн хууль хоорондын уялдаа холбоо, хийдлийг арилгаагүйгээс хоорондоо өрсөлдөх хэм хэмжээг бий болгох, хуулиар олгоогүй эрх хэмжээг журмаар зохицуулсан зэрэг нөхцөл байдал бий болсон. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд мэдээлэл өгөх ажил хангалтгүй, Засгийн газрын зүгээс үндэсний хөтөлбөр зарласнаас хойш нийтийг хамарсан ажил зогсонги байдалд орсон байна. Иймд тус хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд энэхүү хуулийн зохицуулалт нь бүрэн хэрэгжээгүй, практикт нийцээгүй байна.

Дээрх дүгнэлттэй холбоотойгоор доорх зөвлөмжийг хүргүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Монгол Улсын нэгдэн орсон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц болон протоколыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-д заасны дагуу албан ёсоор орчуулж, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэхийг Улсын Их хурлын тамгын газарт мөн тус хуулийн 45 дугаар зүйлийн 45.3-д заасны дагуу Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хандах;
2. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх заалтын дагуу Монгол Улсын Дээд шүүх нь Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах эрхтэй тул Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийн зүгээс Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн “Хүн худалдаалах” гэмт хэрэгтэй холбоотой “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг заавал улс, орон нутаг дамнуулан тээвэрлэсэн байх шаардлагагүй бөгөөд ямар нэг тээврийн хэрэгслээр эсхүл явганаар ч нэг байрлалаас нөгөө байрлалд шилжүүлсэн нь хүн худалдаалах гэмт хэрэгт тооцох үндэслэл болох мөн гадаад улс орнуудад хүн худалдаалах гэмт хэргийн заавал байх шинжээр зохицуулсан нэг цэгээс нөгөө цэгт шилжүүлсэн байх үйлдэл нь заавал байх шинж биш болох” талаар албан ёсны тайлбар гаргах саналыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимд хүргүүлэх;
3. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрчийг” гэсний дараа “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан хохирогчийг” гэж нэмэх.
4. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд хүн худалдаалах асуудлаар мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах чиг үүргээ хэрэгжүүлж мэдээллийн сан бий болгох. Ингэхдээ одоогийн байдлаар Цагдаагийн ерөнхий газрын дотооддоо ашиглаж буй мэдээллийн санд түшиглэн, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд оролцогч байгууллагууд болох прокурор, эрүүл мэндийн байгууллага, шүүх, боловсролын байгууллага, төрийн бус байгууллагууд харилцан мэдээлэл солилцох боломжтой, хүртээмжтэй, хэрэглэгдэхүйц байдлаар Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д зааснаар тухайн мэдээллийн эзний зөвшөөрлөөр авч ашиглах байдлаар зохицуулах;

5. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3-д “Улсын ерөнхий прокурортой хамтран хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам батлах” гэж заасны дагуу тухайн журмыг батлан гаргах;
6. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д заасан “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг батлах” гэж заасан журмыг шинээр батлагдах хүртэл Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/351 дугаар тушаалын “Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:” гэсний “5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийг гэсний дараа Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг гэж нэмэх” гэсэн байдлаар нэмэлт оруулж тухайн журмын үйлчлэлд хамруулах;
7. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4-д “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг урамшуулах” журмыг Хууль зүйн сайдын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/08 дугаар тушаалаар баталсан бөгөөд тус журамд заасан урамшууллын хэмжээ аж ахуйн нэгж байгууллагад 500,000 төгрөг, иргэн, албан тушаалтанд 300,000 төгрөг байгааг эргэн харж, урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх саналыг Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийн зүгээс Хууль зүй, дотоод хэргийн сайдад уламжлах;
8. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан хамгаалах байрыг дотоодод болон гадаад улсад байгуулах төсвийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад тусгуулах саналыг Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийн зүгээс Хууль зүй, дотоод хэргийн сайдад уламжлах. Ийнхүү хамгаалах байрыг байгуулах тохиолдолд Стандартчилал, хэмжил зүйн газрын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн С/07 дугаар тушаалаар батлагдсан “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6040:2019 стандарт, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 58 дугаар тогтоолоор баталсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6418:2013 стандартуудад тус тус нийцүүлэх.
9. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/73 дугаар тушаалаар батлагдсан “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”-ын үйлчлэлд хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө,

- ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хамруулах үүднээс Стандартчилал, хэмжил зүйн газрын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн С/07 дугаар тушаалаар батлагдсан “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6040:2019 стандартын 4.2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн ...” гэсний дараа “хүн худалдаалахын” гэж нэмэлт оруулах;
10. Гадаад харилцааны сайдын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/91 тоот тушаалаар батлагдсан “Гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг, эх оронд нь буцаан авчрах үйлчилгээ үзүүлэх” журмын хэрэгжилтийг хангах үүднээс Монголчууд ихээр амьдарч байгаа, түүнчлэн хүн худалдаалахын хохирогч болох магадлал өндөр гадаадын орнуудын дипломат болон консулын газарт холбогдох стандартад нийцсэн хамгаалах байр байгуулах төсвийг батлуулах талаар Дэд зөвлөлийн зүгээс Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Гадаад хэргийн сайдад санал хүргүүлэх;
 11. Хөдөлмөрийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/135 дугаар тушаалаар батлагдсан “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг болон 3 дугаар зүйлийн 3.6-д заасан “Тахарын алба” нь татан буугдсан тул тус албаны хэрэгжүүлэх чиг үүргийг төрийн аль байгууллагад шилжүүлэх талаар Дэд зөвлөлийн зүгээс санал боловсруулж, дээрх журмын холбогдох хэсэгт өөрчлөлт оруулах саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад уламжлах;
 12. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасны дагуу Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага “Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ хийх тухай” журам батлах үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж буй “эрүүл мэндийн нөхөн сэргээх” гэсэн нэр томъёог холбогдох хуульд нийцүүлэн өөрчлөх, улмаар тус журмыг баталж хэрэгжүүлэх тал дээр Дэд зөвлөлийн зүгээс эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах. Цаашид хүн худалдаалахын хохирогчид нөхөн сэргээх эмчилгээг хийх ажлыг тус журмын дагуу зохион байгуулж, холбогдох бүртгэлийг хөтлөх;
 13. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагийн хохирогчдыг бүртгэх бүртгэлд “хүн худалдаалахын хохирогч” гэсэн нарийвчилсан бүртгэл нэмж тусгах талаар Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад Дэд зөвлөл санал хүргүүлэх;

14. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, урьдчилан сэргийлэх, танин мэдэх, таслан зогсооход чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулж нэмэх талаар арга хэмжээ авч ажиллах;
15. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.10-д заасан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг хүлээсэн төрийн байгууллага, алба хаагчид, мэргэжилтнүүдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа явуулж мэдлэг олгох, иргэдэд чиглэсэн тус гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон нөлөөлөл, сурталчилгаа, сургалт зохион байгуулах чиг үүргээ хэрэгжүүлэх. Тухайн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.7 дахь заалтад заасны дагуу жил жилийн төсөвт үе шаттай тусгуулах санал боловсруулж ажиллах;
16. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлд “Дэд зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүрэгт туслах үүрэг бүхий хүн худалдаалахтай тэмцэх чиглэлд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оруулсан Салбар дундын баг ажиллаж болно” гэсэн агуулга бүхий 6.7 дахь хэсэг нэмэх. Тухайн салбар дундын багийн үйл ажиллагааны зардлыг Дэд зөвлөлийн үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлэх байдлаар зохицуулалт хийх.
17. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.7-д заасан хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгуулах талаар санал боловсруулах гэсэн бүрэн эрхийнхээ хүрээнд тус судалгааны үр дүнгээр төсөв, санхүүжилт бага учраас шийдэгдэх боломжгүй гэж дүгнэгдсэн асуудлуудыг шийдвэрлэх төсвийг улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авч ажиллах.
18. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-д “Хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг Засгийн газар батална” гэж заасны “Засгийн газар” гэснийг “Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж өөрчлөх. Үүнтэй холбоотой тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д “Засгийн газрын шийдвэрээр хамгаалах байрны үйл ажиллагааг төрийн бус байгууллагад хариуцуулж болно” гэсний “Засгийн газрын” гэдгийг “Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэж өөрчлөх.
19. Хүн худалдаалах гэмт хэргийн талаар зөвлөгөө мэдээлэл өгөх төвийг байгуулах;
20. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны шатанд шийдүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн

сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтын 2.1.6 дахь заалт болгон нэмэлтээр “Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл (Хүн худалдаалах) гэж нэмэх саналыг Дэд зөвлөлийн зүгээс Хууль зүй дотоод хэргийн сайд болон Эрүүл мэндийн сайдад уламжлах;

21. Мөрдөн байцаалтын болон прокурорын хяналтын шат, шүүхийн шатанд гарсан хохирол төлбөрийг нэхэмжлэх, холбогдох баримтыг хэрэгт нотлох баримтаар тооцуулж, шүүх түүнийг үнэлэх талаар хуулийн зохицуулалтын хэмжээнд шийдвэрлэх боломж байгаа хэдий ч практикт түүнийг хэрэгжүүлэхгүй байгаа байдлыг шийдвэрлэх, нэг мөр ойлголттой болох үүднээс Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж ажиллах;
22. Хүн худалдаалахтай тэмцэх ажлыг нэгдмэл нэг цогц байдлаар хэрэгжүүлснээр үр дүнд хүрэх тул тухайн хуульд заасан батлагдаагүй журмуудыг батлах, батлагдсан журмуудын зөрчил, давхардлыг арилгахын тулд хүн худалдаалахтай тэмцэх чиглэлийн оролцогч, хэрэгжүүлэгч төрийн болон төрийн бус бүх байгууллагуудын төлөөллийг бүрэн хамруулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж ажиллуулах.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль, тогтоомж:

1. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 2013 он.
2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019 он.
3. Донорын тухай хууль, 2018 он.
4. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2019 он.
5. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012 он.
6. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он.
7. Хууль зүйн туслалцааны тухай хууль, 2022 он.
8. Өрийн удирдлагын тухай хууль, 2015 он.
9. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010 он.
10. Шилэн дансны тухай хууль, 2014 он.
11. Эрүүгийн хууль, 2015 он.
12. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он.

Журам, стандарт:

1. Гадаад харилцааны сайд, Хилийн чанадад хүн худалдаалах болон хүнд, онц хүнд гэмт хэргийн хохирогч болсон иргэнийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах, үйлчилгээ үзүүлэх тухай журам, А/91 дүгээр тушаал, 2013 он.
2. Монгол Улсын Засгийн газар, Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм, 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, 2018 он.
3. Монгол Улсын Засгийн газар, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам, 220 дугаар тогтоолын хавсралт, 2020 он.
4. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам, А/49 дүгээр тушаал, 2017 он.
5. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд нар, Гадаадын иргэнд Монгол Улсын хүүхдийг үрчлүүлэх журам, 100/32 дүгээр тушаал, 2001 он.
6. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нар, Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, 01 дугаар тогтоол, 2021 он.
7. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам, А/351 дүгээр тушаал, 2022 он.
8. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд нар, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журам, А/183, А/112 дугаар тушаал, 2023 он.
9. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд үр бүтээлтэй, идэвх санаачилгатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд "Урамшуулал олгох журам", А/08 дугаар тушаал, 2016 он.
10. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Ажлын байраар хангах мэргэжлийн сургалтад хамруулах журам, А/135 тоот тушаалын хавсралт, 2015 он.
11. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам, А/116 дугаар тушаал, 2017 он.
12. Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам, 39 дүгээр тушаал, 2022 он.
13. Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэн, Эшлэл хийх, эх сурвалжийг заах, ном зүйн бичилт хийх стандарт, А/11 тоот захирлын тушаал, 2023 он.

14. Эрүүл мэндийн сайд, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам, А/462 дугаар тушаал, 2013 он.
15. Хүн худалдаалахын хор уршиг, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тайлбарлан таниулах талаар ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөр, стандарт
16. Монгол Улсын Стандарт, MNS 5481-5:2005, Айдас эмгэгийн оношилгоо, эмчилгээ, 2005 он.
17. Монгол Улсын Стандарт, MNS 5481-6:2005, Биеийн хэлбэрийн өвчний оношилгоо, эмчилгээ, 2005 он.
18. Монгол Улсын Стандарт, MNS 5929:2008, Уй гашуу тохиолдох үеийн сэтгэлзүйн оношилгоо, 2008 он.
19. Монгол Улсын Стандарт, MNS 5935:2008, Өөрийгөө сургах дасгал /тайвшруулах буюу булчин сулруулах/, 2008 он.
20. Монгол Улсын Стандарт, MNS 6418:2013, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих, нийтлэг шаардлага, 2013 он.

Олон улсын эрх зүйн эх сурвалж:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн конвенцын нэмэлт болох Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол, 2002 он.
2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага, Хүн худалдаалахтай тэмцэх жишиг хууль /Model Law against Trafficking in Persons/, 1990 он.
3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага, Хүн худалдаалахын эсрэг жишиг хэм хэмжээнүүд /Model legislative Provisions against trafficking in persons/, 2020 он.
4. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх 2022 оны дэлхийн тайлан /Global report on trafficking in persons 2022/, 2022он.
5. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, 2000 он.
6. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх тухай протокол, 2000 он.

Судалгааны тайлан:

1. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа 2021 он
2. Монгол Улс дахь Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа 2022 он
3. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал 2021 он
4. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах талаарх олон улсын туршлага
5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх судалгааны тайлан 2017 он
6. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, түүнтэй тэмцэх асуудал
7. Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ 2022 он
8. Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа 2022 он
9. Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал
10. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээний удирдамж ямар байх вэ? Судалгааны тайлан 2022 он
11. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа 2017 он
12. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ
13. Хүний эрх ба сексийн үйлчилгээг хуулиар зөвшөөрөхийн ач холбогдол: Монгол Улс Невада загварын сонгох талаар 2021 он
14. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ 2022 он
15. “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн суурь судалгааны тайлан 2022 он
16. “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох, туслалцаа үзүүлэх, холбон зуучлах, үйлчилгээний үйл явцыг тодорхойлох нь” Судалгааны нэгдсэн тайлан 2022 он

17. Хүн худалдаалах Гэмт хэрэгтэй тэмцэхэд Шаардлагатай дата Мэдээллийг цуглуулах, Ашиглах өнөөгийн тогтолцоо, Түүнийг сайжруулах боломж 2022 он
18. Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны: Хүн худалдаалах гэмт хэргийн жишээн дээр 2016 он
19. Хүний эрх онол, арга зүйн сэтгүүл “Биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн талаарх олон нийтийн үзэл хандлага, тулгамдаж буй асуудал” 2020 он

Цахим эх сурвалж:

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://www.legalinfo.mn/>
2. Монгол Улсын Засгийн газрын нийтийн мэдээллийн нэгдсэн цахим сан, <https://mongolia.gov.mn/>
3. MCA Mongolia (mca-mongolia.gov.mn)
4. <https://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf>
5. <https://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf.p-13>.
6. <https://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf>
7. <https://mca-mongolia.gov.mn/news/press-news/trafficking>
8. [What Do the Tiers of the Trafficking in Persons Report Mean? \(state.gov\)](#)
9. 2022 ОНЫ ХҮН НАЙМААЛАХ АСУУДЛЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТУХАЙ ТАЙЛАН - Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам (usembassy.gov)

